

**ХЯНАН ШҮҮЖ, ДЭЛГЭРҮҮЛСЭН
ХУВИЛБАР**

ЯЛГАА САЛГАА

**Библийн чухал ухагдахуунуудын ялгааг
тайлбарлаж,
уншигч таны оюуны мэлмийн өмнө тавьж
буйг хүлээн авна уу.**

**ВИЛЛИЯМ МАКДОНАЛД
“ИТГЭГЧДИЙН БИБЛИЙН ТАЙЛБАР”
НОМЫН ЗОХИОГЧ**

Зохион байгуулагчид:

Христмас Вайлли Цуглаан

Индогуан цуглаан

“Үл Устах Үгс” сайн дурын үйлчлэл

Зөвлөх хороо:

Пак Сү Ён

Б. Пүрэвсүрэн

Ю. Гангаа-Эрдэнэ

Орчуулагчид:

Б. Шинэбаяр

Хянан засварласан:

Ю. Гангаа-Эрдэнэ

copyrights in the name of Christian Missions in
Many Lands, Inc. PO Box 13, Spring Lake, NJ
07762; USA

Зохиогчийн албан ёсны зөвшөөрлөөр Монгол
хэлнээ орчуулж, БНСУ-д 2024 онд хэвлэв.

Зохиогчийн бүх эрх хадгалагдана.

Тус хэвлэлийн аль ч хэсгийг зохиогчийн
зөвшөөрөлгүйгээр цахилгаан, механик, фото
хуулбар, хальсанд хуулах гэх мэт бусад ямар ч
утга болон хэлбэрт шилжүүлэн, хуулж, хэвлэж
үл болно.

Гарчиг

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ ЯЛГАА I:

АВРАЛ	1
1. АВРАЛЫН ГУРВАН ЦАГ	2
2. ЗӨВТГӨЛИЙГ ОЛОН ТАЛААС НЬ ӨГҮҮЛЭХҮЙ	8
3. МӨНХ АМИЙН ТУХАЙ	14
4. ЦАГААТГАЛЫГ ЗӨВ ОЙЛГОХУЙ	20

ХОЁРДУГААР ХЭСЭГ ЯЛГАА II:

ХРИСТЭЧ АМЬДРАЛ	27
5. БАЙР СУУРЬ БА АМЬДРАЛ	28
6. ХОЛБОО ХАМААРАЛ БА НӨХӨРЛӨЛ	37
7. ХОЁР ӨӨР УУЧЛАЛ – ШҮҮГЧ БА ЭЦЭГ	43
8. ХОЁР ХҮН	49
9. АРИУСГАЛЫН ТӨРЛҮҮД	57
10. АРИУН СҮНС – ДОТОР ОРШИХ, БАПТИСМ ХҮРТЭЭХ, ДҮҮРГЭХ	65
11. АВРАЛ БА ҮЙЛЧЛЭЛ	72
12. АГУУ БАЙДАЛ - ХҮН НЬ ҮҮ ЭСВЭЛ БАЙР СУУРЬ НЬ УУ?	79
13. АМИН ЧУХАЛ, ЧУХАЛ, АЧ ХОЛБОГДОЛ БАГА	84

ГУРАВДУГААР ХЭСЭГ ЯЛГАА III:

БУРХАНЫ АРГА ЗАМ	93
14. ДИСПЕНСАЦИ	94

15. БИБЛИ ДЭХ ГЭРЭЭНҮҮД-----	103
16. ИЗРАИЛЬ, ХАРЬ ҮНДЭСТНҮҮД, ЧУУЛГАН-----	110
17. ХУУЛЬ БА НИГҮҮЛСЭЛ-----	115
18. ЧУУЛГАН БА ХААНЧЛАЛ-----	120
ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ ЯЛГАА IV:	
ИРЭЭДҮЙН ҮЙЛ ЯВДЛУУД-----	126
19. ХРИСТИЙН ХОЁР ИРЭЛТ-----	127
20. ХРИСТИЙН ХОЁР ДАХЬ ИРЭЛТИЙН ҮЕ ШАТУУД-----	134
21. ЭЗЭНИЙ ӨДӨР, ХРИСТИЙН ӨДӨР, БУРХАНЫ ӨДӨР-----	143
22. ДАВХАР БИЕЛЭЛ-----	147
ТАВДУГААР ХЭСЭГ ЯЛГАА V:	
БУСАД-----	152
23. ДОЛООН ШҮҮЛТ-----	153
24. ҮХЭГСДИЙН ОРОН БА ТАМ-----	163
25. БИЧВЭРИЙН НУУЦУУД-----	170
26. ХРИСТИЙН АЛДАР (ЦОГ ЖАВХЛАН) -----	180
27. САЙНМЭДЭЭНИЙ НОМУУДЫН ЯЛГАА-----	191

ӨМНӨХ ҮГ

Библи судлалд, ялангуяа Шинэ гэрээг судлахад хэрэгтэй зарим үнэ цэнтэй түлхүүрийг танд атгуулах нь уг номын зорилго. Итгэгч бүр Библи судлагч болох *ёстой*. Итгэгч бүр Библи судлагч болж *чадна*. Гэхдээ ийм болохын тулд тусламж хэрэг болдог. Энэ ном танд хэрэгтэй тэр тусламжийг өгнө.

Үгийн тодорхойлолт чухал гэдгийг уншигч та номоос мэдэж авна. Библийн зарим үг ердийн толь бичигт байхгүй утга агуулдаг. Жишээлбэл, “нууц” (*mystery*) гэдэг үгийг авч үзэхэд, Библид хэрэглэсэн утга нь өдөр тутмын амьдралд хэрэглэдгээс өөр.

Алдаа мадаггүй онол сургаал (*doctrine*) чухал. Аливаа нэг ухагдахуун, сэдэв, ойлголтыг Бичээсээс тодруулахаар бол, сонгон авсан хэсгээ зөвөөр ойлгосон байж гэмээнэ, тухайн ухагдахуун, сэдэв, ойлголтын талаар Библийн дагуу алдаа мадаггүй мэдлэгтэй болж, гажууд онол сургаалд унахгүй.

Ялгаануудыг олж харах нь чухал. Сайнмэдээний нэг номд тэмдэглэсэн нь нөгөөгийнхтэйгөө адил *харагдаж* болох ч, хам сэдвийг нь судлахаар огт өөр зүйлсийг ярьж байх нь бий.

Зөвтгөл, ариусгал гэх мэт олон ухагдахуунд үе шатууд гэж бий. Жишээлбэл, Эзэний ирэлт үе шаттай. Үүнийг ойлгоогүйгээс төөрөгдөл үүсдэг.

Номын маань эхний хэвлэлийг уншсан ахан дүүс, Библи судлалдаа үлэмж тус авснаа нэгэн дуугаар хүлээн зөвшөөрсөн сэтгэгдлүүд ирүүлжээ. Тиймд бид өмнөх хувилбарыг нэмэн дэлгэрүүлсэн хувилбарыг гаргаж байна. Номын маань үр өгөөж улам арвижна хэмээн найднам.

- Номыг эрхлэн гаргагчид

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ ЯЛГАА I: АВРАЛ

НЭГ АВРАЛЫН ГУРВАН ЦАГ

Анх Христэд итгэхдээ ихэнх маань авралын ганц төрлийг сурдаг. Тэр нь *сүнсний* аврал. Дараа нь Библи судлахаараа энэ үзэлдээ аврал гэсэн үг болгоныг автоматаар тааруулах гэж оролддог. Гэвч “аврал” гэсэн үгийг Библи байнга нэг утгаар хэрэглэдэггүй болохыг яваандаа ойлгодог.

Тэгээд удалгүй, *аврал* гэдэг нь “чөлөөлөлт”, “аюулгүй байдал”, “эсэн мэнд байх” гэх мэт олон салаа утгатай ерөнхий үг гэдгийг ухаарна. Жишээ нь Филиппой 1:19 дээр Паул, энэ үгийг шоронгоос суллагдахтай холбож хэрэглэжээ:

Та нарын залбирал болон Есүс Христийн Сүнсний туслалцаагаар суллагдах болно гэдгээ би мэддэг. (Монгол орчуулгад хам сэдвээр нь “суллагдах” гэж орчуулсан нь сайн хэрэг.)

Филиппой 2:12 дээр *авралыг* бас өөр утгаар буюу Филиппойн чуулганд гарсан асуудлыг шийдэх шийдэл гэсэн утгаар хэрэглэсэн. Филиппойн чуулганд ноцтой хагарал гарчээ (Флп 2:14; 4:2). Ийм асуудлыг шийдэх шийдэл бол Эзэн Есүс Христийнх шиг бодолтой, даруу дөлгөөн, өөрийгөө хойш тавих хандлага юм гэж Паул сануулаад Филиппой 2:12 дээр ингэж бичжээ:

Иймээс хайртууд минь, та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг байхад ч биш, харин эдүгээ байхгүй байхад минь

бүр илүүгээр өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр гүйцээ.

Өөрөөр хэлбэл, “Би та нарт наад асуудлын чинь шийдлийг хэлж өгсөн шүү дээ. Одоо тэр шийдлийг айдас ба чичрэлээр хэрэгжүүл” гэсэн санаагаар ярьж байгаа юм.

Библийн гурван хэсэгт, живж үхэхээс амь гарсан тохиолдолд аврагдах гэдэг үгийг ашиглажээ:

Усан цэргүүд онгоцноос зугтахыг оролдож, хошуунаас зангуу авч хаях дүр үзүүлэн завийг тэнгист буулгав. Паул зуутын дарга ба цэргүүдэд “Хэрэв энэ хүмүүс онгоцон дээр үлдэхгүй бол та нар аврагдаж чадахгүй” гэв. (Үйл 27:30-31)

Итгэлээр Ноа, хараахан харагдаагүй байсан зүйлсийн талаар сэрэмжлүүлэл аваад гэр бүлийнхээ авралын төлөө бүхээгийг сүсэглэн бэлдсэн... (Евр 11:7а)

Тэрхүү сүнсээр Христ явж, шоронд байгаа сүнснүүдэд тунхаглажээ. Эдгээр сүнснүүд нь, урьд Ноагийн өдөр бүхээг баригдаж байх үед, Бурхан тэвчиж хүлээсээр байхад дуулгаваргүй байв. Тэрхүү бүхээгт цөөн буюу найман хүн байж, усаар дамжин аврагджээ. (1Пт 3:19-20)

Бурхан бүх хүний амьдралыг тогтоон барьж, харж хандаж байдгийн хувьд, ерөнхий утгаараа бүх хүний Аврагч ажээ.

Учир нь бид үүний төлөө зүдээж зүтгэн, тэмцдэг. Яагаад гэвэл бүх хүний, ялангуяа

итгэгчдийн Аврагч болох амьд Бурханд бид найддаг. (1Тм 4:10)

Гэхдээ бид аврал, аврагдах гэдэг үгсийн хэрэглээнээс, “нүглээс чөлөөлөгдөх”, “нүглээс аврагдах” гэсэн утгыг голчлон сонирхож байгаа. Энэ утга Шинэ гэрээнд түгээмэл.

Тэгвэл энэ төрлийн авралын өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн ялгааг мэдэж авъя:

Өнгөрсөн – Би нүглийн шийтгэлээс аврагдсан: зөвтгөл

Одоо – Би нүглийн хүчнээс аврагдсаар байдаг: ариусгал

Ирээдүй – Нүгэл надаас бүрмөсөн арилж, би нүглийн оршихуйгаас аврагдана: алдаршуулал (эсвэл цог жавхланд орох)

Өнгөрсөн цаг

Нүглийн шийтгэлээс аврагдсаныг дурдсан Библийн зарим эшлэлийг эш татъя:

Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус харин Бурханы бэлэг бөгөөд... (Еф 2:8)

[Бурхан] биднийг...аварч ариун дуудлагаар дуудсан юм (2Тм 1:9)

Тэр биднийг зөвт байдлын дотор хийсэн үйлсээр минь бус, харин өршөөлийнхөө дагуу шинэтгэлийн угаал ба Ариун Сүнсний шинэчлэлээр аварсан юм. (Тит 3:5)

Дээрх жишээнүүдэд “аврах” гэдэг үйл үгийг өнгөрсөн цаг дээр хэрэглэсэн байгааг анзаараарай. Гэхдээ өнгөрсөн цагаар өгүүлээгүй

атлаа нүглийн шийтгэлээс чөлөөлөгдөх тухай ярьсан эшлэлүүд бас бий. Тухайлбал:

Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүнд эс өгөгдөв. (Үйл 4:12)

Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. (Ром 10:9)

Тэгэхээр үйл үгийнх нь цагаар биш, эшлэлийнх нь агуулга, хам сэдвээр авралын аль цаг дээр ярьж буйг тодорхойлох нь. Сэдэв нь нүглийн ялаас бүрмөсөн мултлах тухай өгүүлж байвал авралын өнгөрсөн цаг гэсэн үг.

Одоо цаг

Би аврагдсан нь үнэн боловч бас өдөр бүр аврагдсаар байдаг нь ч үнэн. Би нүглийн ялаас аврагдсан. Харин нүглийн аюулт хөнөөлөөс өдөр бүр аврагддаг. Би нүглийн шийтгэлээс аврагдсан. Харин нүглийн хүч нөлөөнөөс өдөр бүр аврагддаг. Би загалмай дээрх Христийн ажлаар дамжуулан аврагдсан. Харин Бурханы баруун мутарт заларсан Түүний амь ба үйлчлэлээр өдөр бүр аврагддаг. Үүний тод жишээ Ром 5:10 дээр байна:

Хэрэв бид дайснууд байхдаа Хүүгийнх нь үхлээр Бурхантай эвлэрсэн юм бол, эвлэрсэн бид тэр тусмаа Түүний амиар аврагдах болно. (Ром 5:10)

Авралын одоо цаг нь ариусгалтай ижил утгатай. Ариусгал гэж нүгэл ба бузраас өөрийгөө татан авч, Бурханд тусгаарлагдах үйл явцыг хэлдэг. Еврей 7:25 дээр бичигдсэн зүйл нь үргэлжлэх үйл явц юм:

*Тиймээс Тэр Өөрөөр нь дамжуулан Бурханд ойртогсдыг бүрмөсөн **аварч** чадна. Тэр тэдний төлөө зуучлан залбирахын тулд үргэлж амьд байдаг.*

Авралын одоо цагийг өгүүлсэн өөр нэгэн хэсэг 1Коринт 1:18 дээр байна:

*Загалмайн тухай үг нь мөхөгсдийн хувьд мунхаглал бол **аврагдаж буй** бидний хувьд Бурханы хүч мөн.*

Ирээдүй цаг

Сүүлийнх нь авралын ирээдүй цаг. Бид Аврагчтайгаа нүүр нүүрээрээ уулзах цагт нүглийн оршихуйгаас *аврагдана*. Бие маань цог жавхлант бие болж, ямар ч нүгэлгүй болно. Авралын хамгийн сүүлийн энэ шатыг дараах эшлэлүүдэд тодорхой бичжээ:

*Урьд бидний итгэсэн үеэс **аврал** одоо бидэнд улам ойрхон байна. (Ром 13:11б)*

*Харин бид өдрийнх тул итгэл ба хайрын хуяг, **авралын найдварын** дуулга өмсөн, эрүүл ухаантай байцгаая. Учир нь Бурхан биднийг уур хилэнд бус, харин бидний Эзэн Есүс Христээр **аврал авахад** зориулжээ. (1Тс 5:8-9)*

*Христ...хоёр дахиа үзэгдэхдээ нүглийг үүрэхийн тулд бус, харин Өөрийг нь тэсэн ядан хүлээгсдийг **аврахын тулд** ирнэ. (Евр 9:28)*

*Эцсийн үед илчлэгдэхэд бэлэн буй **авралын төлөө** та нар итгэлээрээ Бурханы хүчээр хамгаалагдсан ажээ. (1Пт 1:5)*

Авралын гурван цаг гурвуулаа

Хэрэв тухайн эшлэл өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн алинд ч таарахгүй бол гурван цагийг гурвуулыг нь ярьсан хэсэг байж магадгүй. Хоёр жишээ энд оруулья:

*Тэр нь ард түмнээ нүглээс нь **аврах** тул чи Түүний нэрийг Есүс хэмээн дууд гэв. (Мт 1:21)*

*Түүн дор та нар ч бас үнэний үгийг буюу **авралынхаа** сайнмэдээг сонссон бөгөөд Түүнд итгэсэн мөн амласан Ариун Сүнсээр тамгалагдсан. (Еф 1:13)*

Тэгэхээр иймэрхүү тохиолдлуудад аль цаг вэ гэж гайхах хэрэггүй байх нь. Учир нь гурван цагийг гурвуулыг нь хамруулан өгүүлжээ.

ХОЁР

ЗӨВТГӨЛИЙГ ОЛОН ТАЛААС НЬ ӨГҮҮЛЭХҮЙ

Бид нигүүлслээр, итгэлээр, цусаар, хүчээр, үйлсээр, Бурханаар зөвтгөгдсөн гэж Шинэ гэрээнд өгүүлдэг. Толгой эргэмээр байна уу? Хэрэв зээ, зөвтгөлийн олон талыг ойлговол үүнд будилах зүйл гарахгүй. Библийн хэсэг *зөвтгөлийг аль талаас ярьж байгааг мэдвэл огтоос төөрөлдөхгүй.*

Зөвтгөлийг тайлбарлахуй

Юуны түрүүнд, зөвтгөл гэж юу болохыг тайлбарлая. “Зөвтгөх” гэж Библийн утгаар “зөвд тооцох” гэсэн үг. “Зөв болгох” гэсэн үг биш шүү. Харин “зөв гэж тунхаглах” гэсэн утгатай. Үнэндээ энэ нь хуулийн нэр томьёо бөгөөд шүүх танхимд хийдэг үйл ажиллагаа.

Бидний дотор зөв юм байхгүй. Зөвт байдал ч байхгүй. Харин Есүс Христийг Эзэн ба Аврагч болгон хүлээн авснаар, Христийн оронд биднийг тавьж Бурхан зөвд тооцдог. Бид “Христийн дотор” байгаа цагт Бурханы нүдэнд “зөв” гэж тооцогддог байна. Нүглүүдийн маань улмаас Голгота дээр хийгдсэн ажилд Бурхан сэтгэл ханасан учраас тэр. Христэд нүгэлтэн итгэснээр Бурханы зөвт байдлыг өмсөнө. “Нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө Тэрээр нүгэл

болгосны учир Түүний дотор бид Бурханы зөвт байдал болох юм.” (2Ко 5:21)

Эхэнд хэлсэнчлэн, зөвтгөлийг нигүүлслээр, итгэлээр, цусаар, хүчээр, үйлсээр, Бурханаар олж авдаг. Тэгвэл зөвтгөл яаж зургаан өөр замаар ирэх боломжтой вэ гэсэн асуулт гарах нь мэдээж. Үүнд хариулья.

Нигүүлслээр ирдэг зөвтгөл

Нэгдүгээрт: Зөвтгөл *нигүүлслээр* ирдэг. Ром 3:24 дээр “Христ Есүсийн золилтоор дамжин Бурханы нигүүлслээр үнэгүй зөвтгөгджээ” гэж бичсэн байна. Өөрөөр хэлбэл, зөвтгөгдөх ямар ч гавьяа хүнд байхгүй гэсэн үг. Зөвтгөлийг гавьяагаар, хичээл зүтгэлээр олж авах боломжгүй. Харин бэлэг мэт хүлээн авах ёстой. Хүн ямар ч гавьяа байгуулаагүй байхад, үнийг нь төлөөгүй байхад, Бурхан зөвтгөлийг үнэгүй бэлэглэдэг ажээ.

Итгэлээр ирдэг зөвтгөл

Хоёрдугаарт: Зөвтгөл *итгэлээр* ирдэг. “Тиймээс бид итгэлээр зөвтгөгдсөн тул Эзэн Есүс Христээрээ дамжин Бурхантай эвлэрсэн.” (Ром 5:1) Нүгэлт хүмүүн зөвтгөлийг авахын тулд гагцхүү Аврагчид итгэлээ тавих ёстой гэдгийг энд хэлж байна. “Би тамд унавал зохих ялтан” хэмээн өөрийнхөө үнэн байдлыг хүлээн зөвшөөрөөд, нүглийнх нь ялыг загалмай дээр эдэлсэн Аврагч Есүс Христийг хүлээн авах.

Зүйрлэж хэлбэл: Голгота дээр Христийн гүйцэтгэсэн авралын ажилд үндэслэн Бурхан зөвтгөлийг гэмт хүмүүст бэлэг болгон өгч байгаа бөгөөд бэлгийг тосон авах зам нь итгэл ажээ. Би сайн хүн болохоор эсвэл буян үйлдсэн болохоор гэж өөртөө бардалгүй, харин буруугаа ухааран гэмшээд, зөвтгөгч нь Бурхан юм гэж итгэснээр зөвтгөлийг авах юм.

Цусаар ирдэг зөвтгөл

Зөвтгөл *цусаар* ирдэг. “Тиймд эдүгээ Түүний цусаар зөвтгөгдсөн бид тэр тусмаа Түүгээр дамжин уур хилэнгээс ч аврагдах болно.” (Ром 5:9) Энэ нь зөвтгөлийг надад өгөхийн тулд төлсөн үнийг хэлж байна. Нүглүүдээс минь болж хуримтлагдсан их өрийг төлөх гэж нүгэлгүй Аврагч маань үнэт цусаа урсгасан байна. Зөвтгөлийг хөдөлшгүй баттай болгох гэж ямар өндөр үнэ төлснийг бүү мартаарай!

Хүчнээс ирдэг зөвтгөл

Зөвтгөл *хүчнээс* ирдэг гэж Библийн хаа нэгтэй шууд үгээр бичээгүй ч гэлээ, Ром 4:25 дээр ийм санаа агуулагддаг: “Бидний хилэнцээс болж Есүс тушаагдсан бөгөөд биднийг зөвтгөхийн төлөө амилсан юм.” Бидний зөвтгөлийг энд Христийн амилалтай холбожээ. Тэр нь ч зөв. “Христ амилуулагдаагүй бол та нарын итгэл хоосон агаад та нар ч нүгэлдээ байсаар байна.” (1Ко 15:17) Тэгэхээр бидний зөвтгөл Христийг үхэгсдээс амилуулсан тэр хүчтэй салшгүй

холбоотой аж. Ийм учир зөвтгөлийг хүчнээс ирдэг гэж хэлэх нь зүйд нийцнэ.

Үйлсээр ирдэг зөвтгөл

Бид *үйлсээр* зөвтгөгддөг. “Хүн зөвхөн итгэлээр бус, үйлсээр зөвтгөгддөгийг та нар харж байна.” (Иак 2:24) Олон хүн энэ хэсэг дээр будилдаг. Библи хоорондоо зөрүүтэй санаа өгүүлсэн гэж боддог. Хүн зөвхөн итгэлээр зөвтгөгдөнө гэж элч Паул андуурахын аргагүй тодорхой хэлсэн. Гэтэл Иаков “Тийм биш. Бид бас үйлсээр зөвтгөгдөнө” гэж *бичсэн юм шиг харагдаж байна*. Гэхдээ Иаков тэгж хэлээгүй юм. Зөвтгөл юун түрүүнд үйлсээр ирдэг гэж Иаков хэлээгүй. Эсвэл итгэл дээр үйлс нэмэгдэж байж зөвтгөгдөнө гэж ч хэлээгүй. Харин *сайн үйлс гаргадаг итгэлээр* зөвтгөгдөнө гэж хэлж байгаа юм.

“Надад итгэл байгаа” гэж хэлэвч түүнээс үр дүн гардаггүй бол яах вэ? Хэн ч түүнд итгэхгүй. Тийм итгэл үнэндээ үг болохоос итгэл биш (Иак 2:14-17). Жинхэнэ итгэл харагдахгүй ч гэлээ үйлсээрээ илэрдэг (Иак 2:18). Абрахам Эзэнд итгээд зөвтгөгдсөн (Эх 15:6) боловч хэдэн жилийн дараа, хүүгээ шатаалт тахил болгон өргөх гэж байхдаа үнэхээр итгэлтэйгээ нотолсон (Эх 22:9-14). Рахаб нь Израилийн туршуулуудыг нууж, зугтахад нь туслахдаа итгэл байгаагаа харуулсан (Иак 2:25). Тэгэхээр үйлсээр зөвтгөгдөнө гэж хэлбэл, итгэлийнх нь үнэн мөнийг харуулдаг үйлсийг ярьж байна гэж

ойлгох хэрэгтэй. Үйлс нь шалтгаан бус, *үр дагавар*, үндэс бус, *үр жимс* бөгөөд хүмүүсийн өмнө биднийг зөвтгөдөг ажээ.

Бурханаар ирдэг зөвтгөл

Бид *Бурханаар* зөвтгөгддөг: “Хэн Бурханы сонгосон хүмүүсийг буруутгах вэ? Бурхан бол зөвтгөгч Нэгэн мөн.” (Ром 8:33) Биднийг зөвт гэж тунхаглагч нь зөвхөн Бурхан билээ.

Дүгнэлт

Шинэ гэрээ бидний зөвтгөлийн талаар олон талаас өгүүлснийг дараах байдлаар тоймлон дүгнэж болох нь ээ:

Нигүүлсэл – Зөвтгөлийг хүртэх зохисгүй гэдгийг маань хэлж өгдөг.

Итгэл – Зөвтгөлийг хүлээн авах ёстойг маань хэлж өгдөг.

Цус – Аврагчийн үхэл биднийг худалдан авсныг хэлж өгдөг.

Хүч – Аврагчийн ажилд Бурхан сэтгэл ханасныг амилал харуулж байгааг хэлж өгдөг.

Үйлс – Үнэхээр итгэлээр аврагдсан бол, хүний нүдэнд харагдахуйц үйлс биднээс гарна гэсэн үг.

Бурхан – Есүст итгэгчийг Зөвтгөгч нь зөвхөн Бурхан гэдгийг хэлж өгдөг.

Зөвтгөлийн энэ бүх талыг шүлгийн мөртүүдээр тоймлон бичсэн байдгийг доор эш татан оруулья:

*Гайхамшигт жаргалангийн оронд
Гавьяагүй намайг урьж байна
Гагцхүү энэ Бурханы нигүүлсэл
Би нигүүлслээр зөвтгөгдсөн*

*Тогтоосон цагт Христ үхээж
Тооцохын аргагүй үнэт цусаа урсгаж
Тоо томигүй нүглийг минь угаав
Би цусаар зөвтгөгдсөн*

*Христ амилснаар баталгаа ирж
Хилэнцтэнүүдийн амыг таглав
Христийн амилал эргэлзээг арилгав
Би хүчээр зөвтгөгдсөн*

*Ариун Сүнс хөтлөн замчилснаар
Аврагч Христ миний төлөө үхсэн гэх
Агуу үнэнийг Бичээсээс ойлголоо
Би итгэлээр зөвтгөгдсөн*

*Христийнх гэдэгт минь эргэлзэгч
Хэнийх гэдгийг минь сонжигч
Хэнд ч би харуулах үйлстэй
Би үйлсээр зөвтгөгдсөн*

*Нигүүлсэл, итгэл, цус
Амиллын хүч, үйлс
Энэ бүхэн зөвхөн Түүний гавьяа
Би Бурханаар зөвтгөгдсөн*

-Хэлэн Н. Шай

ГУРАВ МӨНХ АМИЙН ТУХАЙ

Амьдралын чанар

Мөнх амь гэнгүүт мөнх амьдрах гэж бүү ойлгоорой. Аврагдсан, аврагдаагүй бүгд мөнх амьдарна. Гэхдээ зөвхөн итгэгчдэд мөнх амь бий. Тиймээс, мөнх амь гэж амьдралын *хугацаанаас* гадна, амьдралын *чанарыг* илэрхийлдэг. Мөнх амь бол Бурханы Өөрийнх нь амь бөгөөд Есүс Христийн биед бодитоор оршсон, Бурхантай салшгүй холбоотой амь юм:

Тэрхүү амь нь илчлэгдсэн, Эцэгтэй хамт байсан бөгөөд бидэнд илчлэгдсэн мөнх амийг бид үзсэн, мөн та нарт гэрчилж, тунхаглаж байна.
(1Ио 1:2; 1Ио 5:20-ийг мөн үз.)

Адам нүгэлгүй байхдаа ч мөнх амьтай байгаагүй. Нүгэл үйлдээгүй цагт дэлхий дээр байгалиараа амьдарсаар байх байсан ч Христтэй хамт диваажинд цог жавхланд орох найдваргүй амьдрах байлаа. Түүнээс гадна, нүгэл үйлдээд үхлийг амсах боломж хэвээр байх байсан. Үнэхээр ч тийм юм болсон. Адам, Эзэнийг Аврагчаа болгон итгэл найдвараа тавих хүртэл мөнх амийг болон түүнийг дагалддаг ерөөлүүдийг хүлээн аваагүй.

Библид мөнх амийг заримдаа одоо надад байгаа зүйл мэт, зарим тохиолдолд ирээдүйд авах өв, ирээдүйн найдвар мэт өгүүлдэг.

Одоо надад байгаа

Мөнх амь бол яг одоо цагт итгэгчдэд байгаа зүйл. Үүнийг тэд бэлэг болгон хүлээн авчихсан байгаа. Энэ бэлэг Эзэний амлалт (1Ио 2:25) бөгөөд Эзэний дотор байдаг (Иох 6:68; 1Ио 5:11). Мөнх амийг авах зам нь Эзэнд итгэх.

Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Хэн итгэнэ, тэр мөнх амьтай. (Иох 6:47; мөн Иох 3:15-16, 36; 5:24; 6:40; 1Тм 1:16-г үз.)

Эзэнд итгэх гэдгийг өөрөөр Эзэний өгөх уснаас уух (Иох 4:14), Эзэний мах цусыг уух (Иох 6:54), Эзэнийг дагах (Иох 10:27), Эзэнийг мэдэх (Иох 17:3) гэсэн үгнүүдээр илэрхийлсэн. Алуурчинд (1Ио 3:15) болон үл итгэгч нүгэлтнүүдэд мөнх амь байхгүй гэж Иохан хэлсэн байдаг.

Мөнх амь бол Эцэгээс ирдэг бэлэг (Ром 6:23; 1Ио 5:11)

Хүү бас мөнх амийг өгдөг.

Миний хоньд дууг минь сонсдог. Би тэднийг таньдаг бөгөөд тэд Намайг дагадаг юм. Би тэдэнд мөнх амийг өгнө. Тэд хэзээ ч мөхөхгүй бөгөөд тэднийг хэн ч гараас минь булаахгүй. (Иох 10:27-28; мөн Иох 17:2-ыг үз)

Ярь гэж Эцэгээс Христэд даалгасан бүхний зорилго нь мөнх амь өгөх (Иох 12:50).

Итгэсэн бүхэн мөнх амьтай (Үйл 13:48). Энэ бол үнэний нэг тал. Нөгөө тал нь гэвэл, итгээгүй бүхэн өөрсдийгөө мөнх аминд зохисгүй гэдгээ харуулдаг (Үйл 13:46). Энэ амь нигүүлслийн ноёрхлоос бий болдог (Ром 5:21) ба итгэгчид

мөнх амьтай гэдгээ Бурханы үгийн эрх мэдлээс мэдэж чадна.

Та нар мөнх амьтай гэдгээ мэдээсэй гэсэндээ би Бурханы Хүүгийн нэрд итгэдэг та нарт үүнийг бичлээ. (1Ио 5:13)

Мөнх амьтай хүмүүс үүнийгээ бодит амьдрал дээр өдөр бүр ажиллуулах ёстой.

Итгэлийн сайн тэмцлээр тэмц. Мөнх амийг зуур. Чи үүнд дуудагдсан бөгөөд олон гэрчийн өмнө сайн гэрчлэл хийсэн. (1Тм 6:12)

Ирээдүйн төлөө өөрсдөдөө сайн суурь тавьж эрдэнэсийг хурааснаараа жинхэнэ аминаас зуурах юм. (1Тм 6:19; мөн Иох 6:27-г үз)

Ирээдүйн найдвар

Библи мөнх амийг одоогийн маань өмч гэж өгүүлэхээс гадна, ирээдүй цаг дээр ярьсан байдаг:

Тэр нь мэхэлдэггүй Бурханы мөнх цагаас өмнө амласан мөнх амийн найдварт үндэслэсэн юм. (Тит 1:2)

...мөнх аминд аваачих Эзэн Есүс Христийн маань өршөөлийг хүлээн, Бурханы хайранд өөрсдийгөө сахь. (Иуд 21)

Энэ болгон мөнх амийг бүрэн дүүрнээр эдлэх цагийг ярьж байна. Тэр үед итгэгчид ямар ч нүгэлгүй, өвчингүй, уй гашуугүй, үхэлгүй болно. Бие нь мөнхийн цог жавхлантай байдалд шилжинэ.

Заримдаа мөнх амийг өв залгамжлал гэж өгүүлдэг:

Миний нэрийн төлөө гэр орон, ах, эгч, дүүсээ эсвэл эцэг эхээ, хүүхдүүдээ эсвэл эдлэн газраа орхисон хүн бүр зуу дахин ихийг хүртэх бөгөөд мөнх амийг өвлөх болно. (Мт 19:29. Мөн Мк 10:29-30; Лк 18:30-ыг үз)

Түүний нигүүлслээр зөвтгөгдсөнөөр бид мөнх амийн найдварын дагуу өвлөгчид болох юм. (Тит 3:7)

Үйлсээр олж авахгүй

Дэлхий дээр хэрхэн амьдарсныхаа шагналд мөнх амийг авах юм шигээр Библийн зарим хэсэгт бичсэн нь бий. Тийм ангилалд багтах эшлэлүүд гэвэл: Матай 25:45-46; Лук 18:29-30; Иохан 4:36; 12:25; Ром 2:7; Галат 6:8. Гэхдээ энэ цөөн хэдэн эшлэл бүтэн Библийн нийтлэг сургаалаас зөрүүтэй утга санаа илэрхийлсэн байх учиргүй гэдгийг бодох ёстой. Авралыг нигүүлслээр, бэлэг болгож, итгэлээр хүлээн авдаг, үйлсээс бүрэн ангид гэж Библи бүхэлдээ заадаг шүү дээ.

Тэгвэл энэ хэдэн эшлэл юуг хэлнэ вэ? Тун энгийн. Диваажинд хүлээн авах шагналын маань *түвшин* өөр өөр байхыг хэлж байгаа юм. Христийн шүүх суудлын өмнө зарим нь титмээр шагнуулахад зарим нь юу ч үгүй хоцорно. Итгэгч бүр мөнх амьтай ч гэлээ, мөнх амийг эдлэх түвшин ижилгүй байх ажээ (1Ко 15:41б). Мөнх амийг хэр дээд зэргээр амсах нь дэлхий дээр хэр итгэмжтэй үйлчилснээр (Гал 6:7-9), ариун

байдлыг хэр сахиснаар тодорхойлогдох болно (Ром 6:22).

Дээрх эшлэлүүдэд өгүүлж буй сайн үйлс нь мөнх амийг олж авах үйлс бус, харин тэр амиас гарч байгаа үр жимс юм. Жишээ нь Матай 25:46 дээр “Тэд мөнх шийтгэлд, харин зөвт нь мөнх аминд орох юм” гэсэн нь: Их зовлонгийн үед Христийн иудей ахан дүүст тусалж дэмжсэн хүмүүс эл үйлдлээрээ үнэхээр аврагдсан хүмүүс байснаа нотлох бөгөөд үүнийхээ үр дүнд мөнх амийг эдлэх болно гэсэн утгатай. Сайн үйлс нь авралынх нь нотлох баримт юм.

Иохан 4:36 болон 12:25 дээр, аврал авах шаардлагыг бус, итгэмжтэй үйлчлэлийн шагналыг ярьж байгаа нь тодорхой байна:

36 Хураагч хөлсөө хүртэж, мөнх амийн үрийг цуглуулж байна. Тийнхүү тариачин тариа хураагчийн хамт баярлах болно.

25 Амиа хайрлагч нь түүнийгээ алдана. Энэ ертөнцөд амиа үзэн ядагч нь түүнийгээ мөнх аминд хүртэл хадгална.

Ром 2:7 олон хүний хувьд бэрх эшлэл
*Тэвчээртэйгээр сайныг үйлдэж, алдар,
хүндэтгэл болон мөхөшгүй байдлыг хайгчдад
мөнх амь өгнө.*

Өнгөцхөн харвал, сайныг үйлдэж, сайн байвал мөнх амийг авна гэж хэлсэн мэт санагдахаар. Библи өөрөө ийм тайлбарыг байнга хориглодог шүү дээ. Үүнийг Библийн дагуу зөв ойлгож болох хоёр тайлбар бий. Үүнд: (1) *Онолын хувьд* ярьж буй шаардлага гэж харах. Авралгүй

хүмүүсийг шүүх Бурханы стандарт... Үл итгэгч хүн өөрийнхөө хүч чадлаар, ямар ч алдаа гаргахгүйгээр сайныг үйлдэж амьдарвал мөнх амийг өгөх тухай хэлсэн байж болох юм. Даан ч ийм юм боломжгүй. “Сайныг үйлддэг нь алга. Бүр ганц ч алга” (Ром 3:12). (2) Эсвэл энэ нь Ариун Сүнсний хүч чадлаар явах итгэгч хүний дүрслэл байх. Тийм бол, сайн үйлс нь аврал авах үндэс нь бус, авралынх нь үр жимс байх болно.

Дүгнэлт

Мөнх амь бол дахин төрөлтөөр олж авдаг сүнслэг амь. Энэ амь Бурханы Өөрийнх нь амь бөгөөд Бурханы адил мөнх. Энэ амь бидний одоогийн эзэмшил, бас ирээдүйн найдвар. Христэд үнэхээр итгэдэг хүн мөнх амьтай гэдгээ мэдэх арга нь Бурханы үгийн эрх мэдэл билээ. *Авралын баталгаа Библиэс ирдэг.*

Итгэгч бид ирээдүйд мөнх амийг бүрэн дүүрнээр хүлээн авахаар хүлээж байна. Энэ үед бидний бие аврагдана.

Мөнх амийг шагналтай холбож ярьсан бол, ариун байдал, үйлчлэл, сайн үйлсийн хариуд мөнх амийг авна гэдгээр ойлгох ёсгүй. Харин Христийн амь итгэгчдийн дотор ажиллахад түүнийг итгэмжтэй харуулсан нь шагнуулна гэсэн юм шүү.

ДӨРӨВ

ЦАГААТГАЛЫГ ЗӨВ ОЙЛГОХУЙ

Atonement (цагаатгал, эвлэрүүлэл) – Библид олон утгаар хэрэглэсэн үг. Яг ямар утгаар орж байгааг хам сэдвээр тодорхойлох хэрэгтэй. Бид энэ үгийн утгуудыг хэрэглээнээс нь мэдэж авдаг. *[орч. тайлбар: Англи Библид орчуулгаар орж ирсэн atonement гэж үг буруу зөрүү ойлголт төрүүлдэг учир зохиогч үүнд тайлбар хийжээ. Монгол Библид үүнийг эвлэрүүлэл гэж орчуулжээ.]*

Үгийн утга руу орохоос өмнө, Хуучин гэрээний үед хүмүүс хэрхэн аврагддаг байсныг эргэн харцгаая. Хүмүүс Эзэнд итгэснээр аврагдаж байлаа. Бурхан тэдэнд тодорхой нэг илчлэл өгөхөд тэд Түүнд итгэж, зөвт гэж тооцуулдаг байсан. Тухайлбал, Бурхан Абрахамыг тэнгэрийн одод мэт үр удамтай болгоно гэж амладаг. Абрахам “ЭЗЭНд итгэсэнд Эзэн үүгээр нь түүнийг зөвд тооцов” (Эх 15:6). Абрахам ирээдүйд хүлээгдэж байсан Христийн ажлын үндсэн дээр аврагдсан. Абрахам тухайн үедээ Христийн ажлын талаар бүрэн ойлголттой байсан гэвэл эргэлзээтэй. Гэхдээ Бурхан мэдэж байсан учир Абрахамд тэр ажлын үнэ цэнийг тооцон аварчээ. Голгота дээр урссан Аврагчийн үнэт цусанд үндэслэн Бурхан түүний нүглүүдийг уучилсан байна. Бүх үеийн хүмүүс Эзэн Есүсийн авралын ажлын үндсэн дээр, Эзэнд итгэснээр аврагдсан. Үүний үр дүнд мөнхийн харилцаа үүсдэг.

Гэтэл итгэгч израиль хүн Эзэнд итгэснийхээ дараа нүгэл үйлдвэл Бурхантай нөхөрлөх нөхөрлөлөө сэвтээж, өөрөө бузартсанд тооцогддог байв. Мөн зан үйлийн талаас (нүгэл биш боловч) бузар болгодог зүйлс байсан. Тухайлбал, үхсэн амьтанд хүрэх гэх мэт. Ийм тохиолдолд тэр хүн асарт эсвэл сүмд мөргөл үйлдэх хориотой болж, түүнд цагаатгал хэрэг болно. Одоо бүгдээрээ цагаатгалыг үзэцгээе.

Хуучин гэрээн дэх утга

Хуучин гэрээнд “хучих”¹ гэсэн утгатай еврей үгийг цагаатгал гэж орчуулжээ. Тухайлбал Бурхан, “Бүхээгт дотор гадаргүй давирхай түрх” гэж Ноад тушаахдаа “цагаатгах” гэж орчуулагддаг үгтэй адилхан үндэстэй үгийг хэрэглэсэн. Цагаатгал нь Голгота дээрх Христийн ажлаар нүглийг бүрмөсөн, бүрэн дүүрэн, нэг мөр шийдэх хүртэл хучих, далдлах ажил хийж байлаа.

Зарим газарт *цагаатгах* гэдгээр нөхөн төлөх, цэвэрлэх, шийтгэлээс хэлтрүүлэх, адислан ариулах гэх мэт санааг илэрхийлсэн.

Энэ үгийг ихэвчлэн ард түмэн, тахилчид, Израиль үндэстэн дээр хэрэглэжээ. Гэхдээ нүглийг уучлах, нүглийг зайлуулах гэсэн утгаар

¹*Кафар* гэж үйл үг англи хэлний “cover” гэдэгтэй төстэй сонсогддог. Үүний нэр үг хэлбэр нь иудейчүүдийн “*Ём Киппур*” (шууд утгаараа “Хучилтын өдөр” буюу англиар *Day of Atonement*, монголоор *Эвлэрүүллийн өдөр*) гэсэн нэрд одоо ч байна.

хэрэглэсэн удаа бараг байхгүй. Еврейчүүд захидлын бичээч, Хуучин гэрээний тахилууд ганц ч нүгэл зайлуулж чадаагүй гэж тодорхой хэлсэн байдаг. Хэрэв цагаатгалаар “нүглийг зайлуулах” гэсэн утга илэрхийлсэн бол тахилууд үүргээ гүйцэтгэж чадаагүй болж таарна. “Учир нь бух, ямааны цусаар нүглийг авч хаях боломжгүй юм” (Евр 10:4). Жил бүр нүглийг санахын тулд Ём Кишпүрийг тэмдэглэдэг (Евр 10:3). Үүнээс болоод тахилын тогтолцоо Бурханы ард түмэнд нүглийн талаар цэвэр мөс чанарыг өгөөгүй юм. “Эс бөгөөс, үйлчлэгчид нь нэгэнт цэвэршигдээд нүглийн мөс чанар нь цаашид байхгүй болсон тул тахил өргөхөө больсон байх байсан биш үү?” (Евр 10:2).

Цагаатгалыг заримдаа амьгүй юмс дээр үйлддэг – тахилын ширээ, ариун газар, онцгой ариун газар, уулзалтын майхан, сүм. Эндээс харсан ч, цагаатгал нь нүглийг зайлуулахтай холбоогүй нь тодорхой. Учир нь амьгүй зүйлс нүгэл үйлдэж чадахгүй шүү дээ. Цагаатгал хийсэн тахилын ширээ зан үйлийн хувьд цэвэршсэнд тооцогдож, Бурханы мөргөлд ашиглагддаг. Зарим “эд юмс”-д цагаатгал үйлддэг шалтгаан үүнээс өөр байхгүй.

Цагаатгалыг хүн дээр хэрэглэсэн тохиолдолд зан үйлийн талаас цэвэршүүлэх гэсэн санааг илэрхийлсэн байна. Итгэгч иудей хүн нүгэл үйлдвэл, хуульд заасан тахилыг авчирна. Энэ нь нэг талаараа нүглээ гэмшиж байгаа явдал юм. Нүглээ гэмшихэд Бурхан түүнийг уучилдаг.

Тэрээр малыг тахилд өргөснөөр уучлагдаагүй. Харин уг тахилаар бэлгэдэж буй Христийн тахилаар уучлагдсан юм. Нүглийнх нь мөнхийн шийтгэл Эзэнд итгэхэд нь аль хэдийнээ цуцлагдсан боловч тэрээр нүглээ гэмшихдээ Бурхантай нөхөрлөх нөхөрлөлөө сэргээдэг байлаа. Түүний авчирсан тахил гадна талаас, зан үйлийн хувьд түүнийг Иеховагийн мөргөл хүндлэлд орох зохистой болгодог байсан. Тэр хүн угаас Бурхантай гэрээний харилцаанд байсан ба одоо зан үйлийн хувьд зохистой болж байгаа юм. Левийн тахилууд махан биеийг цэвэршүүлэх үүрэгтэй.² Өөрөөр хэлбэл, зан үйлийн хувьд, гадна талыг цэвэрлэдэг гэсэн үг. Гагцхүү Христийн ажил үхмэл үйлсээс мөс чанарыг цэвэрлэж, амьд Бурханд үйлчлэх боломжийг олгодог.³

Цорын ганц гажилт

Хуучин гэрээнд цагаатгал гэж үгээр нүглийг зайлуулах гэсэн санаа илэрхийлдэггүй гэж дээр өгүүлсэн. Гэхдээ энэ дүрмээс зөрсөн нэг л гажилт бий:

Гэмт үйлдлийг дуусгаж, нүглийг эцэслэн хилэнцийг наманчилж мөнхийн зөвт байдлыг тогтоох, үзэгдэл ба эш үзүүлэгийг битүүмжлэх мөн ариунаас ариун газрыг тослохын тулд чиний ард түмэн хийгээд ариун

²Еврей 9:13

³Еврей 9:14

хотын чинь төлөө далан “долоо хоног” тогтоогдсон юм. (Дан 9:24)

Энэ эшлэлийн “*хилэнцийг наманчлах*” гэсэн нь эх хэл дээрээ өнөөх “хучих” гэж үйл үгийг ашигласан байгаа. Энэ эшлэл Христийн хоёр дахь ирэлтийг зааж байгаа бөгөөд тэр цагт Израилийн хилэнц эцэслэн шийдэгдэнэ гэдгийг хэлж байна. Үнэндээ шаардлагатай тахил нь Голгота дээр өргөгдсөн юм. Харин израильчууд жадалсан Нэгэнээ харж, ганц хүүгийнхээ төлөө гашууддаг шиг Түүний хойноос асгартал уйлах хүртлээ тэр тахилын үр ашгийг хүртэж чадахгүй (Зех 12:10; Иох 19:37-г үз). Хуучин гэрээнд хучиж далдалж байсныг Христийн загалмайн үхэл бүрэн дүүрэн, бүрмөсөн зайлуулсан билээ.

Цагаатгал гэх үг бидний өдөр тутмын хэрэглээнд

Цагаатгал нь Шинэ гэрээний үг биш. Цагаатгал гэдэг Хуучин гэрээний ойлголт Шинэ гэрээнд огт үгүй. Хүн дээр ч тэр, амьгүй юмс дээр ч тэр, хучих үйлийн талаар Шинэ гэрээнд огт дурдаагүй. Библийн Жеймс хааны орчуулгад Ром 5:11 дээр энэ үг гардаг. Гэхдээ энэ нь орчуулгын асуудал. Эл үгийг эвлэрүүлэл (reconciliation)⁴ гэж буулгавал зөв болно. Орчин үеийн орчуулгууд цагаатгал (atonement) гэдгээс

⁴*Ром 5:11-д орсон үг нь грекээр каталлагэ бөгөөд эвлэрэх (reconciliation) гэсэн утгатай.*

татгалзаад эвлэрүүлэл (reconciliation) гэх болсон нь сайшаалтай.

Өнөөдөр бид цагаатгах (atonement) гэх үгийг Библийн утгаар ашигладаггүй. Христийн цагаатгал гэж хэлэхдээ Христийн үхэл, оршуулга, амиллаар дамжуулан нүглийн уучлал цагаатгал ирсэн гэдэг санааг илэрхийлдэг. Христийн цагаатгалын цусаар бидний нүгэл бүрмөсөн зайлуулагдсан гэж сургаал дээрээ ярьж, магтан дуугаараа дуулдаг. Гэхдээ энэ нь хэрэглээний утга болохоос, Хуучин гэрээнд ашигласан утга биш юм шүү.

Хэрэв зээ, Хуучин гэрээнд орсон утгыг нь өөрсдийнхөө өдөр тутамд хэрэглэдэг утгаас ялгаж салгахгүй бол төөрөлдөх, будилах аюултай. Нэг талд, Христийн ажил төгс төгөлдөр, нэг удаагийн, дотор талынх гэж ойлгодог, нөгөө талд, Хуучин гэрээний цагаатгал ганц тохиолдлоос бусад үед төгс бус, олон удаагийн, гадна талынх гэж мэддэг бол Христийн цагаатгал гэж ярихад буруудахгүй.

Цагаатгал мянган жилийн хаанчлалд

Цагаатгалыг Езекиелийн эш үзүүллэгт ирээдүйн мянган жилийн хаанчлалын сүмийн мөргөлтэй холбож хэрэглэсэн.⁵ Газар дэлхий дээр Бурханы хаанчлал байгуулагдах цагт тахилын ширээ, Израилийн ард түмэн, сүмд цагаатгалын зан үйл үйлдэнэ гэж Езекиел

⁵*Езекиел 43:20, 26; 45:15, 17, 20.*

зөгнөжээ. Энэ зөгнөл “Тэр нүглийн төлөөх ганц тахил үүрд өргөөд, Бурханы баруун гарт заларсан” (Евр 10:12), “Эдгээрийн уучлал хаа байна, тэнд цаашид нүглийн төлөөх тахил үгүй болдог” (Евр 10:18) гэсэнтэй зөрчилдөөд байгаа мэт харагддаг.

Цагаатгалыг Библийн утгаар бус, орчин үеийн толь бичгийн утгаар ойлгоод байгаагаас энэ асуудал улбаатай. Мянган жилийн хаанчлалын сүмийн тахилууд Хуучин гэрээний тахилуудаас илүү нүглийг зайлуулах үр нөлөөтэй болчихно гэсэн санаа Библид байхгүй юм шүү. Тэр тахилууд ердөө сүмийн зан үйлийн нэг хэсэг байх юм. Аврагдсан Израиль тэр зан үйлийг гүйцэтгэхдээ Христийн ажлын төгс төгөлдрийг зан үйлийн сул доройтой харьцуулан харах болно. Зан үйлүүд бол сүүдэр, Христ бол бодит хүн нь гэдгийг ойлгож авна. Хуучин гэрээний тахилууд ирээдүй рүү, Христийн ажил руу заадаг байсан бол, мянган жилийн хаанчлалын тахилууд өнгөрсөн рүү, Голгота руу заана. Өөрөөр хэлбэл, Эзэний зоогтой ижил үүрэг гүйцэтгэнэ. Дурсан сануулах ёслол байх болно. Түүнээс илүү биш.

**ХОЁРДУГААР
ХЭСЭГ
ЯЛГАА II: ХРИСТЭЧ
АМЬДРАЛ**

ТАВ

БАЙР СУУРЬ БА АМЬДРАЛ

Итгэгчийн *байр суурь, амьдрал* хоёрын ялгааг ойлговол Шинэ гэрээг онгойлгох гол түлхүүрийг атгалаа гэсэн үг. Энэ хоёрын ялгааг олж хараагүй цагт Библийн эшлэлүүд хоорондоо зөрчилдөөд байх шиг санагдаж, толгой эргэдэг.

Заримдаа байр суурийг *зогсох газар*, амьдралыг *байр байдал* гэж хэлэх нь бий. Утга нь адил. Христитгэгчийн байр суурь нь итгэгч хүн Христийн дотор хэн бэ гэдгийг хэлдэг. Амьдрал нь тухайн хүн өөрөө хэн бэ, ямар байх ёстой вэ гэдгийг хэлдэг. Эхнийх нь *онол сургаал*, удаах нь *үүрэг*. Нэг дэх нь *бодит үнэн*, хоёр дахь нь *амьдралын туршлага*. Эхнийх нь *Христтэй нэгдмэл болсон тухай*, удаах нь *Христтэй нөхөрлөх тухай*.

Христитгэгч нь Христийн дотор хэн бэ - энэ нь өөрөө хэн бэ гэдгээс ялгаатай. Христитгэгч нь нигүүлслийн ач буянаар Христийн дотор, Бурханы өмнө төгс байр суурийг авсан. Бурхан түүнийг Хүүгээ хүлээн авдаг шигээр хүлээн авдаг (Еф 1:6, Кол 2:10). Итгэгч хүн Христийн дотор бүрэн бүтэн (2Ко 5:21). Түүний нүглүүд уучлагдаж, Бурханы зөвт байдал түүнийх болсон.

Бурханд би ойрхон, дэндүү ойрхон
Бурханы Хүүгийн адил ойрхон
Бурханы Хүүтэй нэгдсэн би
Ойртохын дээдээр ойртжээ

*Бурханд би эрхэм, дэндүү эрхэм
Хүүгээ хайрладаг шиг нь эрхэм
Бурханы Хүүгийн дотор би
Хайрлуулахын дээдээр хайрлуулжээ*

-Кэйтсби Пэжит

Нөгөө талд итгэгчийн амьдрал гэж бий. Энэ нь байр сууриас эрс ялгаатай. Итгэгчийн амьдрал төгс бус. Өдөр өдөртөө өөр. Зарим өдөр сүнслэг байдал нь уулын оргилд гаравч, зарим өдөр ялагдлын ангалд уначихна.

Христэч хүний амьдралыг байр суурьтайгаа аль болох дүйцэхүйц, адилхан байгаасай гэж Бурхан хүсдэг. Өөрсдийн маань төлөө амиа өргөсөн Эзэн Есүсийг хайрласан хайраар өдрөөс өдөрт Христтэй адил болоосой гэж хүсдэг. Мэдээж бид энэ дэлхийн амьдралаа дуустал төгс болно гэж үгүй. Нас бартал эсвэл Аврагч ирж автал тийм юм болохгүй. Гэвч байнга өсөх үйл явц явагдах ёстой. Амьдрал маань цаг хугацаа өнгөрөх бүр байр суурьтайгаа адил болох ёстой.

Бид Аврагчтайгаа нүүр тулан уулзах үедээ автоматаар Түүнтэй адил болно (1Ио 3:2). Энэ өөрчлөлт шилжилтэд бидний оролцоо байхгүй бөгөөд гагцхүү Бурханы хүчээр болох юм. Гэхдээ энэ амьдралдаа Эзэн Есүстэй адил болж өсвөл Бурханд илүү алдрыг авчирдаг. Тэр ч бүү хэл, христитгэлийн үнэнд илүү сайн “сурталчилгаа” болно.

Байр суурь ба амьдралыг ялгаж салгах нь

Библийн тодорхой нэг хэсэг, байр суурийг ярьж байна уу, эсвэл амьдралыг ярьж байна уу гэдгийг яаж мэдэх вэ? “Христийн дотор”, “Хайрт Хүүгийнх нь дотор”, “Түүний дотор” гэх мэт үгс орж уу гэж хараарай. Ийм үгс ашигласан бол ихэнхдээ бидний байр суурийн тухай ярьсан байдаг (Еф 1:3-14). Харин *бидний ямар байх, юу хийхийг* заасан бол амьдралыг ярьж байгаа нь тэр.

Мөн дарааллыг харах хэрэгтэй. Шинэ гэрээнд байр суурийг эхэнд, амьдралыг хоёрт бичдэг. Хэд хэдэн захидлуудад ийм дарааллаар бичигдсэн байгаа. Жишээлбэл Ефес ном. Эхний гурван бүлэг нь бид Христийн дотор хэн бэ гэдгийг өгүүлнэ. Сүүлийн гурван бүлэг нь өдөр тутмын амьдралдаа ямар байх ёстойг маань хэлж өгнө. Эхний гурван бүлэг нь биднийг Христ дотор тэнгэрлэг газарт байгаа гэж тунхагладаг. Сүүлийн бүлгүүдэд нь гэр орны янз бүрийн асуудал, ажлын талбар гэх мэт сэдвүүдийг хөнджээ.

Ялгаануудын жишээ

Шинэ гэрээг уншихдаа энэ хоёр ойлголтыг ялгаж салгадаг болчихвол ямар их тустайг одоо харцгаая. Байр суурь ба амьдралыг харуулсан долоон жишээг доор орууллаа:

Жишээ №1

Байр суурь	Амьдрал
<i>Учир нь Тэр ариун болгогдогсдыг тахилаар үүрд болгожээ.</i>	<i>Тиймд тэнгэрлэг ганц Эцэг чинь төгс байдаг шиг та нар мөн төгс бай.</i>
(Евр 10:14)	(Мт 5:48)

Эхний эшлэл бүх итгэгчийг төгс гэж мэдэгдсэн. Хоёр дахь эшлэл харин бүх итгэгчийг төгс бай гэж тушаажээ. Хэрэв эхнийх нь байр суурийг, хоёр дахь нь амьдралыг ярьж байна гэж ялган салгаж ойлгохгүй бол хоорондоо зөрчилтэй мэт санагдана.

Жишээ №2

Байр суурь	Амьдрал
<i>Нүгэлд үхсэн бид цаашид түүн дотроо яахин амьдрах билээ?</i>	<i>Түүнчлэн та нар өөрсдийгөө нүгэлд ... байгаагаа тооц.</i>
(Ром 6:2)	(Ром 6:11)

Та нүгэлд (нүглийн хувьд) үхсэн хүн – нигүүлсэл таныг ийм байр суурин дээр тавьжээ. Тэгвэл одоо та өдөр бүр нүглийн хувьд үхсэн хүн гэдэг байр суурин дээрээ зогсож амьдрах үүрэгтэй аж.

Жишээ №3

Байр суурь	Амьдрал
<i>Харин Өөрийг нь Иймд хайрлагдсан</i>	
<i>хүлээн авсан болгонд, хүүхдүүдийн хувьд</i>	
<i>Өөрийнх нь нэрд Бурханыг дуурайгчид</i>	
<i>итгэгчдэд Тэрээр бай.</i>	
<i>Бурханы хүүхэд</i>	
<i>болох эрхийг өглөө.</i>	

(Иох 1:12)

(Еф 5:1)

Хүн дахин төрсөн даруйдаа Бурханы хүүхэд болдог. Тэр цагаас хойш Бурханы хайрт хүүхдүүдийн хувьд Бурханыг дуурайж амьдрах ёстой. Бурханы бүх хүүхэд гэр бүлийнхээ онцлогийн буюу бурханлаг байдлын тусгал болж явах үүрэг хүлээдэг.

Жишээ №4

Байр суурь	Амьдрал
<i>Өөрийн Хүү, бидний Иймд та нар</i>	
<i>Эзэн Есүс Христийн дуудагдсан тэрхүү</i>	
<i>нөхөрлөлд та нарыг дуудлагадаа зүй</i>	
<i>дуудсан Бурхан зохистой явахыг</i>	
<i>итгэмжит юм. Эзэний хоригдол би</i>	
	<i>хичээнгүйлэн ятгая.</i>

(1Ко 1:9)

(Еф 4:1)

Бурхан биднийг Өөрийн Хүүтэй нөхөрлүүлэхээр аугаа нөхөрлөлд дууджээ. Энэ их боломж завшаан их үүрэг хариуцлагыг

дагуулдаг. Бид дуудлагадаа зохистой алхах ёстой.

Жишээ №5

Байр суурь

Амьдрал

Бурханд хайрлагдсан, Ариун хүмүүст зохих ариун хүмүүс байхаар ёсоор түүнийг Эзэн дуудагдсан, Ромд буй дор хүлээн аваарай... бүгдэд...

(Ром 1:7)

(Ром 16:2)

Ром дахь итгэгчдийг Паул “Бурханд хайрлагдсан”, “ариун хүмүүс”, “дуудагдсан” гэж тодорхойлсон. Аврагдсан л бол ариун хүн мөн. Гэхдээ ариун хүн ариун хүний ёсоор амьдрах үүрэг хүлээдэг. Үүний амьдрал талыг Ром 16:2 зааварчилж байна.

Жишээ №6

Байр суурь

Амьдрал

Нигүүлслийн учир ...өөрсдийн авралыг итгэлээрээ айдас ба чичрэлээр аврагдсан... гүйцээ.

(Еф 2:8)

(Флп 2:12б)

Бидний байр суурь бол Бурханы өгсөн бэлэг. Харин амьдрал маань үүнд талархсан сэтгэлийн илэрхийлэл байх ёстой. Байр суурь эхэнд, амьдрал хоёрт байгааг анзаараарай. Бид христэч амьдралаар амьдарсан болохоор христэч

болоогүй. Харин христэч болсон учраас христэч амьдралаар амьдардаг юм.

Жишээ №7

Байр суурь

Амьдрал

Мөн дотор нь зогсдог энэхүү нигүүлсэл уруу бид Түүгээр дамжин итгэлээр боломжтой болсон... *Тимотыг та нар уруу удахгүй илгээнэ гэж би Эзэн Есүст найдаж байна. Тэгвэл байдлыг чинь мэдээд, би бас урамтай байх болно.*

(Ром 5:2а)

(Флп 2:19)

Дотор нь зогсдог тэрхүү нигүүлсэл бол Христийн дотор бидэнд байгаа байр суурь. Бурханы нүдэнд тааламжтай байр суурь. Харин бидний байр байдал, амьдрал бол өдөр тутам биеэ хэрхэн авч явах тухай асуудал юм.

Жишээ №8

Сүүлийн жишээ болгож Колоссай 3:1-5-ыг харцгаая. Элч Паул байр суурь ба амьдралыг хэрхэн ялгаатай гаргаж тавьсныг үзэцгээе.

Байр суурь

Амьдрал

Тиймээс хэрэв та нар Христтэй амилуулагдсан бол... *...дээгүүрхийг хай. Тэнд Бурханы баруун талд Христ заларч байгаа.* (1-р эшлэл)

*Газар дээрхийг бус
дээгүүрх зүйлсийг
эрмэлз. (2-р эшлэл)*

*Учир нь та нар үхсэн Тиймд та нар газар
бөгөөд та нарын амь дээрх эрхтнүүдийг
Христтэй хамт үхүүл... (5-р эшлэл)
Бурханд нууцлагдсан.
(3-р эшлэл)*

Нэг ёсондоо Паул: “Та нар үхсэн хүмүүс. Тэгвэл үхсэн хүн бай. Та нар амилсан хүмүүс. Тэгвэл амиллын амиар амьдар” гэж хэлж байна. Элч Паул нэг талд, Христ доторх байр суурийг маань, нөгөө талд, бид өөрсдөө ямар байх ёстойг ярьж байна гэдгийг ойлговол, ойлгомжгүй байсан энэ хэсгийн утга цэгцтэй болоод ирнэ.

Хувийн гэрчлэл

Христитгэгч хүний байр суурь ба амьдралын ялгааг өөрийн амьдралаар хэрхэн ойлгож авсан, энэ нь надад яаж тусалсныг та бүхэнд хуваалцъя. Христэд итгэн аврагдаад удаагүй байхад минь хүмүүс 2Коринт 5:17-г эш татаж олонтоо гэрчилдэг байлаа: “Тиймээс хэн нэг нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна!”

Амьдрал нь эрс өөрчлөгдсөнийг ярьцгааж, хуучин юмс өнгөрч, бүх юм шинэ болсон гэгцгээдэг байлаа. Ийм үгс сонссон би өөртөө гутарч, “Миний хуучин бүхэн өнгөрч, бүгд шинэ

болсон гэж хэлж чаддаг ч болоосой” гэж боддог байлаа. Харамсалтай нь, Христэд итгэхээс минь өмнө байсан зарим хуучин зуршил, муухай бодлууд, уур уцаар гэх мэт олиггүй юмс надад байсаар л байлаа. Тухайн үед би авралдаа эргэлздэг байв.

Гэтэл нэг өдөр “Христ дотор” гэсэн үгийг би анзаарсан юм. Зүрх сэтгэл минь баяр хөөрөөр бялхлаа. Уг эшлэл миний амьдралыг бус, байр суурийг ярьж байжээ. Нээрээ л “Христ дотор” шинэ бүтээл болсон минь үнэн шүү дээ. Христ дотор, ял, буруутгал, сатаны ноёрхол, үхлийн айдас – энэ бүх хуучин юмс өнгөрсөн шүү дээ. Харин уучлал, зөвтгөл, аврал, ерөөл – бүх юм шинэ болсон. Тэр цагаас хойш 2Коринт 5:17 надад айдас төрүүлэхээ больсон. Харин ч бүр дуртай эшлэл минь болсон. Христ дотор хэн болохоо ойлгосон цагаас Эзэн Есүсийг амьдралынхаа Эзэн болгож амьдрах хүсэл улам бүр ундарсан билээ.

Асуулт: 1Коринт 5:7, Ефес 5:8, 1Петр 2:9 дээр байр суурь, амьдралыг бичсэн эшлэлүүд. Та уншаад энэ эшлэлүүдээс байр суурь ба амьдралыг ялгаж салгаж чадаж байна уу?

ЗУРГАА

ХОЛБОО ХАМААРАЛ БА НӨХӨРЛӨЛ

Одоо өгүүлэх сэдэв болбоос өмнөх бүлэгт өгүүлсэн “байр суурь ба амьдрал”-тай төстэй боловч тодорхой хэмжээнд ялгаатай учир тусад нь нэг бүлэгт тайлбарлана.

Бурханых болсон холбоо хамаарал

Хүн дахин төрөх мөчид шинэ холбоо хамаарал үүсдэг. Тэр хүн Бурханы хүүхэд болдог.

Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрд итгэгчдэд Тэрээр Бурханы хүүхэд болох эрхийг өглөө. (Иох 1:12)

Хайртууд минь, бид одоо Бурханы хүүхдүүд. Бидний ямар болох нь хараахан илчлэгдээгүй. Түүнийг илчлэгдэхэд бид Түүнтэй адил болно гэдгийг мэднэ. Учир нь бид Түүнийг байгаагаар нь харах болно. (1Ио 3:2)

Хүн нэг төрсөн бол буцна гэсэн юм үгүй. Та энэ тухай бодож үзсэн үү? Төрсөн л бол төрсөн. Буцах, алга болох гэж үгүй. Төрөлтөөр дамжуулан өөрчлөх боломжгүй хамаарал, харилцаа холбоо үүснэ. Нэг жишээ татъя. Жонсынхны гэр бүл хүүтэй болжээ. Амьдралд юу ч тохиолдсон тэр хүү ноён, хатагтай Жонсын хүүхэд хэвээр байна. Тэд ч хүүхдийн эцэг эх хэвээр байна. Энэхүү харилцаа, холбоо хамаарлыг хэн ч, юу ч өөрчилж чадахгүй. Хүү том болоод гэр бүлийнхээ нэр хүндийг унагаж,

аав ээжийгээ гомдоосон гэж бодъё. Тэгсэн ч, эцэг эх, үр хүүхдийн холбоо арилахгүй. Ноён Жонс хүүгийн аав хэвээрээ, хүү ч Жонсынхны хүүхэд хэвээрээ үлдэнэ.

Энэ зарчим итгэгчдэд адил. Дахин төрөх мөчид итгэгч нь Бурхан Эцэгийн хүүхэд болдог. Энэ харилцаа, холбоо хамаарлыг юу ч өөрчлөхгүй:

Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнстэй хамт гэрчилдэг. (Ром 8:16)

Тиймээс чи цаашид зарц биш, харин хүү нь юм. Хэрэв хүү нь юм бол Бурханаар дамжин өв залгамжлагч нь ч бас мөн. (Гал 4:7)

Энэ бол хэзээ ч тасрахгүй холбоо. Нэгэнт хүү нь, охин нь болбол үүрд хүү нь, охин нь байх болно.

Бурхантай нөхөрлөх нөхөрлөл

Дээр өгүүлсэн маань үнэний нэг тал. Нөгөө тал нь Бурхантай нөхөрлөх нөхөрлөл юм. Нөхөрлөлийг Библийн грек эх хэл дээр коинониа гэнэ. Нийтлэг зүйлстэй байх гэсэн утгатай. Холбоо хамаарал нь салшгүй холбогдсоныг илэрхийлдэг бол, нөхөрлөл нь харилцааг илэрхийлдэг. Холбоо хамаарлыг тасаршгүй гинжтэй зүйрлэвэл, нөхөрлөлийг амархан тасрах нарийн утастай зүйрлэнэ.

Бурхантай нөхөрлөх нөхөрлөлийг нүгэл тасалдаг. Тохиролцоогүй хоёр хамт алхаж чадахгүй (Амо 3:3). Түүнчлэн, Бурхан нүгэл

үйлдэж буй хүүхдүүдтэйгээ хамт нөхөрлөл дотор алхаж чадахгүй: “Бурхан бол гэрэл, Түүний дотор харанхуй огт үгүй...” (1Ио 1:5). Амьдралдаа байгаа бузар мууг нуун далдалж буй хүмүүстэй Бурхан яахин нөхөрлөж чадах билээ.

Бурхантай нөхөрлөх нөхөрлөлөө алдсан итгэгч хүн баяр хөөр, дуу хуур, үйлчлэх хүч, эрх мэдэл, гэрчлэл, үр нөлөөтэй залбирлын амьдралаа бас алддаг.

Тэр хүн нүглээ гэмшиж, нүглээсээ эргэхээс нааш нөхөрлөл сэргэхгүй. Бурхантай нөхөрлөх нөхөрлөл алдагдах нь ноцтой асуудал мөн. Магадгүй Эзэнээс хөндий байхдаа шийдвэр гаргаад үлдсэн амьдралынхаа туршид арилшгүй хар мөртэй үлдэж болох. Бурханаас холдож хөндийрсөн олон итгэгч үл итгэгчтэй гэрлээд, Бурханд ашиглагдах талаас харвал амьдралаа сүйрүүлсэн жишээ хэчнээн олон билээ дээ. Тэдний сүнс мэдээж авралтай хэвээр. Харин амьдрал нь үр дүнгүй өнгөрч байгаа нь тэр.

Нөхөрлөл тасалдахад Бурханы сахилгажуулал ирнэ. Итгэгч хүн нүглийн мөнхийн шийтгэлээс чөлөөлөгдсөн ч гэлээ энэ амьдралдаа үйлдсэн нүглийн үр дагавар, уршгаас чөлөөлөгдөөгүй. Коринтын чуулганы зарим итгэгч яагаад өвчтэй болсон билээ? Яагаад гэвэл тэд нүглээ гэмшилгүй, буруугаа засалгүйгээр Эзэний зоогт оролцсон (1Ко 11:29-32). Зарим нь бүр нас барсан. Тэд Христ Есүсийн золилтоор диваажинд тэнцсэн боловч энэ дэлхийд Христийг гэрчлэх амьдралд эс тэнцжээ.

Бурхантай нөхөрлөх нөхөрлөлөө алдсан итгэгч Христийн шүүх суудлын өмнө авах шагналаа бас алддаг (1Ко 3:15). Бурханаас хол хөндий өнгөрүүлсэн цаг хугацаа нь үүрд үрэн таран болж дуусна.

Нэг талд, Бурханых болсон холбоо хамаарал хэзээ ч тасрахгүй нь үнэн боловч, нөгөө талд, хайрт Эцэгтэйгээ нөхөрлөх нөхөрлөлөө гээх вий хэмээн эмээж явах нь зүйтэй. Үнэндээ, нигүүлсэл биднийг хэнийх болгосныг, хэзээ ч тасрахгүй ямар гайхалтай холбоо хамааралд оруулсныг мэдсэн хүн Эзэнтэй нөхөрлөх нөхөрлөлөө хамгаалахыг бүр ихээр хүсэх нь дамжиггүй. Нигүүлсэл бидэнд нүгэл хийх зориг өгдөггүй. Харин нүглээс зайлсхийх ухаарал хайрладаг.

Библийн дүрслэл

Хуучин гэрээнд, нүглээс болж Бурхантай нөхөрлөх нөхөрлөлөө алдсан ариун хүний сонгодог жишээ бол Давид хаан. Давид хаан нүглээ улайж, Эзэнтэй нөхөрлөх нөхөрлөлөө хэрхэн сэргээснийг бид Дуулал 32, Дуулал 51-ээс уншдаг.

Шинэ гэрээний тод жишээ гэвэл, тэнэмэл хүүгийн сургаалт зүйрлэл (Лк 15:11-24). Нүгэлтэн Христ рүү ирж аврагдах тухайд энэ сургаалт зүйрлэлийг ихэвчлэн эш татдаг ч гэлээ, Бурханаас хөндийрөөд буцан ирж буй итгэгчийн зүйрлэлээр ч харж болох түүх. Хүү эцэгтээ тэрсэлж, хол газрыг зорин тэнэсэн нь Бурхантай

нөхөрлөх нөхөрлөл тасарч буйн зураглал байж болох юм. Гэхдээ алс нутагт байхдаа ч хүү эцгийнхээ хүү байхаа болиогүй. Харин эргэж ирээд нүглээ гэмшихэд эцэгтэйгээ өмнөх сайхан харилцаагаа, нөхөрлөлөө сэргээсэн юм. Эцэг нь хүүгээ тосон гүйж, хүзүүдэн тэвэрч, үнссэн.

Бяцхан хүүхдүүд минь, та нарыг нүгэл бүү үйлдээсэй хэмээн би эдгээрийг та нарт бичиж байна. Хэн нэг нь нүгэл үйлдвээс Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн. (1Ио 2:1)

Энэ үгийг Бурханы гэр бүлд дөнгөж мэндэлсэн хүмүүст буюу бяцхан хүүхдүүдэд бичжээ. Бурханы чин хүслэн болбоос хүүхдүүд нь огт нүгэл үйлдэхгүй байх. Даан ч бид нүгэл үйлддэг. Тиймээс Бурхан бидэнд нүглээ залруулах гаргалгааг бэлджээ: “Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй.” Эцэгийн өмнө Өмгөөлөгчтэй гэснийг анхааран уншаарай. Биднийг нүгэл үйлдсэн үед ч Бурхан бидний Эцэг хэвээрээ байна. Яаж ийм байх боломжтой вэ гэж үү? Яагаад гэвэл, Бурхан бидний дунд хэзээ ч тасрахгүй холбоо үүссэн байгаа юм. Биднийг нүгэл үйлдэхэд юу болдог байх нь вэ? “Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн.” Есүс Христ биднийг нүглээ гэмших, нүглээсээ эргэх байдал руу авчрахаар ажиллаж эхэлдэг. Тийнхүү бид Эцэгтэй нөхөрлөх нөхөрлөлөө сэргээх юм.

Бурхантай холбогдсон холбоо хамаарал болон Бурхантай нөхөрлөх нөхөрлөлийн ялгааг олж

харснаас хойш би Христийн доторх авралынхаа
ганхашгүй мөнхийн баталгаанд баярласан.
Тэгээд зогсохгүй, намайг тэгж их хайрладаг
Эцэгтэйгээ нөхөрлөлтэй амьдрах урам зоригийг
олж авсан.

ДОЛОО

ХОЁР ӨӨР УУЧЛАЛ – ШҮҮГЧ БА ЭЦЭГ

Бурханы үгэнд буй уучлал хоёр янз. Библийг зөв ойлгоё гэвэл хоёр өөр уучлалын ялгааг мэдэх ёстой. Нэг дэх нь шүүгчийн уучлал, нөгөө нь эцгийн уучлал. Шүүгчийн уучлал шүүх танхимд, эцгийн уучлал гэр оронд.

Шүүгчийн уучлал

Эхлээд шүүх танхим руу очицгооё. Бурхан тэнд Шүүгчээр сууж байна. Нүгэлтэн тэнд хэргээ шүүлгэж байна. Тэр хүн буруутай нь тогтоогдож ял сонслоо. Ял нь мөнхийн үхэл. Гэтэл Эзэн Есүс гарч ирээд, “Би энэ хүний нүглийн ялыг эдэлье. Түүний өмнөөс үхье” гэж мэдэгдэв. Аврагч үүнийг Голготын загалмай дээр хийсэн билээ. Тэгэхэд нь Шүүгч ялтанд: “Хэрэв чи миний Хүүг өөрийн Эзэн ба Аврагчаар хүлээн авбал би чамайг уучилна” гэж мэдэгдлээ. Өнөөх хүн Аврагчид итгэлээ тавьснаар Шүүгч бүх нүглийг нь уучилжээ. Христ бүх ялыг нь эдэлсэн учир одоо тамд шийтгэл эдлэх шаардлагагүй болов. Уучлагдсан нүгэлтний статус өөрчлөгдөв. Бурхан түүний хувьд Шүүгч байхаа больж, Эцэг нь болов.

Эцгийн уучлал

Одоо шүүх танхимаас гарч гэр оронд эцгийн уучлалыг харцгаая. Бурхан тэнд Эцэг, итгэгч хүн

харин хүүхэд. Хүүхэд нүгэл үйлдэв. Одоо юу болох бол? Бурхан хүүхдээ нүгэл үйлдсэн гэж үхлийн ялаар яллах уу? Мэдээж үгүй. Яагаад гэж үү? Яагаад гэвэл, Бурхан одоо Шүүгч биш, Эцэг. Тэгвэл юу болох вэ? Гэр бүлийн сайхан харилцаа, нөхөрлөл алдагдана. Гэр бүлийн халуун дулаан уур амьсгал арилна. Тэр хүүхэд авралаа алдахгүй ч, авралын баяр хөөрийг алдана. Магадгүй Эцэгийнхээ сахилгажууллыг хүртэнэ. Эцэг нь бурууг залруулж, эргээд сайхан харилцаагаа сэргээх гэж хүүхдээ сахилгажуулна. Харин хүүхэд нь нүглээ улайж, буруугаа хүлээвэл эцгийн уучлалыг хүртэнэ.

Шүүгчийн уучлал нэг удаагийнх. Хүн Христэд итгэсэн тэр мөчид ганц удаа авдаг уучлал. Харин эцгийн уучлал олон удаагийнх. Итгэгч хүн нүглээ гэмшиж, нүглээсээ эргэх болгонд авна. Есүс үүнийг Иохан 13:8-10 дээр сургажээ. Бид нүглийн шийтгэлээс чөлөөлөгдөх гэж дахин төрөлтийн усанд нэг удаа ордог бол, христэч амьдралынхаа туршид эцгийн уучлалыг авах гэж олон удаа цэвэрлэгээнд ордог билээ.

Хоёр уучлалын ялгааг Библийн жишээгээр тайлбарлая

Хоёр төрлийн уучлалын ялгааг дараах байдлаар товчхон тайлбарлаж болох байх:

	Шүүгчийн уучлал	Эцгийн уучлал
Хүний хувь чанар	Нүгэлтэн (Ром 3:23)	Хүүхдүүд (1Иохан 3:2)

Бурханы байр суурь	Шүүгч (Дуулал 96:13)	Эцэг (Галат 4:6)
Нүглийн үр дагавар	Мөнхийн үхэл (Ром 6:23)	Нөхөрлөл тасрах (1Иохан 1:6)
Христийн үүрэг	Аврагч (1Тимот 1:15)	Тэргүүн тахилч, Өмгөөлөгч (Еврей 4:14-16, 1Иохан 2:1)
Хүний хэрэгцээ	Аврал (Үйлс 16:30)	Авралын баяр баясгалан (Дуулал 51:12)
Уучлалыг хэрхэн хүртэх вэ	Итгэл (Үйлс 16:31)	Нүглээ улайх (1Иохан 1:9)
Уучлалын төрлүүд	Хууль ёсны (Ром 8:1)	Гэр бүлийн (Лук 15:21-22)
Эсэргүүцвэл	Там (Иохан 5:24)	Сахилгажуулалт (1Коринт 11:31-32)Христийн шүүлтийн суудал өмнө шагналаа алдах (1Коринт 3:15)
Хүлээн зөвшөөрвөл	Шинэ харилцаа (Иохан 1:12)	Нөхөрлөл сэргээгдэнэ (Дуулал 32:5)
Хэдэн удаа хийх шаардлагатай вэ	Дахин төрөлтийг нэг удаа, үүрд угаана (Иохан 13:10)	Олон удаа (олон угаах: Иохан 13:8)

Шүүгчийн уучлал Библид

Хэрэв зээ, Христийн ажлаар дамжуулан нүгэлтэн бидэнд нэг удаад, нэгмөсөн уучлал үзүүлсэн тухай эшлэлүүд таарвал шүүгчийн уучлалыг ярьж байна гэж ойлгож болно. Жишээ нь:

Түүний нигүүлслийн баялгаар бидэнд Түүний дотор цусных нь золилт, гэм нүглийн маань төлөөх уучлал бий. (Еф 1:7)

Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биеэ уучлан, нэг нэгнээ энэрч аядуу зөөлөн сэтгэлээр ханд. (Еф 4:32)

Та нар тэрслэл ба махбодын хозлолоосоо болж үхсэн байхад, Тэр бидний тэрслэл бүхнийг уучилж, та нарыг Түүнтэй хамт амьд болгосон. (Кол 2:13)

Эцгийн уучлал Библид

Библид эцгийн уучлалыг өгүүлсэн хэсгүүд бас бий. Тухайлбал:

Хэрэв та нар хүмүүсийн алдааг уучилбал тэнгэрлэг Эцэг чинь та нарыг мөн уучилна. Харин та нар хүмүүсийг эс уучилбал Эцэг чинь мөн алдааг чинь эс уучилна. (Мт 6:14-15)

Бусдыг бүү шүү, тэгвэл шүүгдэхгүй. Бусдыг бүү ялла, тэгвэл яллагдахгүй. Уучлагтун, тэгвэл та нар мөн уучлагдана. (Лк 6:37)

Та нар залбиран зогсохдоо хэрэв хэн нэгний эсрэг ямар нэгэн юм чамд байгаа бол уучил. Тэгвэл тэнгэр дэх Эцэг чинь мөн та нарын алдааг уучилна. (Мк 11:25)

Энэ гурван эшлэлд Бурханыг зориуд Эцэг гэсэн байгааг анзаараарай. Учир нь энд эцгийн уучлалыг ярьж байна. Энэ уучлал бусдыг уучлах эсэхээс хамаарна гэснийг мөн анзаараарай. Шүүгчийн уучлалд ийм зүйл үгүй. Бусдыг уучлах уу, уучлахгүй юу гэдэг нь мөнх авралыг авах болзол биш. Харин эцгийн уучлал болзолтой. Хэрэв бид бусдыг уучлахгүй бол Эцэг маань биднийг уучлахгүй.

Хаандаа 10,000 талантын (асар их мөнгө!) өртэй боол өршөөгдөж, өрнөөсөө хэлтэрч буй тухай Есүсийн айлдсан сургаалт зүйрлэл Матай 18:23-35 дээр бий. Гэтэл тэр боол өөрт нь 100 денарын (бага мөнгө) өртэй анд нөхрийнхөө өрийг хэлтрүүлээгүй. Тиймээс хаан нь боолдоо уурлаж, бүх өрөө барагдуулах хүртэл нь түүнийг шоронд хорьжээ. Есүс сургаалт зүйрлэлийнхээ төгсгөлд: “Түүнчлэн та нарын нэг бүр чинь ах дүүгээ зүрхнээсээ эс уучлах аваас тэнгэрлэг Эцэг минь ч та нарт мөн тэгж хандах болно” (35-р эш.) гэж хэлсэн. Энд дахиад эцгийн уучлал яригдаж байна. Үл уучлах нь нүгэл мөн. Хэрэв бидэнд үл уучлал байх аваас, нүглээ хүлээн зөвшөөрч, орхих хүртэл маань Бурхан биднийг эцгийн хувиар уучлахгүй.

Энэ мэт суурь ялгааг олж хараад, Библи унших бүртээ уг ойлголтуудаа ашиглавал Библи судлал үнэхээр амттай болж ирнэ. Одооноос эхлэн та Библи дэх уучлалын сэдвийг авч үзэхээр бол, “Энэ нь шүүгчийн уучлал байна” эсвэл “Энэ нь Эцэг хүүхдээ уучлах тухай байна” гэж хэлж

чадахаар боллоо. Нэг л зүйлийг тогтоогоод ав:
Нүгэлтэн Эзэн Есүс Христэд итгэх үедээ
шүүгчийн уучлалыг хүлээн авдаг. Итгэгч хүн
нүглээ улайх үедээ эцгийн уучлалыг хүлээн
авдаг.

НАЙМ ХОЁР ХҮН

Библийн ухагдахуунуудын ялгааг авч үзэхэд итгэгчийн дотор оршдог хоёр хүний ялгааг ойлгох нь юу юунаас илүү амьдралд тустай. Үүнийг ойлгоогүй итгэгчийг буруутгал, эргэлзээ, урам хугарал дотроос нь мэрж иддэг. Итгэгч бүхний дотор шинэ, хуучин хоёр хүн байдгийг ухаарч, тэдгээрийн мөн чанарыг ойлгох нь тун чухал.

Хуучин хүн

Аврагдсан, аврагдаагүй бүх хүнд хуучин хүн бий. Итгэгч хүнд хуучин, шинэ хоёр хүн хамт оршдог бол, үл итгэгчийн дотор зөвхөн хуучин хүн оршдог. Энэ нь Адамаас өвлөгдсөн мөн чанар бөгөөд насан туршид дагаж явна. Үүнийг өөрөөр, Адамын мөн чанар, хуучин мөн чанар, махбод гэж нэрлэдэг. Давид үүнийг хүлээн зөвшөөрөхдөө “Харагтун, хилэнц дунд би төрж, нүгэл дотор эх минь намайг олж тээсэн” хэмээн өчжээ (Дуу 51:5). Паул бас хуучин хүний тухайд “Учир нь миний дотор буюу махбодод минь ямар ч сайн зүйл байдаггүйг би мэддэг” (Ром 7:18) гэж бичжээ. Хуучин хүнээсээ сайн юм хайгаад нэмэргүй. Сайн юм гарч ирээгүйд нь урам хугарах ч хэрэггүй. Харин хорвоогийн хамаг бузар муу бүхэн түүнээс гарах боломжтойг эртхэн ойлгож авах нь сайн.

Адамын мөн чанар болбоос итгэгчийн гурван дайсны нэг. Нөгөө хоёр нь ертөнц ба Сатан.

Хуучин хүн бол бидний дотор орших дайсан, дайсагнагч, тэрслэгч, хор хутгагч. Бузар муу бүхнээр тэжээгдэгч. Энэ мөн чанараас болоод хүмүүс Бурхантай дайсагнадаг. Хуучин хүн Бурхантай дайсагнаж, Бурханы хуульд эс захирагддаг бөгөөд Бурханыг баярлуулах юм хийдэггүй. Хуучин хүнээсээ болоод хүмүүс үнэнээс илүүгээр алдаа завхралыг хүлээн авах хандлагатай байдаг.

Адамын мөн чанарын бузар мууд эдгэрэл үгүй. Хүн хэчнээн олон жил амьдралаа ч хуучин хүн нь сайжрахгүй. Эзэн Есүс хуучин хүнийг шинэчлэх, сайжруулах ажил хийдэггүй. Эсрэгээрээ, Голготын загалмайд түүнийг яллажээ. “Бурхан нүглийг шийдэхийн тулд Өөрийн Хүүг нүгэлт махбодтой адил байдалд илгээн, махбод дотор нүглийг шийтгэв.” (Ром 8:3) “Хуучин хүн маань түүнтэй хамт цовдлогдсон.” (Ром 6:6) Эдүгээ Бурхан итгэгч биднийг өөрсдийгөө үхсэнд тооцож амьдар гэдэг. Өөрөөр хэлбэл, үхсэн хүн шиг нүгэлд хариу үйлдэл үзүүлнэ гэсэн үг.

Ямар нэг зүйлийг болохгүй гэхээр хуучин хүн түүнийг хийхийг хүсдэг. Паул хуучин хүний энэхүү хандлагыг Ром 7:7-9 дээр бичжээ:

7 ... Хэрэв хууль «Чи бүү шунахайр» гэж хэлээгүй байсан бол би шунахайрлын учрыг мэдэхгүй байхсан. 8 Харин нүгэл нь тушаалаар шалтаглаж миний дотор зүсэн бүрийн шунахайрлыг төрүүлсэн. Учир нь хууль үгүй бол нүгэл нь үхмэл юм. 9 Нэгэн цагт би хуульгүйгээр

амьдарч байв. Харин тушаал ирснээр нүгэл амилж, би үхсэн....

Паул хуучин хүнийг нуруунд нь зүүгдсэн үхсэн цогцостой зүйрлэсэн. Ялзарч муудсан, өмхий ханхалсан цогцос гэсэн үг. Эл цогцос түүнийг хаа ч явсан дагаж, өөрийн эрхгүй “Би юутай хөөрхийлөлтэй хүн бэ! Хэн намайг үхлийн энэ биеэс ангижруулах вэ?” (Ром 7:24) гэж гаслахад хүргэжээ.

Хуучин хүн бол Адамын доторх бидний мөн чанар. Эзэн Есүс бидний үйлдсэн нүглүүдийн улмаас ч тэр, эл мөн чанарын төлөө ч тэр үхсэн. Энэ мэдээ үнэхээр сэтгэл онгойлгодог. Яагаад гэвэл, үйлдсэн алив нүглүүдээс маань ч илүү бидний доторх хүн нь их бузар муу билээ.

Бидний өгүүлсэн бүх зүйл үл итгэгчдийн заримдаа гаргадаг сайхан сэтгэл, элэгсэг, өгөөмөр занг үгүйсгээгүй шүү. Ийм зан чанарыг хэд хэдэн өнцгөөр тайлбарлаж болох юм. Төрөлх зан ааш байж болно. Эхийн сэтгэл гэх мэт. Эсвэл багаасаа сурсан хүмүүжил байж болно. Эсвэл дэлхийн гэрэл, газрын давс болох христитгэлийн нөлөө байж болно. Эсвэл авралд хүрэх гэсэн хичээл зүтгэл байж болно. Цаана нь ямар ч шалтгаан байлаа гэсэн нэг юм тодорхой. Аврагдаагүй хүний хамгийн эхний сайн үйлс нь Христэд итгэл найдвараа тавих билээ (Иох 6:39).

Шинэ хүн

Хүн дахин төрөхдөө шинэ хүнийг хүлээн авна. Тэр нь бурханлаг, тэнгэрлэг мөн чанар (2Пт 1:4)

буюу Христийн амь юм. Энэ мөн чанар Бурханаас төрдөг тул нүгэл үйлдэж чадахгүй (1Ио 3:9).

Шинэ хүний чанар нь сайн бөгөөд зөвхөн сайныг үйлддэг. Үүнийг Христийн мөн чанар гэж нэрлэж болно.

Шинэ хүн зөвхөн цэвэр ариунаар хооллодог. Бурханы үгэнд чин үнэнээр хариу үзүүлдэг. Эзэний хуульд баярладаг. Эзэний тушаалууд түүнд ачаа дарамт мэт санагддаггүй. Харин ч Эзэний тушаалуудыг баяртайгаар үйлддэг. Яг л эх хүнд үр хүүхдээ хайрла гэж хэлэхтэй адил санагддаг. Эх хүн үр хүүхдээ баяр хөөртэйгөөр хайрладаг шүү дээ.

Хоёр хүнийг Ноагийн бүхээгээс гаргаж нисгэсэн хэрээ ба тагтаатай зүйрлэж болно. Хэрээ усанд үйж үхсэн хүмүүсийн цогцсоор хооллож байсан тул эргэж ирээгүй. Харин шинэ хүнийг төлөөлдөг тагтаа амарч буух, хоол тэжээл олох шинэ, цэвэр газрыг олох хүртлээ буух газар байгаагүй тул Ноа руу буцаж ирсэн.

“Махбодоос төрсөн нь махбод, Сүнснээс төрсөн нь сүнс билээ.” (Иох 3:6) Эзэн Есүсийн энэ үг юутай үнэн бэ!

Хоёр хүний тэмцэл

Шинэ итгэгчийн дотор хоёр мөн чанар, хоёр хүн зэрэг оршдог. “Зүрх сэтгэлээс минь нүгэл зайлсан ч, өвөг дээдэс минь ясанд минь хэвээр.”

Хүн аврагдсан цаг мөчөөс эхлээд доторх хоёр хүн нь, хоёр мөн чанар нь хоорондоо тэмцэлдэж

эхэлнэ. Гайхах зүйл биш. Эсрэг тэсрэг хоёр зүйл нэг доор яаж энх тайвнаар орших билээ? Уг тэмцлийг Ребекагийн хэвлийд тэмцэлдсэн хоёр хүүхэдтэй зүйрлэж болох юм (Эх 25:22-23). Аргаа барсан Ребека “Ингээд байвал би яах вэ?” гэдэг. Паул энэхүү тэмцлийг Ром 7:14-25 дээр нүдэнд харагдтал дүрсэлжээ:

14 Хууль нь сүнслэг гэдгийг бид мэддэг. Харин би махбодтой бөгөөд нүглийн боолчлолд худалдагдсан. 15 Би юу үйлдэж байгаагаа өөрөө ч ойлгодоггүй. Учир нь би хийх хүсэлтэй зүйлээ хийдэггүй, харин үзэн яддаг зүйлээ хийж байна. 16 Хэрэв би өөрийн хүсдэггүй зүйлээ хийж байгаа бол, хуулийг сайн гэдгийг өөрөө зөвшөөрч буй юм. 17 Харин эдүгээ цаашид би биш, харин миний дотор оршин байгч нүгэл нь үүнийг үйлддэг юм. 18 Учир нь миний дотор буюу махбодод минь ямар ч сайн зүйл байдаггүйг би мэддэг. Учир нь миний дотор хүсэл байвч, харин сайныг хийх нь үгүй. 19 Би өөрийн хүсдэг сайныг хийдэггүй, харин хүсдэггүй бузар муугаа хэрэгжүүлдэг. 20 Хэрэв би өөрийн хүсдэггүй зүйлээ хийж байгаа бол цаашид би биш, харин миний дотор оршин байгч нүгэл нь үүнийг үйлддэг. 21 Ингээд сайныг үйлдэхийг хүсдэг миний дотор муу муухай нь байдаг гэсэн хуулийг би олж мэдлээ. 22 Би доторх хүнийхээ хувьд Бурханы хуульд баярладаг. 23 Гэвч эрхтнүүдэд минь өөр хууль байдаг бөгөөд тэр нь миний оюун ухааны хуультай дайтаж, намайг эрхтнүүдэд минь байдаг нүглийн хуулийн хоригдол болгодог

юм байна гэдгийг би харж байна. 24 Би юутай хөөрхийлөлтэй хүн бэ! Хэн намайг үхлийн энэ биеэс ангижруулах вэ? 25 Бидний Эзэн Есүс Христээр талархал нь Бурханд байх болтугай. Иймд нэг талаар би оюун ухаанаараа Бурханы хуульд үйлчилдэг боловч, нөгөө талаар би махбодоороо нүглийн хуульд үйлчилдэг.

Махбод ба Ариун Сүнсний тэмцэл - Хоёр мөн чанарын хооронд үүсдэг зөрчлийг яг хэлээгүй ч, төстэй асуудал:

Учир нь махбод Сүнсний эсрэг хүсдэг, Сүнс махбодын эсрэг хүсдэг юм. Юун гэвээс хүссэн юмсыг чинь хийлгэхгүйн тулд махбод, Сүнс нэг нэгнээ эсэргүүцдэг ажээ. (Гал 5:17)

Итгэгч хүн заримдаа хуваагдсан юм шиг мэдрэмжтэй явдаг нь гайхах зүйл биш. Ребека шиг, дотоод зөрчлөөсөө болж яахаа мэдэхгүй болдог нь жам ёсны асуудал бөгөөд Эзэнд итгэл найдвараа тавьж алхахад тэмцэл зогсоно гэж бодох нь буруу биш. Гэвч дайн улам ширүүсдэг. Итгэгчийн урмыг нь хугалах зүйл ч болно. Үнэхээр аврагдсан эсэхдээ ч эргэлзэх тохиолдол гарна.

Христитгэгч бүхэн, хамгийн төлөвшсөн итгэгч хүртэл тэмцэлтэй явдгийг мэдэх хэрэгтэй (1Ко 10:13). Энэ тэмцэл түүнийг нас барах хүртэл эсвэл Эзэн ирж авах хүртэл үргэлжилнэ. Энэ тэмцэл аврагдаагүйн нотолгоо бус, харин үнэхээр аврагдсаны баталгаа мөн.

Аль нь ялах вэ?

Дотор минь оршдог нүглийн хүчнээс чөлөөлөгч нь Ариун Сүнс (Гал 5:17). Хамгийн бурханлаг итгэгчийн дотор ч нүглийг ялах хүч үгүй. Гэхдээ итгэгч хүн Ариун Сүнсэнд дуулгавартай байж, Түүнтэй хамтран ажиллах шаардлагатай.

Аль мөн чанар ялахыг итгэгч өөрөө шийддэг. Алийг нь тэжээхээ өөрөө шийднэ гэсэн үг. Махбодын мөн чанарыг зурагт, кино, дэлхийн зугаа цэнгэлээр тэжээхээд шинэ хүнээ сайн ажиллана гэж горьдолтгүй. Чоныг тэжээхээд хонийг ялна гэж бодолтгүй.

“Хүсэл тачаалыг нь хангах юугаар ч махбодыг бүү тэтгэ.” (Ром 13:14) “сэтгэлийн чинь эсрэг дайтдаг махбодын хүсэл тачаалуудыг цээрлэ.” – Итгэгчдэд яагаад ингэж хэлснийг бодох л асуудал.

Итгэгч хүн Библид, залбиралд, Эзэний үйлчлэлд олон цагийг зарцуулж, ариун амьдралд хөтлөх бүхнээс зуурч явах үүрэгтэй.

Шалтаг бүү хэл!

Бид нүгэл үйлдсэн буруугаа хуучин хүн, махбодын мөн чанар руугаа чихэх ёсгүй. Энэ бол явуургүй, явцгүй залийн хэлбэр бөгөөд Бурхан мөн чанарт бус, танд өөрт чинь хариуцлага тооцохыг бүү мартаарай.

Нүгэл үйлдэх шалтаг олох амархан. Энэ нь таны эсэргүүцэх чадварыг бууруулна.

Дүгнэлт

Бидний дотор хоёр өөр мөн чанар оршдогийг Библи ч хэлж байна, хувийн туршлага маань ч хэлж байна. Хэчнээн үгүйсгэлээ гээд хоёр өөр мөн чанар таны дотор байж л байгаа. Итгэгчид үүнийг олж харахгүй бол зөрчил дотор амьдарна. Үнэхээр аврагдсан эсэхдээ эргэлзэж, ялагдаж амьдрах аюултай.

Шийдэл нь тэгвэл юу вэ? Миний дотор бузар муу мөн чанар оршин байгааг хүлээн зөвшөөрч, түүнд үхсэн мэт хандаж, өөрийгөө Ариун Сүнсний удирдлагад бүрэн захируулах. Ингэж чадвал махбодын хүсэл тачаалыг биелүүлэхгүй амьдарч чадна (Гал 5:16).

ЕС

АРИУСГАЛЫН ТӨРЛҮҮД

“Ариусгах” гэж Библийн утгаар “тусгай зорилгод ашиглахаар тусгаарлаж авах” гэсэн үг. Бурханы үйлчлэлд ашиглахын тулд жирийнээс эсвэл бузраас салгах үйл явцыг нэрлэх зарим тохиолдол байдаг ч дандаа биш. Хэрэв та ариусгахыг “тусгай зорилгод ашиглахаар тусгаарлаж авах” гэсэн утгаар ойлговол энэ үг, ухагдахуун орсон бүх хэсгийг зөв ойлгож чадна.

Хуучин гэрээнд: Бурхан долоо дахь өдрийг ариусгасан (Эх 2:3). Хүн болон мал амьтны уугануудыг Эзэнд ариусгасан (Гэт 13:2). Тахилчид өөрсдийгөө Эзэнд зориулан ариусгах үүрэгтэй байлаа (Гэт 19:22). Синай уулыг ариусгасан (Гэт 19:23). Уулзалтын майхан ба түүний эдлэл хэрэгслийг ариусгасан (Гэт 40:9). Исаиа 66:17 эшлэлд хүмүүс хуурамч шүтээнд мөргөх гэж өөрсдийгөө ариусгасан тухай бичсэн байдаг.

Шинэ гэрээнд ариусгалыг ихэвчлэн хүмүүстэй холбож ярьсан. Гэхдээ цөөн тохиолдолд эд юмс дээр хэрэглэсэн. Тухайлбал: Сүм нь өөр дээрх алтыг, тахилын ширээ нь өөр дээрх өргөлийг ариусгана гэж Есүс айлдсан (Мт 23:17, 19). Хоолныхоо төлөө талархахад хоол маань Бурханы үг ба залбирлаар ариусгагдана гэж Паул бичсэн (1Тм 4:5).

Хүмүүсийн ариусгалын тухайд гэвэл: Бурхан Христийг ариусгаж дэлхий рүү илгээжээ (Иох 10:36). Нэг ёсондоо Эцэг биднийг нүглүүдээс

маань аврах ажилдаа Хүүгээ тусгайлан сонгож томилсон гэсэн үг. Есүс Өөрийгөө ариусгасан (Иох 17:19). Өөрөөр хэлбэл, хүмүүсийн Зууч болохын тулд Эзэн Есүс Өөрийгөө тусад нь тавьжээ.

Үл итгэгчид ариусгагдах тохиолдол бас байдаг аж: “Учир нь үл итгэгч нөхөр нь эхнэрээрээ ариусгагдсан байна. Үл итгэгч эхнэр нь итгэгч нөхрөөрөө ариусгагдсан байна.” (1Ко 7:14) Үл итгэгч нөхөр эсвэл эхнэр нь итгэгч ханийнхаа нөлөө, өөрийнх нь авралын төлөөх залбирлын ачаар Христ рүү ирэх боломж байх учраас бусдаас “тусдаа” гэсэн утгатай.

Христ бүх итгэгчдээр ариусгагддаг: “Христ Эзэнийг зүрхэндээ тусгаарлан нандигна (буюу ариусга)” (1Пт 3:15). Христийг амьдралынхаа цор ганц Эзэн хэмээн зүрхэндээ нандигнаснаар Түүнийг ариусгаж байна гэсэн үг юм.

Дээрх бүхэн дээр нэмээд, Шинэ гэрээг судлахдаа ялгаа салгааг нь олж харах ёстой дөрвөн төрлийн ариусгал бий. Үүнд: (1) Христэд итгэхээс өмнөх ариусгал; (2) Байр суурийн ариусгал; (3) Үйл явц бүхий ариусгал; (4) Төгс ариусгал.

Христэд итгэхээс өмнөх ариусгал

Хүн дахин төрөхөөс өмнө Ариун Сүнс амьдралд нь ажиллаж, түүнийг энэ дэлхийгээс тусгаарлан авч, Христ рүү хөтөлдөг. Төрөхөөс нь ч өмнө Бурхан өөрийг нь сонгон тусгаарласныг Паул мэддэг байв (Гал 1:15). Элч Паул, авралд

гурван үе шат байдгийг тесалоникчуудад сануулан бичжээ (2Тс 2:13):

1. Бурхан сонгосон
2. Ариун Сүнс ариусгасан
3. Тэд үнэнд итгэсэн

Энэ ариусгал тесалоникчуудыг итгэж аврагдахаас өмнө болсон гэдгийг анзаараарай.

1Петр 1:2 дээр авралын үйл явцыг дараах байдлаар дараалуулан бичсэн:

1. Бурхан Эцэг сонгосон
2. Ариун Сүнс ариусгасан
3. Есүс Христэд дуулгавартай байх
4. Христийн цусаар цацуулах

Өнө мөнх ахуйд Бурхан биднийг Христийн дотор сонгон авчээ (Еф 1:4). Цаг хугацаат ахуйд Ариун Сүнс биднийг тусгаарлан авсан. Тэгээд бид сайнмэдээнд дуулгавартай хандсан. Сайнмэдээг хүлээн авсан даруйд Христийн урсгасан цусны үнэ цэнэ бидэнд тооцогдсон. Эндээс анхаарч үзэх ёстой зүйл гэвэл, биднийг дахин төрөхөөс өмнө эл ариусгал болж өнгөрсөн гэдгийг Петр ярьсан байна.

Байр суурийн ариусгал

Хүн дахин төрсөн мөчөөс байр суурийн хувьд ариун болдог. Бурханы өмнө зогсох байр суурийн хувьд “Христийн дотор” байдаг учраас, энэ дэлхийгээс Бурханд бүрэн тусгаарлагддаг. Үнэндээ Христ Өөрөө тэр хүний ариусгал болжээ (1Ко 1:30).

Жинхэнэ итгэгч бүр ариун хүн мөн. Тэрээр Эзэнд тусгаарлагдсан нэгэн бөгөөд энэ нь түүний байр суурь. Тийм болохоор 1Коринт 1:2 дээр Коринтын чуулганы бүх итгэгчийг “ариун хүмүүс байхаар дуудагдсан, Христ Есүс дотор ариусгагдсан хүмүүс” хэмээн дууджээ. Бодит байдал дээрээ Коринтын итгэгчид ариун байсан уу гэвэл үгүй. Тэд чуулгандаа байж боломгүй нүглийг хүлцэн байлгаж (1Ко 5:1-2), бие биеийнхээ эсрэг шүүхэд зарга мэдүүлж (1Ко 6:1), зарим багш нь Христийн амиллыг үгүйсгэсэн сургаал номлож байв (1Ко 15:12-14). Тэглээ гээд, Бурханы өмнө зогсох байр суурь нь өөрчлөгдөөгүй бөгөөд тэд Христ Есүс дотор ариусгагдсан ариун хүмүүс байлаа.

Одоо бүгдээрээ байр суурийн ариусгалын тухай бичсэн зарим эшлэлийг харцгаая. Үйлс 20:32 дээр “ариусгагдсан бүхэн” гэсэн үг бүх итгэгчийг хэлж байна. Үйлс 26:18 дээр Эзэн Өөрийнхөө хүмүүсийг “Надад итгэх итгэлээр ариусгагдагсад” гэж нэрлэсэн. Коринтын итгэгчдийг “Эзэн Есүс Христийн нэрээр болон Бурханы маань Сүнс дотор угаагдсан, ариусгагдсан, зөвтгөгдсөн” (1Ко 6:11) гэж тодорхойлсон. Еврей номын бичээч, “Бид Есүс Христийн, бүгдийн төлөө нэгмөсөн бие өргөсөн өргөлөөр ариусгагдсан юм” (Евр 10:10) гэж сануулаад бас “Учир нь Тэр ариун болгогдогсдыг ганц тахилаар үүрд төгс болгожээ” (Евр 10:14) хэмээн мэдэгдсэн. Колоссай 3:12 дээр Паул христитгэгчдийг “ариун” гэж

дуудахдаа Бурханы өмнө зогсох энэ л “ариун” байр суурийг хэлсэн юм.

Үйл явц бүхий ариусгал

Библи бүх христитгэгчийг ариусгагдсан, ариун гэж олонтоо ярьдаг мөртлөө, нөгөө талд биднийг ариун бай, ариус гэж олонтоо хэлдэг. Хэрэв бид ариусгалын төрлүүдийг ялгаж салгахгүй бол үүнд толгой эргэн будилах бөгөөд Бурханы үг хоорондоо зөрчилдөж байна гэж бодно.

Бид Бурханы өмнө “ариун” хэмээх байр суурь буюу статустай гэдэг нь байр суурийн ариусгал юм. Харин бодит амьдрал дээр ариун байдлыг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг нь өөр асуудал бөгөөд үүнийг “үйл явц бүхий ариусгал” гэж нэрлэдэг. Өдөр тутмын амьдралдаа нүглээс зайлсхийж, бузар муугаас зугтан, өөрсдийгөө Бурханд тусгаарлаж амьдрах тухай ярьж байгаа юм.

Эзэн Есүс өөрийнхнийхөө төлөө залбирахдаа “Үнэнээр тэднийг ариусгаач. Таны үг бол үнэн мөн” (Иох 17:17) гэсэн нь энэ төрлийн ариусгал юм.

Энэ төрлийн ариусгалд итгэгчийн өөрийнх нь хамтын ажиллагаа, оролцоо шаардлагатай (2Тм 2:21). Ариусгал ба ариун байдлын талаар уриалга байвал үйл явцын ариусгалыг ярьж байна гэж ойлгох хэрэгтэй. Паул коринтчуудад ийм уриалга хэлснийг үзье: “Хайртууд минь,...өөрсдийгөө махбодын ба сүнсний бүхий

л бохиросоос цэвэрлэе. Ингэхдээ Бурханаас эмээж, ариун чанарыг төгс болгоё.” (2Ко 7:1) Петр бас ижил хандлагаар бичсэнийг харъя: “Та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун.” (1Пт 1:15)

Амьдралын турш үргэлжлэх үйл явц бүхий ариусгалын нэг чухал талбар нь садар самуунаас тусгаарлагдах явдал билээ:

Бурханы хүсэл нь та нарын ариусал бөгөөд тэр нь юу гэвэл, та нар садар самууныг цээрлэж, хүн бүр ариусал хийгээд хүндэтгэл дор өөрийн биеэ хэрхэн хянахаа мэд. (1Тс 4:3-4)

Христитгэгч хэрхэн илүү ариун, урьд өмнөхөөсөө илүү Эзэн Есүстэй адил болох вэ? Хариулт нь 2Коринт 3:18 дээр байна:

Харин бид бүтээлэггүй нүүрээрээ Эзэний алдрын тусгалыг тольдох мэт хараад, Түүний дүрд Эзэний Сүнсээр алдраас алдарт өөрчлөгддөг.

Сэтгэл зүрх маань Эзэн Есүсээр хэр хэмжээнд эзэмдүүлнэ, тэр чинээгээр амьдралын ариун байдал ирнэ. Юуг шүтнэ, түүн шигээ болдог гэх амьдралын зарчимтай адил. Христээр бодол санаагаа дүүргэх тусам, улам Христ шиг болно. Ариун Сүнс энэхүү гайхалтай өөрчлөлтийг үйлдэгч нь. Гэхдээ нэг дор биш. Харин нэг алдрын түвшингөөс нөгөө рүү өсөх зарчмаар өөрчилдөг.

Төгс ариусгал

Энэ ариусгал ирээдүйд итгэгч биднийг хүлээж байна. Бид Аврагч Эзэнтэйгээ нүүр нүүрээрээ уулзах мөчид нүгэл ба бузраас бүрмөсөн ангижирч, ариун чанараараа Эзэн Есүстэй адил болж, төгс ариусна.

Колоссай 1:22 дээр энэхүү ариусгалыг ярьсан байна: “...одоо бол Тэрээр, өмнөө [мэлмийдээ] та нарыг ариун, өө сэвгүй бөгөөд гэм зэмгүй болгохын тулд махбодынхоо үхлээр эвлэрүүлсэн.”

Тэр өдөр чуулган ямар ч өө сэвгүй, төгс ариун болно: “...түүнийг ямар ч толбо, үрчлээсгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн билээ.” (Еф 5:27)

Ариусгал гэж ороогүй ч утга санаагаар төгс ариусгалын тухай ярьсан эшлэлүүд бас бий. Тухайлбал Иохан ингэж бичжээ: “...Түүнийг илчлэгдэхэд бид Түүнтэй адил болно. Учир нь бид Түүнийг байгаагаар нь харна.” (1Ио 3:2). Бидний Эзэн биднийг “Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, өө сэвгүйгээр” (Иуд 24) зогсоох болно гэж Иуда бичсэн байна.

Дүгнэлт

Ариусгалын төрлүүдийг ялгаж салгах нь Библи судлалд маань нэн тустай. Ариун байдлын тухай хэсэг таарвал өөрөөсөө “Намайг Христэд итгэхээс өмнө болсон үйл явдал уу? Эсвэл

Христийн дотор ямар гэдгийг минь хэлж байна уу? Эсвэл Өдөр тутмын амьдралдаа ямар байх ёстойг минь хэлж байна уу? Эсвэл Эзэн Есүс Христийн цог жавхлант оршихуйд очих үед ямар болохыг минь ярьж байна уу?” гэж асуугаарай.

АРАВ

АРИУН СҮНС – ДОТОР ОРШИХ, БАПТИСМ ХҮРТЭЭХ, ДҮҮРГЭХ

Ариун Сүнсний тухай сургаалыг судлахдаа хэд хэдэн чухал ялгааг заавал мэдэх хэрэгтэй. Ариун Сүнс бидний дотор оршин суух, бидэнд баптисм хүртээх, биднийг дүүргэхийн ялгааг олж харах, цаашлаад Сүнсний баптисм ба галан баптисмын ялгааг, мөн Бурханы эрх мэдлээр хэрэгждэг дүүргэлт ба биднээс шалтгаалдаг дүүргэлтийн ялгааг ойлгох ёстой.

Итгэгчийн дотор Ариун Сүнс оршдог

Хүн дахин төрөх мөчид Бурханы Ариун Сүнс биед нь орж, дотор нь оршин сууж эхэлдэг (1Ко 6:19): “Та нарын бие бол Бурханаас та нарт буй, дотор чинь байдаг Ариун Сүнсний сүм бөгөөд та нар ч өөрсдөө өөрсдийнх бус гэдгээ мэддэггүй юм уу?” Дотроо Ариун Сүнсгүй хүн үнэндээ христитгэгч биш (Ром 8:9б). Бурханы гурвалын гурав дахь Бодгаль болох Ариун Сүнс хүний дотор оршин сууж эхэлсэн бол хэзээ ч орхиж явахгүй (Иох 14:16). Дотор минь Ариун Сүнс байгааг хэрхэн мэдэх вэ? Бурханы үгэнд хэлсний дагуу мэднэ. Тэгээд явцын дунд, амьдралд минь ургуулж буй үр жимсээр нь мэдэж болно. Ариун Сүнс дотор минь байлаа гээд заавал ямар нэг мэдрэмж төрөх албагүй. Ариун Сүнснийг ирээч, үлдэж хамт байгаач гэж залбирах талаар Библид

хэлсэн нэг ч үг үгүй. Эзэн Есүс Христэд итгэх мөчид Ариун Сүнс бидний дотор орж ирдэг.

Сүнсний баптисм

Сүнсний баптисмын талаар бичсэн гол эшлэл нь IКоринт 12:13:

Учир нь иудейчүүд эсвэл грекүүд, боолууд эсвэл эрх чөлөөт хүмүүс ч ялгаагүй бид бүгд нэг Сүнсээр нэг бие уруу баптисм хүртэж, нэг Сүнсийг уусан юм.

Сүнсний баптисм нь итгэгчийг Христийн биед буюу чуулганд оруулах Ариун Сүнсний үйлчлэл болохыг дээрх эшлэл тодорхой харуулж байна. Ариун Сүнсний баптисм хамгийн анх Пентэкостын өдөр чуулган байгуулагдахад тохиолдсон. Тэр цагаас хойш хэн нэг хүн Христ рүү эргэх болгонд тэр хүн Сүнсний баптисмаар чуулганы нэг хэсэг болдог болсон.

Нэг ёсондоо, бүх итгэгч гарал угсаа, соёлоосоо үл хамааран энэхүү баптисмыг хүртжээ. Сүнсний баптисм дахин төрөлттэй зэрэг болдог. Дараа нь биш. Христитгэлийн амьдралд ахин давтагдах шаардлага байхгүй.

Бурханы үгэнд Сүнсээр баптисм хүрт гэсэн тушаал үгүй. Аврагчийг нүгэлтэн хүлээн авах мөчид Сүнсний баптисм автоматаар хийгддэг. Үүнд ямар нэг сэтгэл хөдлөл мэдрэгдэх албагүй. Онцгой мэдрэмж төрдөггүй. Гагцхүү Библид хэлсэн учраас энэ үйл явдал болсныг бид баттай мэдэж чадна.

Галан баптисм

Галаар баптисм хүртэх нь Сүнсний баптисмтай ижил нэг зүйл биш. Энэ нь ивээл ерөөлийн бус, шийтгэлийн баптисм юм.

Баптисч Иохан, итгэгч ба үл итгэгч холилдсон хүмүүст номлохдоо “Тэр [Христ] та нарт Ариун Сүнс хийгээд галаар баптисм хүртээнэ” (Мт 3:11; Лк 3:16) гэж хэлээд галан баптисм нь Бурханы шүүлт гэдгийг тайлбарласан:

Тэр гартаа шигшигч сэрээтэй бөгөөд үтрэмээ гүйцэд цэвэрлээд, буудайгаа саравчинд овоолж, харин хальсыг нь унтаршигүй галаар шатаана. (Мт 3:12; Лк 3:17)

Галан баптисм бол шийтгэл гэдгийг хам сэдэв нь тайлбарлаж байна. Сэтгэл хөдлөл, гал мэт мэдрэмж, эрч хүч биш.

Баптисч Иохан, дан итгэгчдээс бүрдсэн хүмүүст номлож байхдаа “Тэр та нарт Ариун Сүнсээр баптисм хүртээнэ” (Мк 1:8; Иох 1:33) гэжээ. Энэ үедээ галын тухай юм дурдаагүй.

Сүнсний баптисм бол итгэгчдийн өнгөрсөн. Галан баптисм нь үл итгэгчдийн ирээдүй.

Ариун Сүнсээр дүүрэх хоёр өөр хэлбэр

Шинэ гэрээнд Ариун Сүнсээр дүүрэх хоёр хэлбэрийг ярьсан. Үүнийг ойлгоогүй цагт энэ сэдэв дээр Библийг хэрхэн зөв ойлгохоо мэдэхгүй будилдаг.

Нэг дэх хэлбэр нь “Бурханы эрх мэдлээр” хэрэгждэг дүүргэлт. Жишээ нь Баптисч Иохан “эхийн хэвлийд байхаасаа л Ариун Сүнсээр

дүүрсэн” (Лк 1:15) байв. Эхийн хэвлийд байгаа Иохан Сүнсээр дүүрэхийн тулд ямар нэг юм хийгээгүй нь тодорхой. Мессиагийн замыг засах онцгой үйлчлэлд баптисм хүртээгчийг бэлтгэхийн тулд Бурхан Өөрийн эрх мэдлээр Иоханыг Ариун Сүнсээр дүүргэжээ.

Хүний оролцоогүй шууд Бурханы эрх мэдлээр хэрэгжиж, Ариун Сүнс дүүрсэн тохиолдлууд Үйлс номд хэд хэд гарна. Хоёр жишээг эш татъя:

Зөвлөлийн өмнө зоригтой гэрчлэхэд Петрийг бэлдэж, Бурхан түүнийг Ариун Сүнсээр дүүргэсэн (Үйл 4:8-12).

Эзэн, Паулыг Сүнсээр дүүргэсэн учир, элч маань шидтэн Елумын хорлонтой няцаалтыг зогсоож чадсан (Үйл 13:9-11).

Сүнсээр дүүр

Ариун Сүнсээр дүүрэх хоёр дахь хэлбэр эхнийхээсээ өөр. Энэ нь итгэгч бүхэнд өгсөн тушаал. Тийм болохоор бидний хяналтаас гадуур зүйл биш. Үүнийг хэлсэн гол эшлэл нь Ефес 5:18: “Дарсанд бүү согтуур. Эс бөгөөс хэт самуурал буй. Харин Сүнсээр дүүр.”

Энд гарч буй “дүүрэх” гэдэг үйл үг нь Ариун Сүнсний нэг удаагийн хүчтэй хөдлөлийг бус, тасралтгүй үргэлжлэх үүргийг илэрхийлдэг.⁶

⁶Библийн грек хэлэнд захиран тушаах хэвийн хоёр хэлбэр байдаг. Эхнийх нь нэг удаагийн үйлдлийг тушаах. Хоёр дахь нь буюу энэ эшлэлд хэрэглэсэн нь үргэлжлүүлэх, үйлдлээ давахыг тушаах хэв юм. Тиймээс “дүүрсээр бай” гэж орчуулбал эх утгад нь илүү ойртох болов уу.

Үүнийг дарсанд согтуурах мансуурлын хөөрөлтэй эсрэгцүүлэн тавьжээ. Харьцуулаад хараарай:

Дарсанд согтуурах	Сүнсээр дүүрэх
Утга учиргүй яриа	Христийг хүндэтгэсэн цэвэр ариун үг яриа
Тогтворгүй алхах	Тодорхой зорилготой зөв үйлдэл хийх
Мансууруулах бодисын нөлөөнд байх	Ариун Сүнсээр удирдуулах
Биеэ захирах чадваргүй	Биеэ захирах чадвартай
Садар самуунд автах	Садар самуунаас ангид байх
Нүглийг эсэргүүцэх хүчгүй	Нүглийг эсэргүүцэх хүчтэй
Олны жигшил, ичгүүр	Хүндтэй, үлгэр дуурайлтай
Урам хугарах	Урам зоригтой

Сүнсээр хэрхэн дүүрэх вэ?

Ариун Сүнсээр дүүрэхийн тулд тодорхой нөхцөлүүд хангагдсан байх ёстой гэдгийг өмнө нь дурдсан. “Ерөөлийн зам дээр өөрсдийгөө тавих ёстой” гэдэг үг ч бий. Тэгвэл ямар нөхцөлүүд бүрдэж, Ариун Сүнсээр дүүрэхэд юу шаардлагатай вэ?

- Хойшлуулалгүйгээр нүглээ улайж, нүглээсээ гэдрэг эргэ (1Ио 1:9; Сур 28:13)
- Өөрийн биеийг Христэд байнга амьд тахил болгон өргө (Ром 12:1-2)

- Өөрийгөө Бурханы үгээр дүүргэ (Кол 3:16)
- Мөргөл, залбиралд олон цагийг зарцуул (2Ко 3:18; Мт 7:7)
- Христитгэгчдийн нөхөрлөлтэй ойр бай (Евр 10:25)
- Бүгдийг Бурханы алдрын төлөө хий (1Ко 10:31)

Ариун Сүнсээр дүүрсэн хүн үүнийгээ зарлаад байдаггүй. Харин ч өөрийгөө дарж, Христийг өргөдөг (Иох 3:30; 16:14). Сүнсээр алхах тусам хүн өөрийнхөө өчүүхэн доройг, хэн ч биш болохоо ухаарч ойлгодог.

Сүнсээр дүүрэх нь сэтгэл хөдлөл бус, ариун байдал гэдгийг санаж яваарай. Христитгэлийн амьдралын бусад олон талбарт байдаг шиг, Сүнсээр дүүрэх нь ч сэтгэл хөдлөлийг агуулдаг боловч сэтгэл хөдлөл гол нь биш. Хүмүүний мэдрэмж маань Бурханы Сүнсээр дүүрэхийн дайвар бүтээгдэхүүн төдий юм.

Эцэст нь хэлэхэд

Итгэгч хүн магадгүй бидний дээр дурдсанд илэрхийлэгдээгүй, Ариун Сүнсний хүчтэй хөдлөлийг амсаж мэдэрсэн байж болно. Жишээ нь Эзэнээс хөндийрсөн байгаад буцаад Эзэн рүү ирэхдээ эсвэл өөрийгөө Эзэнд шинээр, илүү эрч хүчтэйгээр зориулж эхлэх үед ч юм уу. Ийм туршлагыг үлэмж хүсүүштэй бөгөөд сэтгэл маш ихээр хөдөлдөг нь үнэн. Гэхдээ энэ нь Ариун Сүнс орж ирж байгаа юмуу Ариун Сүнсний баптисм биш гэдгийг бүү мартаарай. Эл

туршлага нь Ариун Сүнсний дүүргэлт рүү хөтлөх нэг шат байж болох ч, Ариун Сүнсний дүүргэлт нэг удаагийн үйл явдал биш, үргэлжлэх үйл явц гэдгийг бас санах нь чухал. Ариун Сүнсний ямар нэгэн үйлчлэлийг сүнслэг амьдралын өөр талуудыг илэрхийлдэг Библийн үг хэллэгээр буруу тодорхойлох нь гагцхүү сургаалын төөрөгдөл будилаан үүсгэх аюултай.

АРВАН НЭГ АВРАЛ БА ҮЙЛЧЛЭЛ

Бурханы үгийг судлахдаа авралтай холбоотой хэсгүүдийг христитгэгчийн амьдрал, үйлчлэлийн тухай хэсгүүдээс ялгаж салгавал бид олон алдаа төөрөгдлөөс өөрсдийгөө аварч чадна.

Авралтай холбоотой хэсгүүд

Ерөнхийдөө авралтай холбоотой хэсгүүдийг танихад хэцүү биш. Уг хэсгүүд дараах баримтуудыг байнга гаргаж тавьдаг:

Бурханы оролцоог яривал, аврал нигүүлслээр ирдэг:

Христ Есүсийн золилтоор дамжин Бурханы нигүүлслээр үнэгүй зөвтгөгджээ. (Ром 3:24)

Христийн оролцоог яривал, Голготын загалмай дээр нүгэлтнийг орлосон Түүний үхэл, авралын ажлаар хүмүүнд аврал боломжтой болсон:

Нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө Тэрээр нүгэл болгосны учир Түүний дотор бид Бурханы зөвт байдал болох юм. (2Ко 5:21)

Хүний оролцоог яривал, авралыг хуулийн үйлсээр бус, итгэлээр авна:

Гэлээ ч бид аливаа хүн хуулийн үйлсээр бус, харин Христ Есүст итгэх итгэлээр зөвтгөгддөгийг мэднэ. Тиймээс бид хуулийн үйлсээр бус, харин Христэд итгэх итгэлээр зөвтгөгдөхийн тулд Христ Есүст итгэсэн шүү дээ. Яагаад гэвэл хуулийн үйлсээр зөвтгөгдөх махбод гэж үгүй. (Гал 2:16)

Авралын баталгааг яривал, итгэгч хүн Бурханы үгийн эрх мэдлээс аврагдсанаа баттай мэдэх боломжтой:

Та нар мөнх амьтай гэдгээ мэдээсэй гэсэндээ би Бурханы Хүүгийн нэрд итгэдэг та нарт үүнийг бичлээ. (1Ио 5:13)

Аврал алдагдахгүйн баталгаа, найдвартай байдлыг яривал, Бурханы хүүхдүүд хэзээ ч мөхөхгүй бөгөөд нүглээсээ болж мөнхийн шийтгэл амсахгүй:

²⁷ Миний хоньд дууг минь сонсдог. Би тэднийг таньдаг бөгөөд тэд Намайг дагадаг юм. ²⁸ Би тэдэнд мөнх амийг өгнө. Тэд хэзээ ч мөхөхгүй бөгөөд тэднийг хэн ч гараас минь булаахгүй. ²⁹ Тэднийг Надад өгсөн Эцэг минь бүхнээс аугаа бөгөөд тэднийг хэн ч Эцэгийн гараас булааж чадахгүй. (Иох 10:27-29)

Үйлчлэлтэй холбоотой хэсгүүд

Хүмүүсийн хамгийн их будилдаг нь христитгэгчийн үйлчлэл, амьдралтай холбоотой хэсгүүдийг авралтай холбон тайлбарладаг явдал юм. Тухайлбал Иохан 15:1-11:

¹ Би бол усан үзмийн жинхэнэ мод, Эцэг минь усан үзэм тариалагч билээ. ² Миний дотор байгч, жимс ургуулдаггүй мөчир бүрийг Тэр авч хаяна. Жимс ургуулдаг мөчир бүрийг их жимстэй болгохын тулд Тэр тайрч арчилдаг. ³ Миний хэлсэн үгээр та нар хэдийнээ цэвэр болжээ. ⁴ Миний дотор байгтун. Би ч та нарын дотор байна. Усан үзмийн модонд холбогдохгүй бол

мөчир өөрөөсөө жимс ургуулж чадахгүйн адил та нар Миний дотор байхгүй бол тийм байх болно. ⁵ *Би бол усан үзмийн мод, та нар мөчрүүд. Хэн Миний дотор байж, Би мөн түүний дотор байна, тэр их жимс гаргана. Учир нь Надаас ангид та нар юу ч хийж чадахгүй.* ⁶ *Хэн нэг нь Миний дотор эс байваас мөчир мэт хаягдаж, хувхайрна. Тэдгээр мөчрийг түүж, галд хаяж шатаана.* ⁷ *Та нар Миний дотор, Миний үгс та нарын дотор байваас та нар юу хүссэнээ гуй. Тэгвэл та нарт биелэх болно.* ⁸ *Та нар их жимс гаргаж, Миний шавь нар болоход Эцэг минь алдаршина.* ⁹ *Эцэг Намайг хайрласны адил Би бас та нарыг хайрласан. Хайранд минь байгтун.* ¹⁰ *Би Эцэгийнхээ тушаалыг сахиж, хайранд нь байдаг лугаа адил, та нар тушаалыг минь сахивал хайранд минь байх болно.* ¹¹ *Миний баяр баясгалан та нарт байж, та нарын баяр баясгалан дүүрэн болохын тулд үүнийг Би та нарт хэлэв.*

Энд тамаас аврагдах тухай бус, үр жимс ургуулах тухай өгүүлжээ. Христитгэгч амьдралдаа Сүнсний үр жимсийг ургуулах тухай ярьжээ (Гал 5:22-23). Энд нүгэлтэнд Аврагч хэрэгтэй гэсэнгүй. Харин ариун хүмүүс Христтэй адил байх ёстойг сануулж байна. Үүнийг ойлгохгүй бол, христитгэгчид тамын галд хаягдах боломжтой гэсэн буруу дүгнэлтэд хүрнэ. Бурханаас холдож хөндийрсөн итгэгчийн нэр төр, гэрчлэлийг энэ дэлхий гутаадаг гэдгийг Иохан 15:6 дээр зүйрлэлээр илэрхийлэхдээ уг

мөчрийг галд хаяж шатаана гэсэн юм. Хэрэггүй хог мэт гал руу хаяна. Модтойгоо холбогддоггүй мөчирт (итгэгчид) үл итгэгчид тийнхүү хандана.

Буруу ойлгогддог өөр нэгэн хэсэг бол I Коринт 3:10-15:

¹⁰ *Надад өгөгдсөн Бурханы нигүүлслийн дагуу би мэргэн барилгачин мэт суурь тавьсан бөгөөд өөр нэгэн түүн дээр барьж байна. Гэхдээ түүн дээр яаж барихаа хүн бүр анхаарагтун.* ¹¹ *Учир нь тавигдсан суурь болох Есүс Христээс өөр суурийг хэн ч тавьж чадахгүй.* ¹² *Хэрэв хэн нэгэн энэ суурин дээр алт, мөнгө, эрдэнийн чулуу, мод, өвс болон сүрлээр баривал* ¹³ *ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Юу гэвээс энэ нь галаар илчлэгдэх ба гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно.* ¹⁴ *Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэрээр шагналаа хүлээн авна.* ¹⁵ *Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана.*

Арван нэгдүгээр эшлэл авралын тухай бөгөөд Эзэн Есүс Христ л ганцаараа зөв суурь гэдгийг зааж байна. Бусад хэсэг нь уг суурин дээр барилга барих тухай буюу хүн аврагдсаныхаа дараа хийдэг христэч үйлчлэлийг ярьж байгаа юм. Итгэгч хүн галаар шалгуулна гэсэн үг огт алга. Харин түүний ажил галд шалгуулна гэжээ. Итгэгч хүн өөрөө шатахгүй, харин ажлууд нь шатна. Энд авралд хүргэдэг итгэлийн тухай бус,

шагнал авах уу эсвэл шагналаа алдах уу гэдгийг ярьсан.

Паулын үгсээс өөр нэгэн жишээг IКоринт 9:24-27-аас харцгаая:

²⁴ Уралдааны замд гүйгчид бүгд гүйдэг ч нэг нь л шагнал хүртдэгийг та нар мэдэхгүй гэж үү? Та нар ялахын тулд гүйцгээ. ²⁵ Тэмцээнд өрсөлдөгч бүр бүх талаар биеэ захирах чадварт өөрийгөө дасгалжуулдаг аж. Тэд муудах титэм хүртэхийн төлөө бол, харин бид үл муудах титмийн төлөө юм. ²⁶ Тиймээс би зорилгогүй мэт гүйдэггүй, хий агаар цохих мэт нударгалдаггүй, ²⁷ харин ч бусдад тунхагласан атлаа өөрөө тэнцээгүй байх вий гэсэндээ биеэ залхааж, боолчилдог.

Сүүлийн эшлэлд Паул, барианд очиход “тэнцээгүй байх” боломжтой тухай ярьсан. Хам сэдэв нь авралын тухай бус, христэч амьдралд өөрийгөө захирч явах тухай байна. Паул, Христийн дотор Бурханд хүлээн авагдсан хүн байж, авралд тэнцэхгүй болчихно гэж үгүй. Харин өөрийгөө захирдаггүй, сахилга батгүй байвал, үйлчлэлд, шагналд тэнцэхгүй болчих боломжтой ажээ.

Бурханы үгс хоорондоо хэзээ ч зөрчилддөггүй. Гагцхүү ялгаа салгааг зөв мэдэх хэрэгтэй. Авралын тухай юу эсвэл үйлчлэлийн тухай юу гэдэг ялгааг зөв таньж гэмээнэ Шинэ гэрээнд хоорондоо зөрчилдөөд байгаа мэт хэсгүүд учир зүйндээ орно.

Дахиад нэг жишээ татъя. Эзэн Есүс, Матай 12:30 дээр “Надтай хамт байдаггүй нь Миний эсрэг байна. Надтай хамт хураалцдаггүй нь тараагч нэгэн мөн” гэж айлдсан байтлаа Марк 9:40 дээр “Хэн биднийг үл эсэргүүцнэ, тэр бидний талд” гэсэн.

Өнгөцхөн харахаар энэ хоёр үг бие биеэ үгүйсгээд байгаа юм шиг харагдана. Харин Матай 12:30 нь авралын асуудлыг, Марк 9:40 нь үйлчлэлийг ярьж байгааг ойлговол огт тэгж харагдахгүй. Эхний жишээн дээр, Өөрийг нь Бурханы Хүү гэж хүлээн авахгүй, хийсэн гайхамшгуудыг нь диаволын хүч гэж мунхагласан фарисайчуудад Эзэн Есүс хандаж ярьсан. Христийг хүлээн авах эсэхийг яривал Христийн төлөө байдаггүй нь Христийн эсрэг байдаг.

Хоёр дахь жишээнд нөхцөл байдал огт өөр. Христийн нэрээр үйлчилдэг мөртлөө шавь нартай хамт явдаггүй хүн байжээ. Шавь нар түүний ажлыг болиулах гэж оролдоход Эзэн Есүс, “Түүнийг бүү хоригло...Хэн биднийг үл эсэргүүцнэ, тэр бидний талд” гэж айлджээ. Христийн төлөөх үйлчлэлд бидний эсрэг биш хүмүүс бидний талд байдаг.

Авралтай холбоотой хэсгүүдийг христэч амьдрал, үйлчлэлийн тухай хэсгүүдээс ялгаж салгаж ойлговол хэчнээн тустайг дээрх жишээнүүдээс та ойлгосон биз ээ. Тэгэхээр Библи судалж байхдаа дараах зарчмыг баримтал:

- Бурханы ажил бидний төлөө – авралын тухай
- Бурханы ажил бидний дотор – ариусгалын тухай
- Бурханы ажил биднээр дамжуулж – үйлчлэлийн тухай

АРВАН ХОЁР

АГУУ БАЙДАЛ - ХҮН НЬ ҮҮ ЭСВЭЛ БАЙР СУУРЬ НЬ УУ?

Бичээч нь тухайн хүний хувь хүнийх нь онцлогийг ярьж байна уу эсвэл амьдралд гүйцэтгэж буй үүрэг ролийг ярьж байна уу гэдгийг ялгаж салгах шаардлагатай цөөн хэдэн хэсэг Библид байдаг. Жишээлбэл, хүн угаасаа төрөлх өгөгдлөөрөө илүү учраас бусдаас агуу гэж дуудуулж болно. Эсвэл арай дээгүүр албан тушаал хашдаг учраас илүү агуу гэж дуудуулж болно.

Баптисч Иохан

Есүс нэгэн удаа “Үнэнээр Би та нарт хэлье. Эмэгтэйчүүдээс төрөгсдийн дунд баптисч Иоханаас илүү агуу нэгэн байгаагүй” (Мт 11:11а) гэсэн байдаг. Гэхдээ Иоханыг Ноа, Даниел, Иов гэх мэт бусад агуу хүмүүсээс илүү сайн, илүү өгөөмөр, илүү бурханлаг, илүү даруу гэсэн утгаар хэлээгүй юм. Иохан нь Мессиагийн замыг засагч хэмээх байр сууриараа өмнөх үеийнхээ ариун хүмүүсээс агуу гэж тооцогдсон. Эзэний замыг бэлдэж, ирэлтийг нь зарлаж, Түүнд баптисм хүртээх боломж Иоханаас өөр хүнд олдоогүй. Энэ талаараа Иохан онцгой.

Тэнгэрийн хаанчлалын хамгийн бага нь

Эзэн Есүс, Иоханы хийж байгаа ажил ямар агуу чухал болохыг цохон тэмдэглэснийхээ

араас “Харин тэнгэрийн хаанчлалын хамгийн бага нь ч түүнээс агуу билээ” (Мт 11:11б) гэж айлдсан. Энд ч мөн, тэнгэрийн хаанчлалын хамгийн бага нь хувь хүнийхээ онцлог, амьдралын хэв маяг, зан чанараар Баптисч Иоханаас илүү гэсэн утгаар хэлээгүй. Харин байр суурийн талаас ярьж байна. Иохан хаанчлалыг тунхагласан бол, өнөөгийн итгэгчид тэр хаанчлалын иргэд.⁷ Иохан өөрийгөө “сүйт залуугийн найз” (Иох 3:29) гэж тодорхойлсон. Тэгвэл өнөөгийн бид сүйт бүсгүй. Сүйт залуугийн хувьд сүйт бүсгүй нь найзаас илүү байр суурьтай, илүү ач холбогдолтой байх нь дамжиггүй.

Мариа

Тэнгэрэлч Габриел онгон Мариад “Ивээгдэгч ээ, баярла! Эзэн чамтай хамт байна” (Лк 1:28) хэмээн мэндчилсэн. Мариа сүсэгтэй, зөв шударга, бузар муугаас зайлсхийдэг залуу бүсгүй байсан нь дамжиггүй. Гэхдээ түүний агуу байдал Эзэн Есүсийн маань эх болохоор сонгогдсонд байлаа. Мариа өөрийгөө нүгэлтэн гэдгийг хүлээн зөвшөөрөхдөө Бурханыг “Аврагч” (Лк 1:47) гэж дуудсан. Түүний зан чанар, хувь хүн нь Рутээс эсвэл Ханнагаас илүү байсан гэвэл өрөөсгөл ойлголт болно. Харин гүйцэтгэсэн үүрэг ролийнх нь талаас яривал, Мариа ямар ч эмэгтэйтэй зүйрлэгдэхгүй.

⁷ “Чуулган ба хаанчлал” гарчигтай бүлгийг үзнэ үү.

Нэг өдөр Өөрийг нь биширсэн нэгэн хүн Есүст хандан “Таныг тээсэн хэвлий, Таныг хөхүүлсэн хөх нь ерөөлтэй еэ!” (Лк 11:27) гэхэд Есүс хариуд нь “Бурханы үгийг сонсоод сахигчид нь илүү ерөөлтэй еэ!” (Лк 11:28) гэжээ. Христийн ээж байснаас Христийн дуулгавартай дагалдагч байх нь илүү ерөөлтэй гэдгийг эндээс дүгнэж болно. Мөн Мариа нь Христийг төрүүлснээс Христэд итгэснээрээ илүү ерөөгджээ.

Эцэг Надаас агуу

Ялгаа салгааг гаргах ёстой чухал нэгэн хэсэг бол Иохан 14:28: “Би яваад, та нар уруу ирнэ гэж хэлснийг минь та нар сонслоо. Хэрэв та нар Намайг хайрласан бол Эцэгтээ очиж байгаад минь баярлахсан. Учир нь Эцэг Надаас илүү аугаа юм.” Гаж урсгалынхан болон Христ Бурхан гэдгийг үгүйсгэгчид “Эцэг Надаас илүү агуу” гэсэн сүүлийн үгийг өлгөж аваад мушгиж ашигладаг. Энэ үгээр Эцэг ба Хүүгийн тэнцүүг няцааж, Бурханы Гурвалыг үгүйсгэх нь хам сэдэвтэйгээ огт таарахгүй асуудал.

Тэгвэл “Эцэг Надаас илүү агуу” гэсэн нь юу гэсэн үг вэ? Эзэн Есүс энэ үгийг айлдахдаа газарт байж, Өөрийн бүтээлүүдээс есөн бусын доромжлол, буруутгал, дайсагналыг авч байлаа. Хүмүүс Түүнийг үгүйсгэж, гутааж, дорд үзсэн. Гэтэл Эцэг тэнгэрт байж, тийм хандлагаас ангид байлаа. Энэ утгаар Эцэг, Хүүгээс агуу юм. Хэн гэдгээрээ агуу бус, ямар байр сууринд байгаагаараа агуу. Хэрэв шавь нар Эзэнийг

үнэхээр хайрласан бол тэнгэр рүү буцах гэж байгаад нь баярлах байлаа. Тэнд Тэр хүмүүсийн доромжлол, харгис хэрцгий авираас ангид болно. Тэнгэрт буцвал бүтээлүүдийнхээ хавчлагаас хол, Эцэгтэй эн тэнцүү байр сууриндаа очих болно.

Эзэн Есүс дээрх эшлэлд хэн гэдгээрээ Эцэгтэй Өөрийгөө зэрэгцүүлж тавиагүй. Хэн гэдэг талаас яривал, Бурханы Хүү, Эцэгтэй бүх талаар эн тэнцүү. Харин газар дэлхий дээр байгаа Хүүгийн талаас яривал Өөрийнх нь эсрэг нүгэлтнүүдийн үзэн ядалтыг амсаж байгаа Хүү, тэнгэрт байгаа Эцэгээс дор байр сууринд байгаа нь тодорхой.

Есүсийн агуу байдал

Матай 12 дээр Эзэн Есүс Өөрийгөө сүмээс (эшлэл 6), Ионагаас (эшлэл 41), Соломоноос (эшлэл 42) агуу Нэгэн хэмээсэн. Энэ тохиолдолд байр суурь, үүрэг ролийн асуудал биш. Эзэн Есүс загварыг нь Өөрөө гаргаж, доторх зан үйлийг нь тогтоосон сүмээсээ илүү агуу байх нь мэдээж. Эзэн Есүс хэн гэдгээрээ, тунхагласан мэдээгээрээ, үр дүнгээрээ, аль ч талаасаа Ионагаас агуу юм. Тэгээд зогсохгүй сүр жавхлангаараа, мэргэн ухаанаараа Соломоноос агуу. Соломонд мэргэн ухааныг өгсөн нь Эзэн Есүс билээ.

Хам сэдвийг нь хар

Хувь хүнийх нь агууг ярьж байна уу эсвэл байр суурийнх нь агууг ярьж байна уу гэдгийг хам сэдэв нь тайлбарлаад өгнө. Харин Эзэн

Есүсийн тухай бичсэн бол Түүний агуу байдалтай юуг ч жишихгүй. Эзэн Есүс хамгийн агуугаас агуу, хамгийн сайнаас сайн нь мөн.

АРВАН ГУРАВ

АМИН ЧУХАЛ, ЧУХАЛ, АЧ

ХОЛБОГДОЛ БАГА

Шинэ гэрээг судлахдаа аливаа нэг сэдвийг амин чухал, чухал, ач холбогдол бага гэж ялгах хэрэгтэй. Бурханы үг бүр Өөрийнх нь амьсгалснаар өгөгдсөн боловч бүх хэсэг нь адил ач холбогдолтой байдаггүй.

Эзэн Есүс фарисайчуудтай ярихдаа “Та нар гаа, гоньд, зирааны аравны нэгийг өгдөг атлаа хуулийн чухал нөхцөлүүд болох шударга ёс, өршөөл, итгэлийг орхигдуулдаг” (Мт 23:23) гэж айлдсан байдаг. Эндээс харвал Бурханы хуульд ч гэсэн ач холбогдлын эрэмбэ гэж байдаг аж. Гэхдээ хуулийн ач холбогдол багатай хэсгийг ч гэсэн дуулгавартай дагах ёстойг Эзэн Есүс сануулсан удаатай.

Үүнтэй адилаар христитгэлд ч гэсэн амин чухал сургаал гэж бий. Бас амин чухал биш боловч чухалд тооцогдох сургаал байдаг. Тэдний зарим нь Эзэний тушаал (1Ко 14:37). Тэгээд бас итгэгч хүн Эзэний өмнө өөрийнхөө үзэмжээр шийдэх, ач холбогдолтой сургаалууд гэж бий.

Амин чухал

Дараах сургаалууд амин чухал бөгөөд христитгэлийн тулгуур:

- Бурханы амьсгалаар илчлэгдсэн Библи. Библи нь Бурханы үг.

- Гурвал. Гурвалаар мөнх оршигч цор ганц Бурхан.
- Христийн бурхан чанар. Эзэн Есүс Христ бол Бурхан.
- Бурхан хүн болсон. Есүс бол Бурхан бас төгс Хүн.
- Христ нүгэлтнийг орлож Голгота дээр үхсэн. Оршуулагдаад, үхлээс амилж, тэнгэр өөд одсон.
- Сайнмэдээ. Хүн үйлсээс ангид нигүүлслээр, итгэлээр аврагдана.
- Хоёр дахь ирэлт. Христ дэлхийд дахин ирнэ. Түүний эргэн ирэлтийн нарийн ширийн асуудалд итгэгчид санал зөрөлддөг ч гэлээ, Христ дахин ирнэ гэдэг сургаал нь христитгэлийн тулгуур аж.
- Авралгүй хүмүүсийн мөнхийн шийтгэл.

Энэ сургаалуудыг өчүүхэн төдий ч хөндөж болохгүй. Харин ч амиа тавин хамгаалах хэрэгтэй. Дээрх сэдвүүдийг Библид тов тодорхой өгүүлсэн бөгөөд эвангелийн чуулганууд зуун зууны туршид энэ сургаалуудыг ягштал баримталж иржээ. Энэ сургаалууд дээр үзэл бодлын зөрүү гаргавал сургаалын гажуудал гэж үзэж байв. Итгэгчид энэ сургаалуудыг хамгаалахын тулд үхэхэд бэлэн байлаа. Үүн дээр ямар ч буулт хийж болохгүй. Бид амин чухал сургаалуудыг үгүйсгэдэг хүмүүстэй нөхөрлөх боломжгүй.

Мэдээж хэрэг энэ зарчим Бурханы өөрчлөгдөшгүй ёс суртахууны хуулиудад бас хамаатай. Завхайрах нь хэзээд буруу. Худал ярих, хулгай хийх нь ямагт нүгэл аж. Шүтээн шүтлэгийн бүх хэлбэрийг Бурханы үг хориглодог. Эдгээр болон эдгээртэй төстэй олон талбарт хөнгөвчлөх, зөөлрүүлэх, буулт хийх ямар ч боломжгүй. Бид ийм бузар муугийн эсрэг Бурхантай хамт нэгэн санаагаар зогсох ёстой.

Амин чухал биш ч чухал

Хоёрдугаар зэрэглэлийн сургаалууд бол амин чухал биш ч чухал сургаалууд. Библи тэдгээрийг эрх мэдэлтэйгээр номлодог учраас чухал. Гэхдээ христитгэлийн амин чухал, тулгуур сургаал уу гэвэл үгүй. Энэ ангилалд багтах зарим жишээг дурдъя:

- Баптисм
- Салалт ба дахин гэрлэлт
- Ирээдүйн үйл явдал
- Бурханы сонголт ба хүмүүний хариуцлага
- Итгэгчийн аврал алдагдашгүй байдал
- Чуулган дахь эмэгтэйчүүдийн үүрэг роль
- Сүнсний бэлгүүд

Дээрх асуудлуудад цорын ганц зөв тайлбар байдаг нь мэдээж. Гэвч бүх итгэгч аль тайлбар нь зөв гэдэг дээр нэгдмэл байр суурь баримталдаггүй. Итгэмжтэй, агуу итгэгчид ч хоорондоо санал зөрөлдөх нь бий. Жон Уэсли, Чарльз Спержон хоорондоо санал зөрөлдөх жишээний. Эдгээр сэдэв дээр хүн бүр зөвхөн

Бурханы Үгэнд тулгуурласан итгэл үнэмшлийг бий болгох үүрэгтэй.

Ач холбогдол багатай асуудлууд

Гуравдугаар зэрэглэлийн буюу Библид нэг их ач холбогдол өгөөгүй асуудлууд гэж бий. Ёс суртахууны талаас ч тийм ноцтой биш асуудлууд гэсэн үг. Хэрэв бусдыг бүдрээгээгүй (Ром 14:13), чуулганы эв нэгдэл, амар амгаланг бусниулаагүй (Ром 14:19), өөрийн мөс чанарыг сэвтүүлээгүй (Ром 14:23) бол өөрийн үзэмжээр шийдэхийг Эзэн зөвшөөрсөн тийм асуудлууд энд багтана.

Чуулганы эхэн үед шүтээнд өргөсөн хоол, онцгой өдрүүдийг (иудейн шашны тэмдэглэлт өдрүүдийг) сахих, цэвэр бузар хоол гэсэн асуудлууд хөндөгдсөн. Библи эдгээрийг хэрхэн шийдсэнийг харцгаая:

Шүтээнд өргөсөн хоол

Шүтээнүүдэд өргөсөн хоол хүнсний тухай өгүүлсэн гол эшлэлүүд нь 1Коринт 8:1-13 болон 1Коринт 10:14-30. Тэнд өгүүлэх гол санаа нь: Христитгэгч хүн шүтээнд идээ өргөх найрт оролцоогүй, мөс чанар нь энэ асуудалд цэвэр, бусдыг бүдрүүлээгүй бол ийм хоол идэж болно. Гэхдээ Паул “Бүх юм зөвшөөрөгддөг” гэж хэлэхдээ ёс суртахууны асуудлыг ч гэсэн оруулаад бүх юм гэж хэлээгүй юм шүү. Зөвхөн тухайн өгүүлж буй сэдвийнхээ хүрээнд буюу ёс суртахууны талаас ноцтой биш асуудлуудыг

ярьсан гэж ойлгоорой. Эс бөгөөс Паул садар самууныг ч хүлээн зөвшөөрдөг гэсэн бүдүүлэг тайлбарыг хүлээн авах аюултай.

Онцгой өдрүүдийг сахих

Ром номын 14-р бүлэгт онцгой өдрүүдийг сахих, мах идэх (зөвхөн ногоо идэхтэй эсрэгцүүлж), дарс уух зэрэг сэдвүүдийг авч үзсэн. Паул олон удирдамж өгсний дотор “Хүн бүр өөрийн бодолдоо бүрэн итгэлтэй бай” (5-р эшлэл) гэсэн чухал зарчмыг заасан. Хэрэв та үүнийг хам сэдвээс нь салгаж, Библи бол Бурханы үг эсвэл итгэлээр дамжуулан нигүүлслээр аврагдана гэх мэт тулгуур сургаалуудад хэрэглэвэл энэ нь ноцтой асуудал үүсгэнэ. Ром 14-р бүлэгт заасан зарчмууд нь бидний яриад байгаа, ач холбогдол багатай асуудлуудад хамаатай гэдгийг ойлгох хэрэгтэй.

Цэвэр бузар хоол

Тит 1-р бүлэгт Паул христитгэгчдийг Мосегийн хуулийн дор оруулахыг оролдсон хуурамч багш нарт ихээхэн анхаарал хандуулсан байдаг. Тэрээр 15-р ишлэлд “Цэврийн хувьд (цэвэр хүний хувьд) бүх юм цэвэр ажээ. Харин бузартсан болоод итгэлгүйчүүдийн хувьд юу ч цэвэр биш. Тэдний ухаан ч, мөс чанар нь ч бузартсан байдаг” гэжээ.

Паул “Цэвэр хүний хувьд бүх юм цэвэр” гэж хэлэхдээ бүх талбарт хамаарах асуудлыг хэлээгүй. Харин Мосегийн хуулиар бузарт тооцогддог хоол хүнс гэх мэт зүйлсийг хэлсэн юм. Энэхүү нигүүлслийн эрин үеийн христигэгчдийн хувьд Бурханаас хүмүүст өгсөн бүх хоол хүнс цэвэр ариун билээ. “Кошээр” эсвэл “кошээр бус” гэх юм бидэнд хамаарахгүй.

Ром 14-р бүлгээс адил зарчмаар ойлгох ёстой хэсэг бол 14-р эшлэл: “Ямар ч юм өөрөө бол бузар биш, харин аливааг бузар гэж үзэгчийн хувьд л тэр нь бузар юм гэдгийг би Эзэн Есүс дор мэдэж итгэсэн юм.” Паул ч тэр, бид ч тэр, үнэхээр бузар зүйлс гэж байдгийг хэнээр ч хэлүүлэлтгүй мэднэ. Гагцхүү энд ярьж буй асуудал болбоос, Хуучин гэрээний цагт бузар гэгдэж байсан гахай, сам хорхой, туулай гэх мэт хоол хүнсний тухай юм.

Өнөөгийн бидэнд ач холбогдол багатай зүйлс

Зарим итгэгч дараах сэдвүүдийн заримд онцгой ач холбогдол өгч магадгүй. Гэсэн ч Библи нэг их онцгойлон авч үздэггүй. Өнөөгийн бидэнд ач холбогдол багатай зүйлс ангилалд багтах сэдвүүд нь:

- Эзэний зоогт дарс хэрэглэх үү эсвэл усан үзмийн ундаа хэрэглэх үү
- Исгэсэн талх хэрэглэх үү эсвэл исгээгүй талх хэрэглэх үү
- Цуглааны цагууд
- Цуглаанд хөгжмийн зэмсэг ашиглах

- Библийн аль орчуулгыг ашиглах вэ
- Бурханыг дуудахдаа “Ертөнцийн Эзэн” гэх үү эсвэл “Бурхан” гэх үү
- Христэд үйлчлэлийн арга барил

Дээрх жагсаалтын сүүлийнх буюу Христэд үйлчлэлийн арга барилд тухайн ард түмний соёл, зан заншлыг тодорхой хэмжээнд бодолцон үзэх ёстой. Паул сайнмэдээг ойлгуулах гэсэн хүмүүстэйгээ өөрийгөө адил болгох тухай 1Коринт 9:19-23 дээр ярьсан. Мэдээж үүнийг хийхдээ итгэлийн тулгуур үнэнүүд болоод Христэд үнэнч байхыг гаргуунд гаргахгүй:

¹⁹ Учир нь би бүгдээс чөлөөтэй атлаа илүү олныг олж авахын тулд өөрийгөө бүгдэд боол болгосон. ²⁰ Иудейчүүдийг олж авахын тулд би иудейчүүдэд иудей адил, хуулийн доор байгсдыг олж авахын тулд би өөрөө хуулийн доор бус атлаа хуулийн доор байгсдад хуулийн доор байгч мэт, ²¹ хуульгүйчүүдийг олж авахын тулд (хэдийгээр би Бурханы хуулиас ангид бус харин Христийн хууль дор байдаг атлаа), хуульгүйчүүдэд хуульгүй нэгэн адил, ²² сул доройчуудыг олж авахын тулд би сул доройчуудад сул дорой нэгэн адил болсон юм. Бүхий л аргаар заримыг нь аврахын тулд би бүгдэд бүх юм болж байлаа. ²³ Би сайнмэдээний ерөөл хуваалцагч байхын тулд үүний төлөө бүхнийг хийдэг.

Бүхий л аргаар заримыг нь аврахын тулд би бүгдэд бүх юм болж байлаа – Паул энэ үгийг хэлэхдээ сайнмэдээний үнэнийг гуйвуулах,

нүгэлд хутгалдах тухай огт яриагүй. Үнэнийг гаргуунд нь хаячихгүй л бол сайнмэдээг бусдад илүү үр дүнтэйгээр хүргэх юуг ч хийхэд Паул бэлэн байсан. Тимотыг хозолсон нь үүний тод жишээ (Үйл 16:3). Гэтэл хуулиас ангид, нигүүлслээр аврагдана гэсэн үнэн хөндөгдөх учраас хозлолыг Паул эрс эсэргүүцсэн (тухайлбал Титийг хозлохыг дургүйцсэн, Гал 2:1-5).

Дүгнэлт

Одоо дээр ярьсан бүгдээ нэгтэн авч үзье.

Христитгэлийн тулгуур амин чухал сургаалууд, Бурханы өөрчлөгдөшгүй ёс суртахууны хуулиудад ямар ч найраа байхгүй. Тэднийг зуун хувь хүлээн зөвшөөрч, бүрэн дуулгавартай дагах ёстой.

Харин амин чухал биш ч, чухал гэсэн асуудлуудын тухайд итгэгч бүр Бурханы Үгэнд аль болох ойрхон, нягт нямбай дүгнэлт хийж, амьдралдаа хэрэгжүүлэх ёстой.

Ач холбогдол багатай зүйлсийн хувьд ялгаатай байр суурь, үзэл бодол байж болно. Гэхдээ эв нэгдэл, амар амгаланг бодолцох ёстой (Еф 4:1-6). Хамгийн гол нь христитгэгч хүн бузар муугаас зайлсхийж, ах дүүгээ бүдрүүлэхээс эсвэл өөрийн мөс чанарыг зөрчихгүй байхыг нэн тэргүүнд тавина.

Амин чухал болон чухал асуудлуудыг авч үзэхэд тодорхой суурь зарчмуудыг баримтална. Харин ач холбогдол багатай асуудлуудыг авч

үзэхэд огт өөр зарчим хэрэгжинэ. Христ бол Бурхан гэдгийг ярихдаа Паул үзэл бодлын зөрүүг хүлээн зөвшөөрч “Хүн бүр өөрийн бодолдоо бүрэн итгэлтэй байг” (Ром. 14:5б) гэж хэлээгүй. Эсвэл садар самууны тухайд “Ямар ч юм өөрөө бол бузар биш гэдгийг би Эзэн Есүс дор мэдэж итгэсэн юм” (Ром 14:14) гэж хэлээгүй. Библиэс таны уншиж буй хэсэг амин чухал, чухал, ач холбогдол бага асуудлын алийг ярьж байна гэдгийг зөв тодорхойлох хэрэгтэй.

**ГУРАВДУГААР
ХЭСЭГ
ЯЛГАА Ш:
БУРХАНЫ АРГА
ЗАМ**

АРВАН ДӨРӨВ ДИСПЕНСАЦИ

“Үеүдийг ялга. Тэгвэл Бичээсүүд хоорондоо уялдах болно” гэж Августин хэлсэн удаатай. Бурхан хүмүүн төрөлхтний түүхийг үеүдэд хуваажээ: “... үеүдийг (гр. *αιонаς*) бүтээсэн Хүүгийнхээ дотор...” (Евр 1:2). Энэ үеүд зарим нь удаан, зарим нь богино үргэлжилсэн. Бид үеүдийг хугацааны урт богиноор бус, Бурхан хүн төрөлхтөнтэй ажилласан арга замаар нь ялгадаг.

Диспенсацийг тодорхойлохуй

Бурхан Өөрөө хэзээ ч өөрчлөгддөггүй боловч арга замууд нь өөрчлөгддөг. Бурхан өөр өөр цаг хугацаанд өөр өөр арга замаар ажилладаг. Тодорхой нэг эрин үед Бурхан хүмүүстэй харилцахдаа авч хэрэгжүүлж буй арга замуудыг, ажиллах байдлыг заримдаа бид диспенсаци (*dispensation*) гэж нэрлэдэг. Энэ нь теологийн мэргэжлийн үг хэллэг бөгөөд үеүд гэсэн үг биш, харин удирдлага, засаг захиргаа, тогтолцоо, дэг журам, хөтөлбөр, удирдан зохион байгуулсныг илэрхийлсэн үг. Гэхдээ диспенсацийг цаг үеүдээс салгаж ойлгох аргагүй. Жишээ нь, АНУ-ын төр хэд хэдэн администрацид хуваагдсан. Тухайлбал: Рузвельтын администраци, Айзенхауэрын администраци, Рейганы администраци гэхчлэн. Мэдээж АНУ-ын төр хэвээрээ боловч, алба хашиж буй ерөнхийлөгчдийн төр барих хэлбэр, аргачлал,

удирдлага, зохион байгуулалт өөр байгааг бид ингэж ярьдаг. Гол санаа нь дагаж мөрдөж буй зарчим бодлого. Гэхдээ тухайн зарчим бодлогыг, авч хэрэгжүүлсэн цаг хугацаатай нь хамт бид авч үздэг шүү дээ.

Диспенсацийн жишээнүүд

Тиймээс энэ бүлэгт диспенсацийг, түүхийн тодорхой цаг үе болгонд Бурхан хүмүүстэй харьцахдаа хэрэгжүүлсэн арга зам гэдгээр авч үзнэ. Бурханы диспенсаци ажиллагааг айл гэрийг авч явахтай зүйрлэж болох юм. Зөвхөн эхнэр нөхөр амьдарч байхад гэрт тодорхой нэг уур амьсгал, амьдралын хэв маяг байна. Дараа нь хүүхдүүд гараад ирэхээр гэр орны байдал, тухайн айл гэрийг авч явах арга зам өөрчлөгдөнө. Хожим нь хүүхдүүд томроод тусдаа гарцгаахад юмс ахин өөрчлөгдөнө. Бурхан хүн төрөлхтөнтэй ажиллаж буй нь үүнтэй адил (Гал 4:1-5).

Жишээлбэл, Абел дүүгээ алсан Каины дээр Бурхан тэмдэг тавьж түүнийг олсон хэн ч алахааргүй болгосон (Эх 4:15). Гэтэл их үерийн дараа Бурхан цаазын авах ялыг тогтоож, “Хэн хүний цусыг урсгана түүний цусыг хүн урсгана” (Эх. 9:6а) гэж зарлигдсан. Яагаад ялгаа байна вэ? Яагаад гэвэл диспенсаци өөрчлөгдсөн байна.

Өөр нэг жишээ: Дуулал 137:8-9-ийг бичсэн хүн Вавилон дээр хатуу шийтгэл дуудсан байна:

*Сүйрэгч болох Вавилон охин оо,
Бидэнд үйлдсэн ёсоор чинь*

Чамд хариулагч нь азтай яа!

Нялхсыг чинь булаагаад

Хад уруу шидэгч нь азтай яа!

Тэгтэл хожим хойно Эзэн Есүс Өөрийн хүмүүстээ “Би та нарт хэлье, дайснуудаа хайрла, та нарыг хавчигчдын төлөө залбир” (Мт 5:44) гэж номлосон.

Хуулийн доор амьдарч асан дуулал бичээчийн амнаас гарч болсон үг эдүгээ нигүүлслийн доор амьдрагч христитгэгчийн амнаас гарч боломгүй үг болжээ.

Хуулийн доор харь үндэстний эхнэр, хүүхдүүдээ явуулахыг Израилийн эрчүүдэд тушааж байлаа (Езр 10:3). Харин одоо, нигүүлслийн доор итгэгчид үл итгэгч хань ижил, үр хүүхдүүдээсээ салах ёсгүй (1Ко 7:12-16).

Диспенсацийн нотолгоо

Хэдэн диспенсаци байгаа, тэднийг юу гэж нэрлэх вэ гэдэг дээр бүх итгэгч санал нэгддэггүй. Үнэндээ зарим итгэгч диспенсацийг ч огт хүлээн зөвшөөрдөггүй.

Гэхдээ диспенсацийн нотолгоог дараах байдлаар гаргаж ирж болно. Юуны түрүүнд, дор хаяж хууль ба нигүүлсэл гэсэн хоёр диспенсаци байгаа нь Библиэс тодорхой харагддаг: “Хууль Мосеогоор өгөгдсөн бол, нигүүлсэл ба үнэн нь Есүс Христээр ирсэн билээ.” (Иох 1:17) Библи ч гэсэн Шинэ гэрээ, Хуучин гэрээ гэсэн хоёр хэсэгтэй байгаа нь администраци өөрчлөлт болсныг харуулж байгаа юм. Өнөөгийн итгэгчид

мал амьтдаар тахил өргөхөө больсон. Тэгэхээр Бурхан шинэ дэг журмыг тогтоосон нь илэрхий байна.

Хэрэв хоёр диспенсаци байгааг бид хүлээн зөвшөөрч байгаа бол, гурав дахь нь бас байгааг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Учир нь ертөнц бүтээгдсэнээс хойш хэдэн зуун жил дараа буюу Гэтлэл 19-р бүлэг хүртэл хууль өгөгдөөгүй байсан. Тэгэхээр хуулиас өмнө дахиад нэг диспенсаци байсан гэж дүгнэхээс өөр аргагүй (Ром 5:14). Ингээд гурван диспенсаци боллоо.

Дөрөв дэх диспенсаци бас гарч ирнэ. Юу гэвэл, Библи “ирэх үе”-ийн (Евр 6:5) тухай өгүүлдэг. Энэ нь, Эзэн Есүс Христ дэлхийд хаанчлахаар буцан ирэх үе буюу мянган жилийн хаанчлал (Millennium) юм.

Паул ч мөн одоогийн үеийг ирэх үеэс ялгаж ярьсан байдаг. Эхлээд Паул, өөрт нь сайнмэдээ ба чуулганы үнэнийг даатгасан үеийг буюу диспенсацийг ярьсан (1Ко 9:17; Еф 3:2; Кол 1:25). Энэ нь одоогийн үе. Дараа нь тэрээр ирээдүйн үеийн тухай ярьсан байдаг. Үүнийг Ефес 1:10 дээр “цагийн дүүрлийг гүйцэлдүүлэх” гэж тодорхойлсон. Паулын тодорхойлолтоос харахад уг диспенсаци хараахан ирээгүй нь тодорхой байна.

Тэгэхээр бид дэлхийн түүхийн сүүлийн эрин үед амьдраагүй гэдгээ мэдэж авлаа.

Диспенсацуудын ангилал

Скофилдын Судлал Библи (Scofield Reference Bible)-ийн редактор доктор С. И. Скофилд долоон диспенсаци байна гэж үзсэн.

1. Гэм нүгэлгүй үе (Эх 1:28). Адам бүтээгдсэн цагаас, нүгэлд унах хүртэл.
2. Мөс чанар буюу ёс суртахууны хариуцлага (Эх 3:7, 22). Нүгэл орж ирсэн цагаас их үер хүртэл
3. Хүмүүний засаглал (Эх 9:5-6). Их үерээс Абрахамын дуудлага хүртэл.
4. Амлалт (Эх 12:1-3). Абрахамын дуудлагаас хууль өгөгдөх хүртэл.
5. Хууль (Гэт 19-20). Хууль өгснөөс Пентэкостын өдөр хүртэл.
6. Чуулган (Үйл 2). Пентэкостын өдрөөс шүүрэлт (Rapture) хүртэл.
7. Хаанчлал (Илч 20:4). Христийн мянган жилийн хаанчлал.

А. Э. Бүүт, “Мөнхөөс мөнх үргэлжлэх цаг хугацаа” (The Course of Time from Eternity to Eternity) номдоо Эхлэл номд өгүүлсэн бүтээлийн долоон өдөр хүн төрөлхтний түүхийн долоон диспенсацийг урьдчилан зөгнөсөн гэж дүгнэсэн байна.

- Эхний өдөр – Хүн бүтээлийн гэрэл ба амлалтын гэрлээр шалгуулсан
- Хоёр дахь өдөр – Засаглал (Үерээс эхлээд үндэстнүүдийн хуваагдал хүртэл)

- Гурав дахь өдөр – Израиль (Абрахамаас эхлээд сайнмэдээний номууд бичигдэж дуусах хүртэл)
- Дөрөв дэх өдөр – Нигүүлсэл (завсрын үе)
- Тав дахь өдөр – Их зовлонгийн үе
- Зургаа дахь өдөр – Мянган жилийн хаанчлал
- Долоо дахь өдөр – Мөнх эрин үе

Диспенсацийн ач холбогдол

Диспенсацийн нарийн ширийн асуудал дээр санал зөрөлдөж болох ч, диспенсацууд байдгийг олж харах нь хамгийн чухал. (Тэр дундаа, хууль ба нигүүлслийн ялгааг олж харах нь чухал.) Эс бөгөөс, Библи дэх өөр цаг үед хамаарах хэсгүүдийг өөрсөд дээрээ авч үзэж, сургаалын төөрөгдөлд ордог. Библийн үг бүр бидэнд ашиг тустай нь үнэн ч гэлээ (2Тм 3:16), бүгд бидэнд шууд хандсан байх албагүй. Өөр цаг үеүдэд хамаатай хэсгүүдээс амьдралд хэрэгжүүлэх зарчим, сургамж гэх мэт олон зүйлийг сурч ойлгож болох ч гэлээ, тухайн хэсгийн хамааралт цаг үеийнхний өнцгөөс эл хэсгээ тайлбарлавал зохино. Жишээлбэл, хуулийн дор амьдарч асан иудейчүүд ац туурайгүй, сэвсээ хивдэггүй амьтны мах идэх хориотой байлаа (Лев 11:3). Энэхүү хориг өнөөгийн христитгэгчдэд хамаарах үг биш (Мк 7:18-19). Гэхдээ уг хоригийн сүнслэг зарчим буюу ёс суртахууны болон оюун санааны бузраас цэвэрлэж явах ёстой гэдэг нь өнөөдөр ч хүчин төгөлдөр.

Өөрийг нь дуулгавартай дагавал материаллаг талаас амжилттай, чинээлэг болгоно гэж Бурхан израильчуудад амласан (Дх 28:1-6). Уг амлалтууд энэ дэлхий дээр хүртэх материаллаг, биет, бодит ерөөлийн тухай. Гэвч эл амлалтууд өнөөдөр бидний хувьд хүчин төгөлдөр биш. Учир нь уг амлалтуудыг бидэнд хэлээгүй. Дуулгавартай байдлыг минь санхүүгийн амжилтаар ерөөнө гэж Бурхан бидэнд амлаагүй. Харин тэнгэрлэг газар дахь сүнслэг ерөөлүүдийг амлажээ (Еф 1:3).

Бүх диспенсацид өгсөн ганц сайнмэдээ

Үеүд хоорондоо ялгарах өөр өөрийн онцлогтой боловч хэзээ ч өөрчлөгддөггүй зүйл нь сайнмэдээ юм. Өнгөрсөнд ч, одоо ч, ирээдүйд ч аврал ганцхан болзолтой: Эзэнд итгэх. Аль ч эрин үед авралын үндэс нь үргэлж, Голгота дээр хийгдсэн Христийн загалмайн ажил болой. Хуучин гэрээний хүмүүс Эзэний өгсөн илчлэлд итгэхдээ аврагдаж байлаа. Жишээлбэл, Абрахам тэнгэрийн одод шиг олон үр удамтай болно гэсэн Бурханы амлалтад итгэснээр аврагдсан (Эх 15:5-6). Абрахам хэдэн зууны дараа Голгота дээр юу болох талаар гүйцэд ойлголттой байсан гэвэл юу л бол. Харин Бурхан бүгдийг мэддэгийн хувьд, Абрахамыг Эзэнд итгэх үед нь, ирээдүйд болох Христийн ажлын үнэ цэнийг Абрахам дээр тооцож аварчээ.

Хуучин гэрээний ариун хүмүүс “зээлээр” аврагдсан гэж нэгэн хүн хэлсэн байдаг. Өөрөөр

хэлбэл, Эзэн Есүсийн олон жилийн дараа төлөх үнээр аврагдсан (Ром 3:25-ын утга) аж. Харин бид 2000 гаруй жилийн өмнө болчихсон үйл явдал буюу Христийн гүйцээчихсэн ажлын үндсэн дээр аврагддаг. Аль нь ч гэсэн Эзэнд итгэх итгэлээр аврагддаг.

Хуулийн цаг үед байсан хүмүүс хуулийг сахиснаар эсвэл мал амьтан тахилд өргөснөөр аврагдаж байсан гэдэг үзлээс бид сэрэмжлэх ёстой. Хууль зөвхөн буруушааж чадна, аварч чадахгүй (Ром 3:20). Бух, ямааны цус нэг ч нүглийг арилгаж чадахгүй (Евр 10:4). Тийм ээ! Бурханы авралын зам нь итгэл, зөвхөн итгэл билээ (Ром 5:1-ийг үзнэ үү.)

Бас нэг санаж явууштай зүйл: Өнөөгийн эрин үеийг нигүүлслийн эрин үе гэж ярихдаа өнгөрсөн эрин үеүдэд Бурхан нигүүлдэггүй байсан гэж бүү буруу бодоорой. Нигүүлслийн эрин үе гэдэг нь Бурхан хүнийг хуулиар биш нигүүлслээр сорьж байгаа эрин үе гэсэн утгатай. Үүний нарийн ялгааг дараа үзэх бүлэгт тайлбарлана.

Үеүд хормын дотор дуусдаггүй гэдгийг ойлгох нь бас чухал юм. Шилжилтийн үе, давхцалын үе гэж байдаг. Үүнийг Үйлс номоос харж болно. Шинэ чуулган өмнөх диспенсацийн зарим урхинаас салах гэж багагүй хугацаа зарцуулсан. Шүүрэлт ба их зовлон гамшгийн дунд ёс бусын хүн гарч ирэх, Иерусалимд ариун сүм баригдах цаг хугацаа байх боломжтой.

Диспенсацийг буруу ашиглах

Эцэст нь хэлэхэд, сайны хажуугаар заавал саар байдагчлан, диспенсацийн үзлийг буруугаар ашиглах явдал ч байдаг. Зөвхөн Паулын шоронгийн захидлуудыг өнөөгийн чуулганд хамаатай гэдэгтээ тултал диспенсацийн үзлийг ярьдаг христитгэгчид бий. Түүнээсээ болоод Эзэний зоог, баптисмыг хүлээн авдаггүй. Учир нь Паулын шоронгийн захидлуудад дурдаагүй учраас тэр. Дээрээс нь тэд Петрийн сайнмэдээ, Паулынхаас өөр байсан гэж номлодог (үүнийг няцаах нотолгоо Гал 1:8-9). Энэ хүмүүсийг ультра-диспенсаци үзэлтнүүд эсвэл Булингерчүүд (үүсгэн санаачлагч багш нь У. Э. Булингер) гэж нэрлэдэг. Ийм туйлширсан диспенсаци үзэлтнүүдээс зайгаа авах нь зүйтэй.

АРВАН ТАВ

БИБЛИ ДЭХ ГЭРЭЭНҮҮД

Хүн төрөлхтний түүхийн янз бүрийн үе шатанд Бурхан хүн төрөлхтөнтэй гэрээнүүд байгуулжээ. Тэдгээрийн зарим нь тухайлбал, хууль болзолтой байсан. Хэрэв хүмүүс үүргээ биелүүлбэл Бурхан гэрээгээ биелүүлнэ гэсэн нөхцөлтэй. Нөхцөлтэй гэрээнүүд нь “махбодын улмаас сул дорой” болдог бөгөөд хүн болзлыг хэзээ ч биелүүлж чадаагүй юм.

Золоор Бурханы ихэнх гэрээ ямар ч болзолгүй байсан. Болзолгүй гэрээнүүд зуун хувь Эзэнээс хамаардаг бөгөөд энэ нь эл гэрээнүүдийн биеллийг баталгаажуулдаг.

Ихэнх гэрээг Абрахам болон түүний үр удамтай хийсэн. Тэдний аль нь ч чуулгантай шууд холбоогүй ч бидний үзэх гэж байгаачлан чуулган цөөн хэдэн зүйлд оролцдог.

Еден (Эх 1:28-30; 2:16-17)

Хүмүүнийг нүгэлгүй ахуйд хийгдсэн Едений гэрээ нь хүнийг дэлхий дээр үржиж олшрох, дэлхийг захирах үүрэгтэй болгосон. Түүнд бүх амьтны амьдралыг удирдах эрх мэдэл өгсөн. Тэрээр цэцэрлэгээ арчилж, сайн муугийн модныхоос бусад бүх үр жимснээс идэх ёстой байлаа. Энэ сүүлчийн тушаалд дуулгаваргүй байх нь үхэлд хүргэх болно. Тиймээс энэ нь болзолт гэрээ байв.

Адам (Эх 3:14-19)

Хүн нүгэлд унасны дараа Бурхан могойг харааж, могой ба эмэгтэйн хоорондох, Сатан ба Христийн дундах дайсагналыг зөгнөсөн. Христийг Сатан гэмтээж, харин Сатаныг Христ устгах болно. Эмэгтэй хүн төрөхдөө өвдөлтийг мэдэрч, нөхрийнхөө удирдлага дор орно. Газар хараагдсан. Хүн газарт үр тариа тариалахдаа өргөс, хогийн ургамалтай тэмцэх ёстой болжээ. Ийнхүү хүн хөлсөө дуслуулан, ядран байж хоолоо олж идэх, эцэстээ бие нь тоос шороо болж хувирах хувь тавилантай болжээ.

Ноа (Эх 8:20-9:27)

Бурхан дахин газрыг хараахгүй, үерээр дэлхийг сүйтгэхгүй гэж Ноад амлаж, солонгоор баталгаа өгчээ. Уг гэрээ хүн амины гэмт хэрэгт цаазын ял оноохыг тогтоож өгсөн бөгөөд мэдээж хэрэг энэ нь хэргийг шүүх, ялыг гүйцэтгэх төр байхыг дам утгаараа илэрхийлдэг. Тэгэхээр Ноагийн гэрээ хүний засаглалыг тогтоосон гэж хэлж болно. Бурхан цаг хугацаа, улирлын тогтмол байдлыг хангаж, дэлхий дээр хүн үржин олшрохыг тушааж, хүмүүс амьтдыг ноёрхохыг дахин баталгаажуулсан. Хүн одоо цагаан хоолондоо мах нэмж оруулах боломжтой болсон. Ноагийн үр удмын тухайд Бурхан Хамын хүү Канааныг ⁸ Шем, Иафет хоёрт зарц болгож

⁸Хараал ер нь бол хараалыг хүлээн авсан хүний эцэг рүү буцан очиж, хүүгээ өсгөж хүмүүжүүлэх үүрэг хариуцлагыг харуулдаг. “Хүүгийнхээ зан чанарын өмнө

хараасан. Бурхан Шемд сайхан газар нутаг өгсний дотор Мессиагийн өвөг дээдэс амьдрах газар нутаг багтаж байлаа. Иафет асар их тэлж, Шемийн майханд амьдрах болно. Ноатай байгуулсан гэрээ нь ямар ч болзолгүй бөгөөд хэзээ ч цуцлагдаагүй. Энэ нь “бүх үеийнхэнд” зориулагдсан (Эх 9:12).

Абрахам (Эх 12:1-3; 13:14-17; 15:1-5; 17:1-8)

Энэхүү гэрээнд Абрам (Абрахам) болон түүний үр удамд өгсөн дараах болзолгүй амлалтууд багтана: Агуу үндэстэн (Израиль); Абрахамд өөрт нь өгсөн ерөөлүүд; алдар нэр; бусдад ерөөлийн суваг болох (12:2); найз нөхөд нь Бурханыг ивээлийг, дайснууд нь хараал хүртэх; бүх үндэстэнд ерөөл болох (Христээр дамжин биелсэн) (12:3); хожмоо Израиль болон Палестин гэж нэрлэгдсэн Канааныг үүрд эзэмших (15:18); биеийн болон сүнслэг, тоо томшгүй олон үр удам (13:16; 15:5); Олон үндэстэн болон хаадын эцэг болох (Ишмаел, Исаак нараар дамжуулан) (17:4, 6); Бурхантай харилцах онцгой харилцаа (17:76).

хариуцлага хүлээдэг нь эцэг хүн тул Хам дээр шийтгэл дуудахын тулд Ноа заавал өөрийгөө хараах хэрэгтэй болно. Тийм учраас Хамыг шийтгэх гэж хүү дээр нь хараал дууджээ.” (Артур Кустаниц, Ноагийн гурван хүү, 195-р хуудас) “Хам эцгийгээ гутаасан буруутай. Тэгвэл энэ үйлийнх нь үр дагавар хэрхэн бууж буйг хараарай. Хам тарьснаа хурааж авч байна. Хам хүүгийн хувиар нүгэл үйлдсэн тул хүүгийнхээ дотроос шийтгэлээ авчээ.” (А. У. Пинк, Эхлэл номын түүвэр тайлбар, 124-р хуудас)

Мосегийн гэрээ буюу хууль (Гэт 19:5; 20-31)

Мосегийн хууль нь Бурханы өмнө болон хүмүүсийн өмнө хүлээх үүргийг тодорхойлсон арван тушаалыг (Гэт 20), Израилийн нийгмийн амьдралтай холбоотой олон дүрэм журам (Гэт 21:1–24:11), мөн шашны амьдралтай холбоотой нарийн дэг жаяг ёслолууд (Гэт 24:12–31:18). Энэ нь харийнханд биш Израиль үндэстэнд өгөгдсөн бөгөөд цусаар батлагдсан (Гэт 24:8; Евр 9:19-20). Энэ нь хүнээс дуулгавартай байхыг шаарддаг болзолт гэрээ тул “махбодоос болж сул дорой” болсон (Ром 8:3а). Арван тушаал нь хэзээ ч аврал өгөх зорилготой байгаагүй. Харин дуулгавартай байж чадахгүй сул доройг нь, нүглийг нь хүмүүнд ойлгуулах зорилготой (Ром 3:20б). Арван тушаалын ес нь Шинэ гэрээнд давтагдсан байдаг (Амралтын өдрийг хасаад). Ингэхдээ шийтгэл дагуулдаг хуулийн хувьд бус, харин нигүүлслээр аврагдсан хүмүүст тохирох амьдралын хэв маягийн жишиг байдлаар. Христитгэгч хүн хуулийн дор бус, нигүүлслийн дор байдаг. Өөрөөр хэлбэл Христийн хууль доор байдаг(1Ко 9:21). Энэ нь илүү дээд түвшний хэм хэмжээ билээ. Хууль нь Абрахамын гэрээг хүчингүй болгоогүй (Гал 3:17-18).

Палестин (Дх 28:1; 29:1-30:20)

Бурхан Эхлэл 15:18-д “Египет мөрнөөс (Нил биш, Египетийн горхи) их мөрөн Евфрат хүртэлх энэ газрыг Би үр удамд чинь өгсөн” гэж Абрахамд амлах үед энэ гэрээний суурь

тавигдсан гэж хэлж болно. Энэ нь дуулгаваргүй, үнэнч бус израильчуудыг үндэстнүүдийн дунд тараагдахыг, Эзэн хоёр дахь удаа дэлхийд ирэхийг, израильчууд гэмшиж эргэхийг, дайснуудынх нь шийтгэлийг, Мессиагийн хаанчлал дор израильчууд газар нутаг дээрээ аюулгүй амьдрахыг урьдчилан зөгнөсөн.

Израиль газар нутгаа хэзээ ч бүрэн эзэлж байгаагүй. Соломоны хаанчлалын үед зүүн хэсгийн улсууд алба гувчуур төлдөг байсан ч (1Ха 4:21, 24) үүнийг эзэмшил болсон, эзлэн авсан гэж тооцож болохгүй. Палестины гэрээний биелэл ирээдүйд хүлээж байна.

Давид (2См 7:1-17)

Бурхан Давидад хаант улсыг нь үүрд мөнх байлгана гэж амлаад зогсохгүй хаан ширээнд нь суух үр удмыг амласан (2См 7:12-16). Энэ бол Давидын дуулгавартай байдал, зөвт байдлаас ямар ч хамааралгүй, болзолгүй гэрээ байв. Христ бол Соломоноор дамжуулан Давидын хаан ширээг залгамжлах хууль ёсны өв залгамжлагч болж буйг Матай 1-р бүлэг дэх Иосефын угийн бичиг харуулдаг. Иосеф Есүсийг өөрийн хүү болгон өргөж авсан. Лук 3-р бүлэгт гардаг Мариагийн удмын бичгээс харвал Христ нь Натанаар дамжсан Давидын удам ажээ. Христ мөнх амьдардаг учраас уг хаан ширээнд суух өөр хүн байх боломжгүй. Түүний хаанчлал мөнх. Түүний 1000 жилийн хаанчлал мөнхийн хаанчлал болж цааш үргэлжилнэ.

Соломон (2См 7:12-15; 1Ха 9; 2Шс 7)

Соломонтой байгуулсан гэрээ нь мөнхийн хаанчлалын хувьд болзолгүй боловч хаан ширээнд залрах үр удмынх нь хувьд болзолтой байсан (1Ха 9:4-5; 2Шс 7:17-18). Соломоны удмын нэг Кониа (өөр нэр нь Иекониа, Иехоиахин) хараагдаж, түүний биеэс төрөх үр удам нь Давидын сэнтийд залрах эрхээ хасуулсан (Иер 22:30). Дээр дурдсанчлан Есүс Соломоны махан биеийн үр удам биш юм. Эс бөгөөс Кониагийн хараал дор байх байлаа.

Шинэ гэрээ (Иер 31:31-34; Евр 8:7-12; Лк 22:20)

Шинэ гэрээ нь Израилийн гэр болон Иудагийн гэртэй (Иер 31:31) хийгдсэн нь тодорхой бөгөөд Хуучин гэрээг (Мосегийн гэрээг) давамгайлж орлоно. Энэ нь илүү сайн тахилч, илүү сайн Тэргүүн тахилч, илүү сайн тахил, илүү сайн тахилын ширээтэй байх бөгөөд илүү сайн амлалтууд дээр тулгуурладаг (Евр 7-9; 13:10). Иеремиаг бичих үед энэ гэрээ ирээдүйд байсан (Иер 31:31a). Энэ нь Израилийн зөрчсөн Мосегийн хууль шиг болзолт гэрээ биш юм (Иер 31:32). Үүнд Бурхан ямар ч болзолгүйгээр амласан: Израилийн ирээдүйн сэргэлт (Езк 36:25-26); Ариун Сүнсний оршихуй (Езк 36:27); Бурханы хүслийг биелүүлдэг зүрх сэтгэл (Иер 31:33a); Израилийн хуулийг дэлхий даяар мэдэх (Иер 31:34a); нүглийг уучилж, мартаг (Иер

31:346); Израиль үндэстэн мөнхөд оршин тогтнох (Иер 31:35-37).

Израиль нь үндэстний хувьд шинэ гэрээний үр шимийг хараахан хүртээгүй байгаа ч, Эзэний хоёр дахь ирэлтээр хүлээн авах болно. Энэ хооронд жинхэнэ итгэгчид гэрээний зарим ерөөлийг хуваалцдаг. Тэдний нүглүүд уучлагдаж, мартагдсан (Евр 10:16-17). Тэд хуулийн зөвт шаардлагыг биелүүлэх боломжтой болсон (Ром 8:4). Чуулган шинэ гэрээтэй холбоотой гэдгийг Эзэний оройн зоогоос харж болно. Аяга нь гэрээ болон түүнийг баталсан цусыг илэрхийлдэг (Лк 22:20; 1Ко 11:25).⁹ Мөн Паул, Бурханы нигүүлслийн сайнмэдээнд үйлчилдэг өөрийгөө болон бусад элч нарыг “шинэ гэрээний үйлчлэгчид” (2Ко 3:6) гэж тодорхойлсон.

⁹“Чуулган шинэ гэрээний Зуучлагчийг хувьчлан мэддэг нь уг гэрээний үндсэн этгээд байхаас илүү том хувь завшаан билээ.” Ж. Н Дарби

АРВАН ЗУРГАА

ИЗРАИЛЬ, ХАРЬ ҮНДЭСТНҮҮД, ЧУУЛГАН

Шинэ гэрээ хүн төрөлхтнийг гурван ангилалд хуваадаг: Израиль, Харь үндэстнүүд, чуулган. Жишээ нь, Паул 1Коринт 10:32 дээр “Иудейчүүдэд ч, грекчүүдэд ч, Бурханы чуулганд ч төвөг бүү учруул” гэж бичжээ. Энд “грекчүүд” гэсэн нь “харь үндэстнүүд” гэдэгтэй ижил утга агуулна.

Үйлс 15:14-17 дээр хүн төрөлхтний энэ гурван ангилал ахин дурдагддаг:

Чуулган

“Бурхан Өөрийнхөө нэрийн төлөөх ард түмнийг харийнхнаас авахаар...” (14-р эшлэл)

Израиль

“Үүний дараа Би эргэж ирээд Давидын нурсан асрыг дахин босгоно. Балгаснуудыг нь Би дахин босгож, сэргээнэ.” (16-р эшлэл)

Харь үндэстнүүд

“Ингэснээр бүх үндэстнүүд Эзэнийг эрэн хайж, Миний нэрээр дуудагдсан бүх харийнхан ч бас хайна.” (17-р эшлэл)

Элч Паул энэ ялгааг мөн дараах байдлаар илэрхийлсэн:

- Иудейчүүд – махбоддоо гараар хозлуулсан (Еф 2:11)
- Харь үндэстнүүд – хозлуулаагүйчүүд (Еф 2:11)
- Чуулган – Гараар үйлдээгүй хозлолыг хийлгэсэн (Кол 2:11)

Ер нь Библи судлаачид харь үндэстнүүдийг Израильтай эсвэл чуулгантай хольж хутгадаггүй. Үүн дээр асуудал гардаггүй. Тиймээс бид энд Израиль ба чуулганы ялгааг л авч үзнэ. Энэ бол маш чухал. Хэрэв энэ хоёрын ялгааг олж харахгүй бол Библийн тайлбарт маань ноцтой алдаа гарч, чуулганы талаарх сургаал, эш үзүүллэгийг буруу тайлж эхэлдэг.

Энэ сэдэв яагаад чухал гэж үү? Яагаад гэвэл Израилийг чуулган орлох болсон гэж номлодог олон хүн бий. “Израиль бол Хуучин гэрээний үеийн чуулган. Гэвч тэд Мессиагаас татгалзсан учраас Бурхан тэднээс үүрд татгалзсан. Тиймд Бурхан олон зууны туршид чуулганаар дамжин ажиллаж байна. Израиль үндэстэнд ирээдүй гэж байхгүй. Шинэ гэрээний чуулган одоо Бурханы Израль болж, Израилийн амлалтууд нь сүнслэг байдлаар чуулганд биелнэ” гэж тэд заадаг.

Гэвч Библи огт өөр юм ярьдаг. Израиль ба чуулган гарал үүсэл, мөн чанар, үүрэг хариуцлага, хувь тавилан бүх зүйлээрээ ялгаатай.

Израиль нь Эзэн Есүсийг Мессиа гэж хүлээн авахаас татгалзахад Бурхан Израилийг тодорхой хугацаанд хажуу тийш тавьжээ. Тэр хооронд цоо

шинэ зүйлийг буюу чуулганыг танилцуулав. Хэзээ нэгэн өдөр газар дэлхий дээр чуулганаар ажиллах хөтөлбөр нь дуусахад Бурхан Израильтай ажиллах ажлаа үргэлжлүүлнэ. Тэгэхээр Израильтай харилцах Бурханы харилцаа түр завсардахад орж ирсэн, хаалтад байгаа зүйл бол чуулган юм.

Чуулган ба Израилийн ялгааг дараах байдлаар эсрэгцүүлэн тавьж болох юм.

Чуулган ба Израилийн ялгааг тайлбарласан олон жагсаалт үүсгэж болно. Льюис Сперри Чафер “Системчилсэн теологи” номдоо хорин дөрвөн ялгааг жагсаасан байдаг. Гэхдээ дээр дурдсан зүйлс маань, Бурханы төлөвлөгөө зорилгод чуулган ямар онцгой байр суурь эзэлдгийг болон Израилиас яагаад өөр болохыг харуулахад хангалттай гэж бодож байна.

Израиль ба чуулганыг хольж хутгадаг хэсгүүдийн нэг нь Матай 23:37-25:46 эшлэлд буй Чидун уулан дээрх сургаал. Энэ хэсэг чуулганы тухай бус, Израилийн тухай. Христ дэлхий дээр хаан болж эргэн ирэхийн өмнөх үеийг болон уг эргэн ирэлтийг багтаан, ирээдүйн үйл явдлыг өгүүлдэг. “Иудейд байгсад уул руу зугтааг” гэж 24:16 дээр дурдсаныг харвал газарзүйн байршил нь Израильд байна. Мөн 20-р эшлэлд “Зугтах чинь өвөл эсвэл Амралтын өдөр таарахгүйн тулд залбир” гэсэн. Амралтын өдрийг чуулганд бус зөвхөн Израильд тогтоож өгсөн. Хорин хоёрдугаар эшлэл дэх “сонгогдогсод” гэдэг нь Бурханы сонгосон иудейчүүд юм. Цаашилбал

30-р эшлэлд Христ ирж байгаа нь чуулганаа авахаар агаар мандалд бус, Израилийн Хаан болохоор газар дэлхийд буухыг зөгнөжээ.

Тэгэхээр Библи судлахдаа Израилийг ярьж байна уу эсвэл чуулганыг ярьж байна уу гэдгийг ялгаж салгаж уншаарай. Хэрэв “Эзэний өдөр”-ийн тухай байвал гарцаагүй Израилийг ярьж байна гэсэн үг. Харин “Христийн өдөр” гэвэл чуулганд хамаатай юм ярьж байгаа гэдэгт итгэлтэй байж болно. Тухайлбал, Илчлэл 11-р бүлгийн долоон бүрээ Израильд хамаатай. Яагаад гэвэл, Эзэний өдрийн нэг хэсэг учраас тэр. Харин 1Коринт 15:52-т дурдсан сүүлчийн бүрээ нь шүүрэлтийг ярьж байгаа бөгөөд шүүрэлт нь Христийн өдөрт хамаарах тул чуулганд хамаатай сэдэв юм.

Чуулган бол Израиль мөн гэж мэтгэдэг хүмүүсийн ашигладаг хоёр эшлэлийг энэ сэдвийнхээ төгсгөлд авч үзье:

1. Үйлс 7:38 дээр Израилийг “цөл дэх цуглаан” (KJV орчуулгад “church in the wilderness”) гэж бичжээ. Гэхдээ энд орчуулагдсан “чуулган” (экклесиа) гэх үг нь шууд утгаараа олон хүний цугларлыг хэлсэн гэдгийг ойлгох хэрэгтэй. NKJV орчуулга “congregation” гэж хувилбарыг сонгосон одоо иудейчүүдийн таалалд нийцэж байгаа бөгөөд утгад нь дөхөж очдог. Яг энэ үгээр Ефес дэх шүтээн шүтэгч үймээн дэгдээгчдийн цугларалтыг нэрлэсэн байдаг (Үйл 19:32). Шинэ

гэрээний чуулганыг Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христтэй холбогдуулж бичдэг.

2. Галат 6:16 дээр Паул: “Энэ жишгээр явагч хүмүүс болон Бурханы Израиль дээр амар тайван, өршөөл нь байх болтугай” гэж бичсэн. Эндээс “Бурханы Израиль” гэсэн үгийг авч, өнөөгийн бүх итгэгчид “Бурханы Израиль” мөн гэж маргадаг. Мэдээж Паул, амар тайван ба өршөөлийг бүх итгэгчдэд хүсэн ерөөсөн нь үнэн. Гэхдээ бүх итгэгчдийн дотроос, хуулийн зарчмаар бус, шинэ бүтээлийн зарчмаар (15-р эшлэл) явдаг иудей итгэгчдийг нэмж онцлохдоо “Бурханы Израиль” гэж бичсэн байна. Эх грек дээрээ “энэ жишгээр явагч хүмүүс” гэсний араас “кай” гэсэн холбоос үг байдаг “ба, болон” гэсэн утгатай. Тиймд “бүх итгэгч болон итгэгч иудейчүүд (Бурханы Израиль)” гэж ойлгогдохуйц тодорхой байгаа юм. Харин энэ холбоосыг зарим амилленниал үзэлтэй орчуулагч нар “буюу” гэж орчуулж, чуулганыг “шинэ Израиль” болгох гэж хичээдэг нь харамсалтай.

АРВАН ДОЛОО

ХУУЛЬ БА НИГҮҮЛСЭЛ

Хууль ба нигүүлсэл бол хүн төрөлхтөнд хэрэгжүүлдэг Бурханы эсрэг тэсрэг хоёр арга зам билээ. Бурхан хүнийг сорьж буй харилцан адилгүй хоёр өөр зарчим. Хүмүүстэйгээ байгуулсан хоёр өөр гэрээ: “Учир нь хууль Мосегоор өгөгдсөн бол, нигүүлсэл ба үнэн нь Есүс Христээр ирсэн билээ.” (Иох 1:17)

Хүн хийсэн үйлийнхээ үр дагаврыг авдаг нь хуулийн зарчим. Харин авах байсан ял шийтгэлийг нь хэлтрүүлж, үгээр хэлэхийн аргагүй их ивээлийг хүртээдэг нь нигүүлсэл. Нигүүлсэл бол үнэгүй бэлэг. Эл хоёр зарчмыг Ром 4:4-5 тодорхойлсон нь:

4 Ажилладаг хүний хувьд цалин нь өглөг бус, харин төлбөр гэж тооцогддог. 5 Харин сүсэг бишрэлгүй хүнийг ч зөвтгөдөг Тэрээр үйлддэггүй боловч Өөрт нь итгэдэг нэгний итгэлийг нь зөвд тооцдог.

Хууль ба нигүүлсэл нэг нэгэндээ харш бөгөөд хольж хутгаж огтоос болохгүй. “Хэрэв энэ нь нигүүлслээр юм бол цаашид үйлсээр биш ажээ.” (Ром 11:6)

Хууль бол болзолт гэрээ. Хууль дор Бурхан: “Дуулгавартай дагавал Би чамайг шагнаана. Эс дагавал Би чамайг шийтгэнэ” гэж айлддаг. Нигүүлсэл бол болзолгүй гэрээ: Нигүүлсэл дор Бурхан “Би чамайг үнэгүйгээр ивээж ерөөнө” гэж айлддаг.

Хууль “үйлд” гэдэг бол, нигүүлсэл “итгэ” гэнэ. Гэхдээ “итгэх” нь болзол биш бөгөөд бүтээл нь Бүтээгчдээ үзүүлэх зүй ёсны хариу билээ. Итгэл нь гавьяа ч биш. Эзэнд итгэснээр сайрхах юм хэнд ч үгүй. Харин ч орчлон ертөнцийн цорын ганц найдвартай Хүнд үл итгэх нь тэнэглэл болно.

Хууль ариун байдлыг шаарддаг боловч ариун амьдрах хүчийг өгдөггүй. Нигүүлсэл ариун байдлыг номлодог (Тит 2:11-12) бөгөөд шаардлагатай хүчийг өгдөг. Хэн нэгэн үүнийг ингэж хэлжээ: “Хууль нь хүчгүй хүнээс хүч шаарддаг бөгөөд хүч гаргаагүйнх нь төлөө түүнийг хараадаг. Нигүүлсэл нь юу ч байхгүй хүнд хүч чадал өгч, тэр хүчийг гаргаснаар нь түүнийг ерөөдөг.”

Хууль нь хараалыг авчирдаг: “Хуулийн номд бичигдсэн бүхнийг хэрэгжүүлдэггүй, дагадаггүй хүн бүр хараагдсан” (Гал 3:10б). Нигүүлсэл нь ерөөлийг авчирдаг: “Христ Есүсийн золилтоор дамжуулан Бурханы нигүүлслээр үнэгүй зөвтгөгджээ” (Ром. 3:24).

Хууль сайрхлыг өөхшүүлдэг бол, нигүүлсэл сайрхлыг тасалдаг. “Тэгвэл сайрхал хаана байна? Хаана ч үгүй. Ямар хуулиар зөвтгөгдөх вэ? Үйлсийн хуулиар уу? Үгүй, харин итгэлийн хуулиар юм.” (Ром 3:27).

Хуулийн доор авралын баталгаа үгүй. Та хангалттай сайн үйлс хийсэн эсэх, эсвэл зөв төрлийн сайн үйлс хийсэн эсэхээ хэзээ ч мэдэхгүй. Аврал бол бэлэг учраас нигүүлслийн

дор бүрэн баталгаа бий. Та хэзээ бэлэг авснаа мэднэ.

Хуулийн дор байгаа хүн шаардлагыг үргэлж биелүүлж чадна гэсэн итгэлгүй тул авралын баталгаатай байж чадахгүй. Нигүүлслийн дор итгэгч хүн авралын мөнхийн баталгааг эдэлдэг (Иох 10:27-29). Учир нь түүний аврал нь Христийн төгс ажлаас хамаардаг.

Хуулиас аврал ирдэггүй. Бурхан хүнийг аврах гэж хуулийг өгөөгүй. Хуулийн зорилго нь хүнийг нүгэлтэн гэдгийг харуулах явдал билээ. “Хууль нь нүглийг мэдүүлэгч л юм” (Ром 3:20б). Авралыг мэдүүлэх гэж хэлээгүйг тогтож хараарай.

Аврал нь нигүүлслээс ирдэг (Еф 2:8-9). Диваажинд буюу мөнхийн улсад очих цорын ганц найдвар бол Эзэн Есүс Христ гэж итгэдэг хүмүүст (аврал авах зохисгүй байсан хүмүүст) Бурхан үнэ төлбөргүйгээр авралыг бэлэглэдэг.

Хуулийн дор нүгэл сэрдэг (Ром 7:8-13). Нигүүлслийн дор хүмүүн нүглийг жигшдэг. Нүгэлтнийг хуулийн дор тавихад тэрээр хориглосныг хийхийг хүснэ. Энэ нь хуулийн буруу биш, харин хүний мөн чанарт буй нүглийн хариу үйлдэл юм. Нигүүлслийн дор хүмүүн нүглийг жигшдэг. Бидний нүгэлд Аврагч маань ямар их үнэ төлснийг санах үедээ бид нүглээс холддог.

Хуулийн дор ажил хэзээ ч дуусдаггүй. Тийм учраас долоо дахь өдөр буюу Амралтын өдөр ажлаасаа амардаг аж. Нигүүлсэл бидэнд ажил

дууссаныг хэлдэг. Тийм учраас бидний долоо хоног Эзэний өдрөөс эхэлдэг.

Хүн юу хийх ёстойг хуульд заасан. Нигүүлсэл харин Христ дотор Бурхан юу хийснийг илчилдэг.

Хууль бол боолчлолын систем (Гал 4:1-3). Нигүүлсэл бол эрх чөлөөний систем (Гал 5:1). Хуулийн дор байгаа хүмүүс бол зарц. Нигүүлслийн дор байгаа хүмүүс бол охид, хөвгүүд юм.

Хууль: “Чи хайрла.” Нигүүлсэл: “Бурхан хайрласан.”

Хууль: “Үйлд, тэгвэл чи амьтай болно.”
Нигүүлсэл: “Амийг ав, тэгвэл чи үйлдэнэ.”

Хууль: “Хичээ, дага.” Нигүүлсэл: “Итгэж найд, дага.”

Хууль шаардлага тавьдаг. Нигүүлсэл ивээл хайрладаг.

Хууль хамгийн сайныг ч ялладаг. Нигүүлсэл хамгийн мууг ч зөвтгөдөг.

Хууль бол сахих ёстой зүйл. Нигүүлсэл бол биднийг сахидаг зүйл.

Хууль биднийг шалтаггүй болгодог. Нигүүлсэл биднийг Өмгөөлөгчөөр хангадаг.

Хуулийн дагуу дэг журамгүй хүүг хотын гадна аваачаад үхтэл нь чулуудах ёстой (Дх 21:18-21). Нигүүлслийн дор дэг журамгүй хүү нүглээ улайж, эцгийнхээ гэрт эргэн ирэхэд, эцэг нь баяртайгаар хүлээн авна (Лк 15:21-24).

Хуулийн дор хоньд хоньчныхоо төлөө үхдэг. Нигүүлслийн дор Хоньчин хоньдынхоо төлөө үхсэн (Иох 10:11).

Нигүүлсэл нь шаардлага хангасан сайн хүмүүсийг хайдаггүй. Эс бөгөөс энэ нь нигүүлсэл байхаа болино. Шаардлага хангасан сайныг хүлээн авах нь шударга ёсны ажил билээ. Тэгэхээр нигүүлсэл нь буруутай, ялтай, хэлэх үггүй, аргаа барсан хүмүүсийг хайж, тэднийг аварч, ариусгаж, эцэст нь алдаршуулдаг. Ингэхээр яаж ч бодсон нигүүлсэл нь хуулиас давуу.

“Хэрэв зээ, та хууль ба нигүүлслийн ялгаа салгааг зөв гаргаж чадвал Библийг сайн ойлгох бөгөөд өөрийгөө гайгүй теологич болжээ гэж бодож болно. Энэ ур чадвартаа Бурханд ч талархах нь зүйтэй” хэмээн Мартин Лютер хэлсэн байдаг.

АРВАН НАЙМ

ЧУУЛГАН БА ХААНЧЛАЛ

Чуулган бол Бурханы хаанчлал эсвэл тэнгэрийн хаанчлалаас ялгаатай. Энэ мэдэгдэл олон уншигчдад хачирхалтай санагдах биз. Христийн шашны ертөнцөд чуулган ба хаанчлалыг ихэвчлэн ижил утгаар ярьдаг. Гэвч тэдгээрийг ялгаж салгахгүй байх нь сургаал болон практикийн аль алинд нь ноцтой асуудал үүсгэдэг.

Арван зургаадугаар бүлэгт бид чуулганы талаар нэлээд олон зүйл хөндсөн тул нэг ярьснаа дахин ярих шаардлагагүй биз ээ. Чуулган нь Бурхан хүн төрөлхтөнтэй харилцах бусдаас ялгаатай өвөрмөц бүтэц бүхий институт гэдгийг сануулахад хангалттай. Христ бол чуулганы Тэргүүн бөгөөд бүх итгэгч эрхтнүүд нь юм. Арьс өнгө, нийгмийн байдал, хүйсийн ялгааг Христ дотор устгасан. Бүгд Түүний дотор нэг. Чуулганы цаг үе Пентэкостын өдөр эхэлсэн бөгөөд шүүрэлтийн үеэр дуусна. Чуулганыг Христийн бие, Христийн сүйт бүсгүй гэж нэрлэдэг бөгөөд Христийн хаанчлалд Христтэй хамт хаанчилж, Христийн алдрыг хуваалцах хувь тавилантай.

Тэгвэл тэнгэрийн хаанчлалын талаар юу хэлэх вэ?

Тэнгэрийн хаанчлал нь Бурханы ноёрхлыг хүлээн зөвшөөрдөг хүрээ юм. Тэнгэр нь Бурханыг илэрхийлсэн үг. Үүнийг Даниел 4:25-26-д тодорхой харуулсан. 25-р эшлэлд Даниел,

Хамгийн Дээд Нэгэн хүмүүсийн хаанчлалыг захирдаг гэж хэлээд, дараагийн эшлэлд Тэнгэр захирдаг гэж мэдэгдсэн. Тэгэхээр тэнгэрийн хаанчлал Бурханы засаглалыг илэрхийлдэг бөгөөд эл засаглалыг хүмүүс хүлээн зөвшөөрч буй бүх газарт оршино.

Тэнгэрийн хаанчлалд хоёр тал бий. Эхнийх нь гадна харагдах тал буюу Бурханыг их удирдагч гэж хүлээн зөвшөөрдөг хүн бүрийг хамарсан хүрээ. Гэхдээ түүний дотор тал буюу үл үзэгдэх тал нь жинхэнээсээ Христийг хүлээн авсан хүмүүсийг хамарна.



Гадна талын нүдэнд харагдах том хүрээнд, хүлээн зөвшөөрөгч бүх хүн орно. Үнэн ба худал, улаан буудай ба хогийн ургамал аль аль нь энд багтана. Харин дотор талд, зөвхөн Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дахин төрсөн хүмүүс багтдаг.

Хаанчлалын талаарх Библийн бүх эшлэлийг нэгтгэн харьцуулж үзвэл түүний түүхэн хөгжлийг таван үе шатанд хувааж болно.

Хаанчлалыг урьдаас зөгнөв

Эхний үе шат: Хуучин гэрээний бичээсүүд хаанчлалыг зөгнөсөн. Хэзээ ч устахгүй, өөр хүмүүст эрх мэдлээ өгөхгүй хаанчлалыг Бурхан байгуулна гэж Даниел зөгнөсөн (Дан 2:44). Тэрээр мөн Христ ирээд бүх дэлхийг мөнхөд ноёрхохыг урьдчилан харсан (Дан 7:13-14; мөн Иер 23:5-6-г үзнэ үү).

Хаанчлал ойрхон байна

Хоёр дахь үе шат: Хаан биеэр ирсэн тул хаанчлал ойртлоо, Хааны биед хаанчлал ирлээ гэж тодорхойлсон. Эхлээд Баптисч Иохан, дараа нь Есүс, дараа нь шавь нар нь хаанчлал ойртсоныг зарлав (Мт 3:2; 4:17; 10:7). Хаан Өөрийгөө Израилийн ард түмэнд үзүүлэхээр иржээ. Есүс “Би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулсан. Тиймд Бурханы хаанчлал та нарт ирчхээд байна” гэж Есүс хэлсэн (Мт 12:28). Өөр нэг удаа Тэр: “...Бурханы хаанчлал та нарын дунд байна” гэж хэлсэн (Лк 17:21). Хаан газар дэлхийд ирсэн тул хаанчлал Түүнтэй хамт байсан юм. (Энд эш татсан хоёр эшлэл хаанчлалыг “тэнгэрийн хаанчлал” гэлгүй “Бурханы хаанчлал” гэж тодорхойлжээ. Энэ хоёр нэр томъёог Шинэ гэрээ харилцан сольж хэрэглэдэг. Угтаа бол нэг утгатай болохыг доор тайлбарлана.)

Хаанчлалын завсрын үе

Гуравдугаар үе шат: Хаанчлалын завсрын үе буюу түр зуурын хэлбэр. Израилийн ард түмэн

Хаанаасаа татгалзсаны дараа Хаан тэнгэрт буцаж ирэв. Хаан газар дэлхий дээр биеэр байхгүй үед Түүний хаанчлалыг хүлээн зөвшөөрдөг бүх хүмүүсийн зүрх сэтгэлд хаанчлал оршдог бөгөөд хаанчлалын ёс суртахууны зарчмууд өнөөдөр бидэнд хамаатай. Хаанчлалын энэхүү завсрын үеийг Матай 13-р бүлгийн сургаалт зүйрлэлүүдэд дүрсэлсэн.

Хаанчлал биелэлээ олох үе

Хаанчлалын дөрөв дэх үе шат нь бодитоор биелэлээ олох үе. Энэ үед Христ дэлхий дээр мянган жил засаглах бөгөөд энэ үеийг ихэвчлэн Мянган жил гэж нэрлэдэг. Эзэн Есүсийн дүр төрх уулан дээр хувирсан нь ирж буй хаанчлалын сүр жавхланг урьдчилан харуулсан явдал байлаа (Мт 16:28). Есүс “Дорноос хийгээд өрнөөс олноороо ирцгээж, тэнгэрийн хаанчлалд Абрахам, Исаак, Иаковтой хамт ширээнд тухлах болно” гэж хэлсэн нь энэ үеийн тухай юм (Мт 8:11).

Мөнхийн хаанчлал

Тав дахь буюу эцсийн хэлбэр нь мөнхийн хаанчлалын үе. Үүнийг 2Петр 1:11-д “бидний Эзэн ба Аврагч Есүс Христийн мөнх хаанчлал” гэж тодорхойлсон.

Тэнгэрийн хаанчлал ба Бурханы хаанчлал

“Тэнгэрийн хаанчлал” гэсэн хэллэг зөвхөн Матайн сайнмэдээнд тааралдана. “Бурханы

хаанчлал” гэсэн нэр томьёо бүх дөрвөн сайнмэдээнд гарна. Практик талаас яривал, энэ хоёрт ямар ч ялгаа байхгүй. Аль аль нь нэг ижил зүйлийн нэр. Жишээлбэл, Матай 19:23-т Есүс, баян хүн тэнгэрийн хаанчлалд орох хэцүү гэж хэлсэн. Марк 10:23 ба Лук 18:24-т Есүс, ижил үг хэлсэн байдаг ч, Бурханы хаанчлал гэсэн нэр томьёог ашиглажээ. Матайн уг хэсэгт Есүс, эхлээд “тэнгэрийн хаанчлал” гэж ярьснаа, араас нь тухайн зүйлээ ярихдаа “Бурханы хаанчлал” гэж нэр томьёог авч хэрэглэсэн. (Мт 19:23 ба 19:24-ийг харьцуул.).

Тэнгэрийн хаанчлал ба Бурханы хаанчлал гэх хоёр хэллэгийг харилцан сольж хэрэглэсэн бусад хэсгүүд:

Матай 4:17-г Марк 1:15-тай харьцуул

Матай 8:11-ийг Лук 13:29-тэй харьцуул

Матай 10:7-г Лук 9:2-той харьцуул

Матай 11:11-ийг Лук 7:28-тай харьцуул

Матай 13:11-ийг Марк 4:11-тэй харьцуул

Матай 13:31-ийг Марк 4:30-31, Лук 13:18-тай харьцуул

Матай 13:33-ыг Лук 13:20-21-тэй харьцуул

Матай 19:14-ийг Марк 10:14, Лук 18:16-тай харьцуул

Тэнгэрийн хаанчлал гадаад болон дотоод мөн чанартай гэдгийг дээр өгүүлсэн. Бурханы хаанчлал гэж ярьсан ч эл зарчим адил.

Хаанчлалын дотоод үнэн байдлыг дараах эшлэлүүдээс харуулж болно.

Элч Паул “Бурханы хаанчлал бол идэх болон уух явдал бус, харин Ариун Сүнс дорх зөвт байдал, амар тайван хийгээд баяр баясгалан нь юм” (Ром 14:17) гэж хэлэхдээ хаанчлалын дотоод үнэн байдлыг өгүүлжээ. Тэрээр мөн “Бурханы хаанчлал ярианд бус, харин хүч дор байна” (1Ко 4:20) гэдгийг цохон тэмдэглэсэн.

Хаанчлал ба чуулган

Хаанчлал ба чуулганы ялгаа: Христ олны өмнө гарч, нийтэд үйлчилж эхэлснээр хаанчлал эхэлсэн. Пентэкостын өдөр чуулган эхэлсэн (Үйл 2). Бурханы хаанчлал дэлхий сүйрэх хүртэл дэлхий дээр байна. Чуулган зөвхөн шүүрэлт хүртэл дэлхий дээр оршино. Тэгээд хожим нь Христийн хоёр дахь ирэлтээр Христийн сүйт бүсгүйн хувиар, дэлхий дээр хамт хаанчлахаар Христтэй хамт буцаж ирнэ. Өнөөдрийн хувьд, хаанчлалын жинхэнэ дотоод үнэн байдалд багтсан хүмүүс мөн чуулганы ч дотор багтдаг. Энэ нь хаанчлал ба чуулган давхцаж байгаа цорын ганц талбар юм.

**ДӨРӨВДҮГЭЭР
ХЭСЭГ
ЯЛГАА IV:
ИРЭЭДҮЙН ҮЙЛ
ЯВДЛУУД**

АРВАН ЕС

ХРИСТИЙН ХОЁР ИРЭЛТ

Библийг ойлгож, түүнээс ивээл авахын тулд Христийн эхний болон хоёр дахь ирэлтийг ялгаж салгах шаардлагатай. Христийн эхний ирэлт гэдэг нь мэдээж, Бетлехемд малын тэвшинд нялх хүүхэд болон мэндэлснийг хэлж байгаа. Хоёр дахь ирэлт гэдэг нь Христ дэлхий дээр хожим эргэн ирэх тухай. Эхний ирэлтээр Христ зовлон эдэлж, загалмай дээр үхэж, эргэн амилсан. Харин хоёр дахиа ирэхдээ цог жавхлан, алдар суугаа мандуулах болно (1Пт 1:11).

Энэ бүлэгт ерөнхийдөө Христийн хоёр дахь ирэлтийн тухай өгүүлнэ. Аврагч дахин ирэх үнэнийг толилуулна. Дараагийн бүлэгт Христийн хоёр дахь ирэлтийн үе шатуудыг үзнэ.

Хуучин гэрээний эш үзүүлэгчид Мессиа ирэхийг урьдчилан харжээ. Гэхдээ харсан зүйлдээ будилж орхиж. Бурханы Сүнс тэдэнд: Христ (*Мессиагийн* грек нь) ирээд зовлон амсана, бас цог жавхлангаа мандуулна гэж илчилсэн. Христ зовлон эдэлж, цусаа урсгаад үхсэн. Гэхдээ бас бүх дайснуудаа ялж, яруу алдраа бадруулна. Эш үзүүлэгчид энэ хоёрыг яаж уялдахыг ойлгоогүй. Христ дундаа хоёр мянга гаруй жилийн зайтай хоёр удаа ирнэ гэж ухварлаагүй.

Христийн хоёр ирэлтийг Библид ялгамжаагүйгээр, дунд нь ямар нэгэн цаг хугацаа оруулалгүйгээр нийлүүлэн бичсэн байдаг. Эхний болон хоёр дахь ирэлтийг шууд залгаад биччихсэн байдгийг хэдий чинээ хурдан ойлгоно

төдий чинээ бидэнд хэрэгтэй. Зарим жишээг оруулья:

Хоёр ирэлтийг нэг дор бичсэн эшлэлүүд

Дуулал 22-ын эхний хорин нэгэн эшлэл гарцаагүй Христийн анхны ирэлтийн тухай юм. Аврагч загалмай дээр зовж буйг дүрсэлсэн байгаа. Гэтэл 22-р эшлэлээс хүүрнэлийн өнгө аяа илэрхий өөрчлөгддөг. Сүүлийн арван эшлэл хоёр дахь ирэлтийн ялалт ба жавхланг дүрсэлсэн байна

Мөн Исаиа 9:6-7 дээр хоёр ирэлтийг хамт бичжээ:

6 Учир нь бидний төлөө Хөвгүүн төрж, Бидэнд Хүү өгөгдсөн аж. Засаглал Түүний мөрөн дээр байж, Түүний нэрийг Гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна. 7 Давидын сэнтий дээр Түүний хаанчлал дээгүүр засаглал хийгээд амар тайван нь тэлэхүйд эцэс үгүй. Шударга ёс, үнэн зөвөөр үүнийг өдгөөгөөс өнө мөнхөд тогтоон тулна. Түг түмдийн ЭЗЭНий зүтгэл үүнийг гүйцэлдүүлэх болно.

Бетлехемд мэндлэхийг нь “Учир нь бидний төлөө Хөвгүүн төрж, Бидэнд Хүү өгөгдсөн аж” гэж зөгнөөд, араас нь Христийн хоёр дахь ирэлтийг буюу Христ энэ дэлхий дээр хүч чадал, цог жавхлантай хаанчлахаар буцан ирэх үеийг дүрсэлжээ.

Исаиа 49:7 мөн л хоёр ирэлтийг хамт өгүүлдэг:
Хүн бүхэнд жигшигдсэн, үндэстнүүдэд басамжлагдсан, захирагчдын Зарцад хандан Израилийн Аврагч, Ариун Нэгэн, ЭЗЭН ингэж айлдаж байна. Чамайг сонгосон Израилийн Ариун Нэгэн, итгэмжит ЭЗЭНээс болж хаад үзээд босно, ноёд ч сөгдөж мөргөнө.

Хүн бүхэнд жигшигдсэн, үндэстнүүдэд басамжлагдсан, захирагчдын Зарцад – энэ үг Христийн нэг дэх ирэлтийг хэлж байна. Эшлэлийн үлдсэн хэсэг хоёр дахь ирэлтээр болох үйл явдал гэдэг нь тодорхой.

Мөн Исаиа 52:14-15-ыг үзээрэй:

Төрх нь аливаа хүнийхээс, галбир нь хүний хөвгүүдийнхээс илүүгээр зэрэмдэглүүлсэн тул олон хүн Түүнээс болж хирдхийв. Ийнхүү Тэрээр олон үндэстнийг цочооно. Түүнээс болж хаад амаа хамхина. Учир нь, мэдээгүй тэд харах болно. Сонсоогүй тэд ухварлах болно.

Арван дөрөвдүгээр эшлэл загалмайд өлгөгдсөн Аврагчийн дүрслэл. Цовдлуулсан Мессиаг харсан бүхэн Түүний эдэлж буй тэр их зовлон шаналлаас болж хирдхийж байлаа. Тэрээр хүнд танигдахгүй болтлоо зэрэмдэглүүлсэн. Гэтэл арван тавдугаар эшлэлд эрс тэрс дүр зураг харагдана. Аврагчийг буцаж ирэхэд Түүний цог жавхлангаас болж хүмүүс цочирдоно. Галилын нэгэн дорд Хүн хаадын Хаан, эздийн Эзэн болоод эргэн ирэхийг харсан үндэстнүүд хэлэх үггүй болно.

Хоёр ирэлтийг нийлүүлэн бичсэн, хүмүүсийн хамгийн сайн мэддэг эшлэлүүдийн нэг нь Исаиа 61:1-2:

1 Над дээр Эзэн БУРХАНЫ Сүнс байна. Учир нь зовогсдод сайнмэдээ хүргэж, шаналсан зүрхтэйг нь эдгээн, олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглаж, хүлээстэй хүмүүсийг чөлөөлөхийн тулд Намайг Эзэн тосолсон юм. Намайг Тэр илгээсэн юм. 2 Мөн ЭЗЭНий тааламжит жил, Бурханы маань өшөө авах өдрийг тунхаглан, бүх гашиуудагчийг тайвируулан...

Эзэн Есүс Өөрөө Назарын синагогт эндээс эш татсан байдаг (Лк 4:18-19). Эш татахдаа “Эзэний тааламжит жилийг тунхаглах” гэдэг дээр зогссоныг анзаараарай. “Бурханы маань өшөө авах өдрийг тунхаглах” гэж цааш үргэлжлүүлж уншаагүй. Яагаад юм бол? Яагаад гэвэл Христийн эхний ирэлт Эзэний тааламжит жилийг авчирсан болохоор тэр. Харин хоёр дахь ирэлтээр нь Бурханы маань өшөө авах өдөр эхлэх болно.

Үүнтэй ижил жишээ Дуулал 34:15-16 дээр бий:

15 ЭЗЭНий мэлмий зөвт хүн дээр сонор нь тэдний хаихираан дээр байдаг. 16 ЭЗЭНий нүүр царай ёр мууг үйлдэгчдийн эсрэг байдаг нь тэдний дурсамжийг ч дэлхийгээс арилгахын тулд буюу.

Петр энэ хоёр эшлэлийг 1Петр 3:12 дээр эш татахдаа “тэдний дурсамжийг ч дэлхийгээс арилгахын тулд” гэсний наагуур тасалж авсан.

Өмнөх хэсэг нь тэр чигтээ одоо бидний амьдарч буй эрин үед хамаарах учраас тэр. Харин сүүлийн өгүүлбэр Христийн хоёр дахь ирэлт рүү зааж байна.

Эш үзүүлэгч Мика нь Мессиагийн төрөх газрыг Бетлехем байхыг зөгнөсөн (Мик 5:2):

Гэвч Ефратын Бетлехем ээ, Иудагийн овгуудын дунд чи өчүүхэн авч, Надад Израилийг захирах Нэгэн нь Чамаас гарах болно. Тэр нь эртнээс хийгээд мөнхөөс үүдэлтэй.

Мика үүнийхээ араас шууд Христийн хоёр дахь ирэлт рүү үсэрч, Түүнийг дэлхийн зах хязгаар хүртэл агуу болно гэж эш үзүүлсэн (Мик 5:4):

Тэр босож, ЭЗЭНий хүчээр, Бурхан ЭЗЭНийхээ нэрийн сүр жавхлангаар хонин сүргээ хариулах болно. Тэр цагт Тэрээр дэлхийн зах хязгаар хүртэл агуу байх учраас тэд амар тайван амьдрах болно.

Зехариа 9:9 дээр Христийг Иерусалим руу ялгууснаар орох тухай эш үзүүлсэн:

Сион охин оо, үлэмж ихээр баярлагтун! Иерусалим охин оо! Ялалтын уухай хадаагтун! Үзэгтүн, хаан чинь чам уруу очиж байна. Тэр бол зөвт, ялагдашгүй, даруухнаар илжиг унажээ. Илжигний төл болох дудран унажээ.

Гэтэл дараагийнх нь эшлэлд, Христийн хоёр дахь ирэлтийг буюу Христ тэнгисээс тэнгис хүртэл ноёрхох үеийг өгүүлсэн байна:

Би Ефраимаас тэргийг нь, Иерусалимаас морийг нь тастана. Дайны нум тастуулна. Тэр үндэстнүүдэд амар тайвныг тунхаглаж, Түүний ноёрхол тэнгисээс тэнгис, Евфратаас газрын мухарт хүртэл орших болно.

Хуучин гэрээнээс гадна, Шинэ гэрээнд Христийн хоёр ирэлтийг нийлүүлж ярьдаг. Жишээ болгож Лук 1:31-33-ыг харъя:

31 Үзэгтүн, чи хэвлийдээ үртэй болж Хүү төрүүлнэ. Түүнийг чи Есүс гэж нэрлэх болно. 32 Тэр Хүү аугаа Нэгэн болох ба Хамгийн Дээдийн Хүү гэж дуудагдана. Эзэн Бурхан Түүнд өвөг Давидынх нь хаан ширээг өгөх болно. 33 Тэр Иаковын гэрийг үүрд хаанчлах бөгөөд хаанчлалд нь төгсгөл гэж үгүй.

Эхний эшлэл мэдээж Есүсийг төрөх үед биелсэн (Мт 1:25-ыг үз). Харин 32, 33-р эшлэл одоогийн чуулганы үеийг алгасаж, шууд Христ Давидын сэнтийд залрах, дэлхийг хаанчлах үе рүү үсэрсэн байна.

Лук 20:18 дээр Христийн хоёр ирэлтийг ярьсан, битүү утгатай хэсэг бий:

Тэр чулуун дээр унах хүн бүр бутрах бөгөөд хэний дээр энэ чулуу унана, тэр няцарна.

Эшлэлийн эхний хэсэгт чулуу (Христ) дэлхий дээр байлаа. Түүнийг энэ дэлхий дээр байхад зарим хүн Түүн дээр унаж бутарсан. Эшлэлийн хоёр дахь хэсэгт, чулуу тэнгэрээс унаж байна. Христ тэнгэрээс буун ирэхдээ

дуулгаваргүйчүүдийг няцалж, хумхын тоос болгоно.

Христийн хоёр ирэлтийг нийлүүлж өгүүлсэн нь тодорхой харагддаг сүүлийн жишээгээр Еврей 9:26, 28-ыг авъя:

Тийм бишсэн бол, ертөнцийн сууриас хойш Тэр үргэлж зовох ёстой болно. Харин эдүгээ, үеийн төгсгөлд Өөрийгөө тахил болгон нүглийг зайлуулахын тулд Тэр ганц удаа үзэгдсэн юм.

Христ мөн олны нүглийг үүрэхийн тулд ганц удаа өргөгдсөн бөгөөд хоёр дахиа үзэгдэхдээ нүглийг үүрэхийн тулд бус, харин Өөрийг нь тэсэн ядан хүлээгсдийг аврахын тулд ирнэ.

Тэр Өөрөө тахил болоод нүглийг зайлуулахаар нэг удаа үзэгдсэн – Түүний эхний ирэлт. Харин хоёр дахиа ирэхдээ нүглийг үүрэхийн тулд бус, Өөрийн хүмүүсийг аврахын тулд ирнэ.

ХОРЬ

ХРИСТИЙН ХОЁР ДАХЬ ИРЭЛТИЙН ҮЕ ШАТУУД

Христийн эхний болон хоёр дахь ирэлтийг хооронд нь ялгаж салгах шаардлагатайг өмнөх бүлэгт ярьсан. Эхнийх нь одоо түүх болжээ. Тэр цагаас хойш хэдийнээ 2000 гаруй жил өнгөрчээ. Хоёр дахь нь харин ирээдүйд биелэлээ хүлээж байгаа эш үзүүллэг.

Гэхдээ Христийн хоёр дахь ирэлт нэг удаагийн үйл явдал болохгүй. Үүнийг мэдэх хэрэгтэй. Хоёр дахь ирэлт нь хэд хэдэн үе шаттай, тодорхой хугацаанд өрнөх үйл явдал. Энэ үе шатуудыг энэ бүлгээр тодруулахыг зорилоо.

Шинэ гэрээг анх бичсэн грек хэлэнд нийтлэг хэрэглэдэг “ирэх” гэсэн үг нь “байх”, “ирээд байх” гэсэн санааг агуулдаг (*пароусиа*). Ирээд, ирсэн газраа тодорхой хугацаанд байх гэсэн утга илэрхийлдэг. Эзэн хаан ирлээ гэвэл, эзэн хааны айлчлалаас гадна, энэ тэрүүгээр орох, тухайн газартаа тодорхой хугацааг өнгөрүүлснийг хэлнэ.

Англи хэлэнд ч ирэх гэж үг ийм утгаар хэрэглэгддэг. Жишээ нь, Христ Галилд ирээд хүмүүсийг эдгээсэн гэвэл, Галилд орж ирснийг нь зөвхөн яриагүй. Харин тэндээ өнгөрөөсөн хугацааг ч мөн хамруулан ярьж байгаа.

Тэгэхээр, Христийн хоёр дахь ирэлт гэхээр ганц удаагийн үйл явдлыг бус, тодорхой хугацааг бодох хэрэгтэй. Энэ хугацаа нь дөрвөн үе шаттай байна:

1. Эхлэл
2. Үргэлжлэл
3. Илчлэлт
4. Төгсгөл

1. Христийн ирэлтийн эхлэл

Христийн ирэлтийн эхлэлийг *Rapture* (өргөгдөл, *шүүрэлт*, дээш татагдалт) гэж нэрлэдэг. Христ ариун хүмүүсээ авахаар ирэхийг *шүүрэлт* гэнэ. *Шүүрэлт* нь Библийн латин орчуулгын 1Тесалоник 4:17-оос англи хэлэнд орж ирсэн үг бөгөөд “шүүрч авах” гэсэн утгатай. Энэ үед Христ агаарт буун ирнэ. Христ дотор нас барсан хүмүүс амилна. Амьд байх итгэгчид өөрчлөгдөнө. Бүгд Эцэгийн гэр рүү дээш явна. Энэ үйл явдал хэзээ ч болж мэднэ. Бас хормын дотор болж өнгөрнө.

22 Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдоно. 23 Харин тус бүр өөрийн дараалалтай байна. Христ бол анхны үр жимс, дараа нь Түүнийг ирэхэд Христийнхэн амилуулагдана. (1Ко 15:22-23)

13 Ах дүү нар аа, нойрсогчдын талаар та нар эс мэдэхийг бид хүсэхгүй байна. Эс бөгөөс та нар найдваргүйчүүдийн адил гашиудах вий. 14 Учир нь бид Есүс үхсэн бөгөөд амилсанд итгэдэг агаад Есүсээр нойрсогсдыг Бурхан Түүний хамт тийнхүү авчирна. 15 Бид үүнийг Эзэний үгээр та нарт хэлье. Эзэнийг иртэл амьд үлдсэн бид нойрсогчдын өмнө орохгүй. 16 Учир нь, Эзэн Өөрөө тушаалын уухай, тэргүүн тэнгэрэлчийн

дуу ба Бурханы бүрээн дуугаар тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христ дотор үхэгсэд эхлээд амилна. 17 Дараа нь амьд үлдсэн бид тэдэнтэй хамт агаарт Эзэнтэй уулзахаар үүлэн дунд өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно. 18 Тиймээс эдгээр үгсээр бие биеэ тайвшруул. (1Тс 4:13-18)

Ах дүү нар аа, бидний Эзэн Есүс Христийн ирэх хийгээд бид Түүн өөд цуглах тухайд бид та нараас гуйж байна. (2Тс 2:1)

7 Тиймээс ах дүү нар аа, Эзэнийг ирэх хүртэл тэвчээртэй байгтун. Харагтун, тариачин хөрсний үнэт үр жимсийг хүлээдэг. Ингэхдээ тэр эрт ба оройтсон бороог ортол тэсвэртэй хүлээдэг юм. 8 Та нар ч бас тэвчээртэй бай. Эзэний ирэх ойртсон тул зүрхээ чангал. (Иак 5:7-8)

Бяцхан хүүхдүүд ээ, одоо та нар Түүний дотор бай. Тэгвэл Түүнийг илчлэгдэхэд бид Түүний өмнө зоригтой байж, Түүнийг ирэхэд өмнө нь ичгүүр үгүй байх болно. (1Ио 2:28)

Шүүрэлтийг харж болох өөр хэсгүүд гэвэл Иохан 14:1-4; 1Коринт 15:51-54; Филиппой 3:20-21; 1Тесалоник 1:10; Еврей 9:28; 1Ио 3:2; Илчлэл 22:7, 20.

2. Христийн ирэлтийн үргэлжлэл

Христийн ирэлтийн хоёр дахь үе шат болох үргэлжлэл хэсэгт Христийн шүүх суудал багтана. Энэ үед итгэгчид итгэмжит үйлчлэлийнхээ шагналыг авна.

Учир нь Эзэн Есүсийг ирэхэд Түүний өмнө хэн бидний найдвар эсвэл баяр баясгалан эсвэл өргөмжлөлийн титэм бэ? Энэ нь та нар бус уу? (1Тс 2:19)

Амар амгалангийн Бурхан Өөрөө та нарыг бүрэн ариусгатугай. Сүнс, сэтгэл, бие тань бүхлээрээ бидний Эзэн Есүс Христийг ирэхэд гэм зэмгүй хэвээр байх болтугай. (1Тс 5:23)

Мөн Ром 14:10-12; 1Коринт 3:11-15; 2Коринт 5:10; 2Тимот 4:7-8-ыг үзнэ үү.

Христийн ирэлтийн үргэлжлэл үе шатанд Хурганы хурим болно. Илчлэл номд бичигдсэн байршлаас нь дүгнээд, Хурганы хуримыг бид Христийн жавхланта хаанчлалын өмнө болно гэж үзсэн. Хэдийгээр энд “ирэх” гэж хэрэглээгүй ч Христийн ирэлтэй холбоотой үйл явдал мөн.

6 *Хурсан олны дуу шиг, их усны шуугиан мэт, хүчит аянгын нүргээн адил “Халлелуяа! Төгс хүчит Эзэн Бурхан маань хаанчилж байна” гэхийг би сонсов. 7 “Баярлан хөөрч, Түүнд алдрыг нь өргөн өргөмжилцгөөе. Учир нь Хурганы хурим болж, сүйт бүсгүй нь өөрийгөө бэлдэв.” 8 Тэрээр гялалзсан, цэвэр, нарийн маалингаар хувцаслах болжээ. Учир нь нарийн маалинга нь ариун хүмүүсийн зөвт үйлс юм. 9 Тэр надад “Хурганы хуримын зоогт уригдагсад ерөөлтэй еэ!” гэж бичигтүн гээд “Эдгээр нь Бурханы үнэн үгс мөн” гэлээ. (Илч 19:6-9)*

Энэ бүхэн тэнгэрт болж байх зуур, газар дэлхийд гамшиг зовлон нүүрлэнэ. Бурхан газар дэлхий дээр шүүлт буулгах энэ хугацаа долоон

жил байна (Дан 9:27; Мт 24:4-28; Илч 6-19). Энэ хугацааны сүүлийн хагасыг Их зовлонгийн үе гэж нэрлэдэг ба өмнө нь хэзээ ч нүүрлэж байгаагүй тийм их гамшиг сүйрэл, зовлон шаналал ирэх болно (Мт 24:15-31).

3. Христийн ирэлтийн илчлэлт

Гурав дахь үе шат нь Христийн ирэлтийн *илчлэлт*. Энэ үед Христ энэ дэлхийд хаадын Хаан, эздийн Эзэн болж хаанчлахаар сүр хүч, алдар суу, яруу жавхлангаа мандуулан эргэн ирнэ. Шүүрэлт болоход энэ дэлхий Христийг харахгүй. Энэ нь нүд ирмэхийн зуурт болоод өнгөрнө. Харин Христ хаанчлахаар эргэн ирэхийг нүд бүр харна. Тиймээс энэ үеийг Христийн ирэлтийн *илчлэлт* гэж нэрлэдэг.

Түүнийг Чидун ууланд сууж байхад шавь нар хэдүүлхнээ Түүн дээр ирж “Энэ нь хэзээ болох вэ?

Таны залрал болон үеийн төгсгөлийн тэмдэг юу байх вэ? Бидэнд хэлээч” гэсэнд (Мт 24:3)

Аянга зүүн зүгээс цахилж, баруун зүг хүртэл гялбуулдаг шиг, Хүний Хүүгийн залрал тийм байх болно. (Мт 24:27)

Учир нь Хүний Хүүгийн залрал Ноагийн өдрүүдтэй адил байх юм. (Мт 24:37)

Үер бууж, бүгдийг хаман одох хүртэл тэд мэдээгүй юм. Хүний Хүүгийн залрал ийм байх болно. (Мт 24:39)

Ингэснээр Эзэн Есүс маань бүх ариун хүнтэйгээ хамт ирэхэд бидний Бурхан бөгөөд Эцэгийн өмнө Тэр та нарын зурхийг ариун чанар дор гэм зэмгүй гэж батална. (1Тс 3:13)

Дараа нь хуульгүй нэгэн илчлэгдэх бөгөөд Эзэн [Есүс] амныхаа амьсгалаар түүнийг алж, ирэлтийн төрхөөрөө арилгана. (2Тс 2:8)

Бид Эзэн Есүс Христийнхээ хүч чадал ба Түүний ирэх тухай та нарт мэдүүлэхдээ ухаалгаар зохиогдсон домгуудыг дагаагүй, харин бид Түүний сүр жавхланг нүдээр гэрчлэгчид байсан. (2Пт 1:16) (Петр хоёр нөхрийнхөө хамт уулан дээр Эзэний дүр хувирсныг харсныгаа энд Христийн ирэлтийн илчлэлтийг урьдчилж харсан явдал гэж тайлбарлаж байна.)

Христийн ирэлтийн энэхүү гурав дахь үе шатыг харж болох өөр эшлэлүүд: Зехариа 14:4; Малахи 4:1-3; Үйлс 1:11; 2Тесалоник 1:7-9; Иуда 14; Илчлэл 1:7; 19:11-16.

Хоёр дахь ирэлтэд Христийг Хүний Хүү гэж дурдсан бол үргэлж энэхүү гуравдугаар үе шатыг ярьсан байдаг.

4. Христийн ирэлтийн төгсгөл

Христийн ирэлтийн төгсгөл, сүүлийн үе шатанд тэнгэр газар галаар устгагдана. Энэ үйл явдал Христ мянган жил дэлхийг хаанчилсны дараа болно. Энэ тухай 2Петр 3:4, 7-13 дээр ярьсан:

Мөн тэд “Түүний ирэх амлалт нь хаана байна вэ? Эцэг өвгөдийг унтсанаас хойш бүх юмс бүтээлийн эхнээс байсан шигээ хэвээрээ байна шүү дээ” хэмээнэ.

7 Харин өнөөгийн тэнгэр ба газар нь Түүний үгээр байгаа бөгөөд галд зориулагдан, сүсэг бишрэлгүй хүмүүсийн шүүлт ба сүйрлийн өдөрт хадгалагдаж байна. 8 Хайртууд минь, Эзэний хувьд харин нэг өдөр нь мянган жил мэт, мянган жил нь нэг өдөр мэт байдаг нь та нараас бүү нууцлагдаг. 9 Эзэн удаашралыг тооцдог зарим хүмүүсийн боддог шиг амлалтдаа хойрго биш билээ. Харин ч Тэр, хэнийг ч мөхүүлэхийг хүсэлгүй, бүгдийг гэмшилд ирээсэй хэмээн хүсэж та нарт тэвчээртэй ханддаг. 10 Гэвч Эзэний өдөр хулгайч мэт ирэх болно. Тэгэхэд тэнгэр нүргэн өнгөрч, язгуур юмс галд хайлах бөгөөд газар ба түүн дээрх бүх үйл шатна. 11 Энэ бүхэн тийн устгагдах аваас ариун байдал ба итгэл сүсэг дор та нар ямаршуу байх ёстой вэ? 12 Бурханы өдөр ирэхийг хүлээж, түргэлүүл. Тэр өдөр тэнгэр шатан устаж, язгуур юмс түймэрт хайлах болно. 13 Харин Түүний амлалтын дагуу зөвт байдал оршдог шинэ тэнгэр, шинэ газрыг бид хүлээн байна.

Эцсийн өдрүүдэд элэглэн дооглогчид Христийн эргэн ирэхийг няцаах тухай энэ хэсэгт ярьжээ. Тэд Христийн эргэн ирэлтийн аль үе шатыг ярьсан бэ?

Шүүрэлтийг ярьсан уу? Үгүй. Тэд шүүрэлтийн тухай юу ч мэдэхгүй байж таараа. Христ хаанчлахаар эргэн ирэхийг ярьсан уу? Үгүй. Хэлсэн үгэнд нь тийм утга харагдсангүй. Хам сэдвээс нь харахад, Эзэн бүх бузар мууг үйлдэгчдийг шийтгэх эцсийн шийтгэлийг л тэд тохуурхаж байна. Нэг ёсондоо, дэлхий дээр Бурханы буулгах эцсийн шүүлт, өөрсдийнх нь нэрлэдгээр “дэлхийн сүйрэл.” “Юунд ч санаа зовох шаардлагагүй юм байна. Бурхан хүмүүний түүхэнд оролцож байгаагүй. Цаашдаа ч оролцохгүй” гэж тэд маргаад, бузар муугаа, үг үйлдлээ үргэлжлүүлэх зөвшөөрлийг өөрсдөдөө олгоно.

Элч Петр тэдний тохуурхалд хариулахдаа ирээдүйд, *Христийн мянган жилийн хаанчлалын дараа*, одоогийн бидний мэддэг тэнгэр газар бүрэн сөнөхийг сануулав. Христийн ирэлтийн энэхүү сүүлийн шат мянган жилийн хаанчлалын дараа болох юм. Түүнээс цааш мөнх эрин эхэлнэ.

Магадгүй зарим нь: “Тэгвэл нэг дэх болон гурав дахь үе шат, шүүрэлт болон Христийн илчлэлтийг тусдаа үйл явдал гэж яаж мэдэж байгаа юм бэ?” гэж асуух байх. Ямар ялгаа байгааг доор цэгцтэй харуулъя:

Дээш шүүрэгдэх	Христ илчлэгдэх
1. Христ тэнгэрээс бууж ирнэ (1Тс 4:16-17)	1. Христ газарт бууж ирнэ (Зех 14:4)
2. Христ ариун хүмүүсээ авахаар ирнэ (1Тс 4:16-17)	2. Христ ариун хүмүүстэйгээ хамт ирнэ (1Тс 3:13; Иуд 14)
3. Шүүрэлт бол нууц. Өөрөөр хэлбэл, Хуучин гэрээнд илэрхийлэгдээгүй зүйл (1Ко 15:51)	3. Христ илчлэгдэх нь нууц биш. Энэ нь Хуучин гэрээний эш үзүүллэгийн сэдэв (Дуу 72; Иса 11; Зех 14)
4. Христ ариун хүмүүсээ авахаар ирэхэд өмнө нь тэнгэрт ямар нэг тэмдэг үзэгдэнэ гэж бичээгүй.	4. Христ ариун хүмүүстэйгээ хамт ирэхэд тэнгэрийн тэмдгүүд тунхаглана (Мт 24:29-30)
5. Шүүрэлт нь Христийн өдөртэй холбоотой (1Ко 1:8; 2Ко 1:14; Флп 1:6, 10)	5. Христийн илчлэлт Эзэний өдөртэй холбоотой (2Тс 2:2)
6. Шүүрэлт бол ерөөлт цаг (1Тс 4:18)	6. Христийн илчлэлтийг голчлон шүүлттэй холбон дүрсэлсэн (2Тс 2:8-12)
7. Шүүрэлт нүд ирмэхийн зуур, хормын төдийд болно (1Ко 15:52). Тэгэхээр дэлхий ертөнц энэ үйл явдлыг харж чадахгүй.	7. Христийн илчлэлтийг дэлхий даяар харна (Мт 24:27; Илч 1:7)
8. Шүүрэлтийн гол төвлөрөл нь чуулган байна (Иох 14:1-4; 1Ко 15:51-58; 1Тс 4:13-18)	8. Христийн илчлэлтийн гол төвлөрөл нь Израиль, дараа нь харь үндэстнүүд байна (Мт 24-25)
9. Христ өглөөний гэрэлт од болж ирнэ (Илч 22:16)	9. Христ эдгээгч туяагаар гийгүүлэх зөв шударгын нар болж ирнэ (Мал 4:2)

ХОРИН НЭГ ЭЗЭНИЙ ӨДӨР, ХРИСТИЙН ӨДӨР, БУРХАНЫ ӨДӨР

Бурханы үг, ариун Бичвэрийг судлахдаа ялгаа салгааг нь олж харахын чухлыг та бүхэн мэдэрч байгаа биз ээ. Одоо бүгдээрээ ирээдүйн эш үзүүлэгийг судлахад *Эзэний өдөр*, *Христийн өдөр*, *Бурханы өдөр* хоорондоо ямар ялгаатайг үзэцгээе.

Эзэний өдөр

Энэ нь мэдээж хэрэг 24 цаг бүхий нэг өдөр бус, тодорхой шинж чанар бүхий хугацаа.

Хуучин гэрээнд “Эзэний өдөр” гэсэн ухагдахуун байдаг ба түүний гол онцлог нь шүүлт, шийтгэл, хоосрол, харанхуй (Иса 2:12; Иое 2:1-2). Энэ үед Бурхан Израилийн дайснуудын эсрэг давшиж, тэднийг нэг мөр шийтгэнэ (Зеф 3:8-12; Иое 3:14-16; Оба 15-16; Зех 12:8-9). Энэ үед мөн Бурхан Өөрийнхөө ард түмнийг шүтээн шүтлэг, урвалтынх нь төлөө шийтгэнэ (Иое 1:15-20; Амо 5:18; Зеф 1:7-18). Эзэний өдөр нь голчлон нүглийн шийтгэл ба Эзэний үйл хэрэг ялалтад хүрэх тухай билээ (Иое 2:31-32).

Шинэ гэрээнд Эзэний өдрийг өөрөөр “цаг хугацаа болон үе” (Үйл 1:7; 1Тс 5:1) гэж бичсэн байдаг. Энэхүү цаг хугацаа ба үе нь шүүрэлтийн дараа эхэлж, дараах үйл явдлуудыг дотроо агуулна. Үүнд:

1. *Зовлонгийн үе* буюу *Иаковын зовлон шаналангийн үе* (Дан 9:27; Мт 24:4-28; 1Тс 5:1-11; 2Тс 2:2; Илч 6:1-19:16). Энэ бол Эзэний өдрийн эхний үе шат бөгөөд шөнийн хулгайч мэт гэнэт ирнэ. Бодоогүй цагт, гэнэтхэн, асар их сүйрэл дагуулж, зугтах аргагүй, гарцаагүй ирнэ. Хугацаа нь долоон жил. Бурхан хуурамч иудейзм, хуурамч христитгэл болон харь үндэстнүүд дээр шийтгэлээ асгана. Шийтгэл нь улам өсөн нэмэгдэж, эрчимжиж явагдана. Үүнийг Илчлэл номын долоон лац, долоон бүрээ долоон аяганы бэлгэдлүүд харуулдаг. Зовлонгийн үеийн сүүлийн хагасыг их гамшгийн үе, эсвэл их зовлонгийн үе гэж нэрлэдэг. Энэ нь дэлхий ертөнцөд урьд өмнө хэзээ ч нүүрлээгүй тийм их зовлон шаналал, гамшиг сүйрлийн үе байх болно.
2. *Христ ариун нэгнүүдтэйгээ хамт ирнэ* (Мал 4:1-3; 2Тс 1:7-9). Их зовлонгийн үеийн төгсгөлд Эзэн Есүс хүчит тэнгэрэлч нартайгаа хамт дэлхийд ахин ирээд “Бурханыг мэддэггүй ба бидний Эзэн Есүсийн сайнмэдээг дагадаггүй хүмүүсээс дүрэлзэх галд өшөө авах аж” (2Тс 1:8). Дэлхий дээр хаанчлалаа байгуулахын өмнө бүх дайснаа устгана.
3. *Христийн мянган жилийн хаанчлал* Эзэний өдөрт багтдаг (Иое 3:18; үүнийг 14-р эшлэлтэй харьцуул. Зех 14:8-9;

үүнийг 1-р эшлэлтэй харьцуул). Энэ үед Эзэний эсрэг тэрсэлсэн болгон шийтгүүлнэ (Иса 65:17-25). Хаан дэлхийг төмөр таягаар захирна (Илч 19:15).

4. *Тэнгэр газар галаар устгагдана* (2Пт 3:7, 10). Христийн мянган жилийн хаанчлал төгсөхөд их нүргээнтэйгээр тэнгэр газар өнгөрөн одож, бүх бодис нь халуун галд хайлна. Ингээд Эзэний өдөр дуусна.

Христийн өдөр

Эзэний өдөр гэдэг нь Бурханы Хүүгээс татгалзсан дэлхийг шийтгэх цаг. Харин *Христийн* өдөр гэж Христэд найдвараа тавьсан бүхэнд буюу чуулганы гишүүдэд ивээл ерөөлийн цаг байна. Эзэний өдөр нь Эзэн Есүсийн өдөр, Есүс Христийн өдөр, Эзэн Есүс Христийн өдөртэй ижил. Энэ өдөрт дараах хоёр үйл явдал болно. Үүнд

1. *Ариун хүмүүсийн шүүрэлт* (1Ко 5:5; Флп 1:6, 10). Христ дотор үхсэн хүмүүс амилна. Амьд байх итгэгчид өөрчлөгдөнө. Хамтдаа тэд дээш авагдаж, агаарт Эзэнтэй уулзаж, Түүнтэй хамт Эцэгийн гэр ба тэнгэр рүү явна.
2. *Христийн шүүх суудал* (1Ко 1:8; 2Ко 1:14; Флп 2:16). Итгэгчид шүүх суудал (*бэма*)-ын өмнө зогсож, ажлаа тайлагнан, шагналаа авна. Энд тэдний авралыг шийдэхгүй. Харин үйлчлэлийг нь шалгана. Христийн сайшаалыг хүртэгсэд

шагнуулна. Амьдралаа үрэн таран хийгсэд хохирол амсана. Өөрсдөө тэд “гал дундуур гарсан мэт” аврагдана (1Кор 3:15).

Жэймс хааны орчуулга (KJV) 2Тесалоник 2:2 дээр “Христийн өдөр” гэж ташаа орчуулсан байдаг. Үүнийг “Эзэний өдөр” гэх нь зөв гэж ихэнх Библийн эрдэмтэд үздэг. Тесалоникийн итгэгчид хатуу сорилгод байсныгаа Эзэний өдрийн шүүлт шийтгэл эхэлчихлээ хэмээн андуу бодсон. Эзэний өдөр ирэхээс өмнө дэлхий нийтээрээ итгэлээс гажиж, ёс бусын хүн буюу антихрист гарч ирнэ – энэ хоёр үйл явдал болохоос нааш Эзэний өдөр ирэхгүй гэж Паул тесалоникчуудын санааг амраажээ.

Тесалоникчууд *Христийн өдрөөс* айх үндэслэл байхгүй. Тэдний хувьд Христийн өдөр нь сорилтоос, зовлонгоос үүрд аврагдах баяр хөөрийн өдөр билээ.

Бурханы өдөр

Бурханы өдрийг Эзэний өдөр болон Христийн өдөртэй адилтган бодож, хольж хутгаж болохгүй. Энэ бол Бурханы сүүлийн ялалтын өдөр. Бүх хилэнц дуусгавар болж, тэнгэр газар галаар устсаны дараа (2Пт 3:12) Бурханы өдөр ирнэ. Өөрөөр хэлбэл, Бурханы өдөр гэдэг нь мөнх эрин үе юм.

ХОРИН ХОЁР ДАВХАР БИЕЛЭЛ

Библийн эш үзүүлэгийг судлах гэж байгаа бол, зарим эш үзүүлэг хоёр биелэлтэй байдгийг мэдэх хэрэгтэй. Бүрэн дүүрэн биеллийнхээ өмнөх төстэй үйл явдлыг давхар хамруулан ярьсан байдаг.

Ариун Сүнсийг асгах

Эш үзүүлэгийн давхар биеллийн сонгодог жишээ бол Бурханы Сүнс асгарах тухай эш үзүүлэг:

28 Дараа нь Би Сүнсээ бүх махбод дээр цутгана. Хөвгүүд, охид чинь эш үзүүлж, хөгшчүүл чинь зүүд зүүдэлж, залуус чинь үзэгдэл үзнэ. 29 Боол шивэгчингүүд дээр ч тэр өдрүүдэд Би Сүнсээ цутгана. 30 Би тэнгэр ба газарт совин ёр үзүүлнэ. Тэр нь цус, гал, утаан баганууд болой. 31 ЭЗЭНий агуу, аймшигт өдөр ирэхийн өмнө нар харанхуйлж, сар цус мэт болно. 32 ЭЗЭНий нэрийг дууддаг бүхэн аврагдах болно... (Иое 2:28-32а)

Элч Петр энэ эшлэлийг Пентэкостын өдөр иш татахдаа “Энэ нь эш үзүүлэгч Иоелээр дамжуулан айлдсанаар болжээ” (Үйл 2:14-21) гэж хэлдэг. Гэхдээ энэ зөгнөл бүрэн утгаараа биеллээ гэсэн санаагаар хэлээгүй юм шүү. Учир нь Иоелын хэлсэн бүх үйл явдал Пентэкостын өдөр болоогүй юм.

Ариун Сүнс бүх махбод дээр цутгагдаагүй. Зөвхөн гурван мянган иудейчүүд дээр асгарсан.

Тэнгэрт совин ёр үзэгдээгүй. Нар харанхуйлж, сар цус мэт болоогүй. Газарт тэмдгүүд үзэгдээгүй. Цус, гал, утаан баганууд бий болоогүй.

Пентэкостын өдөр Иоелын эш үзүүллэг бүрэн бусаар биелсэн юм. Уг эш үзүүллэг Христийн хоёр дахь ирэлт дээр бүрэн утгаараа биелнэ. Түүнийг ирэхийн өмнөхөн тэнгэр газарт тэмдгүүд үзэгдэнэ. Ирснийх нь дараа, мянган жилийн хаанчлалын дэлхий дээрх бүх хүн төрөлхтөн дээр Ариун Сүнс цутгагдана.

Онцгой төрөлтүүд

“Давхар биелэл”-ийн зарчим хүн болгоны мэддэг, онгон төрөлтийг эш үзүүлсэн Исаиа 7:14 дээр тодорхой харагдана:

Тиймээс Эзэн Өөрөө чамд нэгэн тэмдэг өгнө. Үзэгтүн! Нэгэн онгон бүсгүй [еврейгээр алма] хөл хүндтэй болж, Хүү төрүүлж, Түүнийгээ “Иммануел” гэж нэрлэнэ.

Энэ эш үзүүллэг Ахаз хаанд зориулагдсан үг гэдэг нь тодорхой. Тухайн үед нэгэн хүүхэд төрөх бөгөөд ялалт ойрхон буйг илтгэн түүнийг “Бурхан бидэнтэй хамт” гэж нэрлэх аж. Тэр хүү сайн мууг ялгах насанд хүрэхээс өмнө Сири ба Израилийн холбоо нурж, хэдхэн жилийн дотор тэр хүүхэд нутгийнхаа үр шимээс хүртэнэ (15-р эшлэл).

Гэхдээ энэ эш үзүүллэг Христийг төрөхөд бүрэн утгаараа биелсэн юм.

22 Эдүгээ энэ бүхэн тохиолдсон нь эш үзүүлэгчээр дамжуулан Эзэн айлдсан нь биелэгдэхийн тулд бөгөөд ингэхдээ 23 “Харагтун, онгон бүсгүй хүүхэд олж, Хүү төрүүлнэ. Түүнийг Иммануел (орчуулбал «Бурхан бидэнтэй хамт») гэж тэд нэрлэнэ” гэсэн юм. (Мт 1:22-23)

Исаиагийн хэрэглэсэн алма гэх еврей үг нь залуу бүсгүй, онгон эмэгтэйн аль алийг хэлдэг бол, Матай дээр хэрэглэсэн *партэнос* гэж грек үг зөвхөн онгон эмэгтэйг хэлдэг.

Иерусалим руу орох нь

Давхар биеллийн гурав дахь жишээ Дуулал 118:26а дээр бий:

ЭЗЭНий нэрээр Ирэгч нь ерөөлтэй еэ!

Эзэн Есүс загалмайд цовдлогдохын өмнөх ням гарагт Иерусалим руу дудран унаад ороход ард олон ингэж уухайлцгаасан:

Давидын Хүүд Хосанна! Эзэний нэрээр Ирэгч нь ерөөлтэй еэ! Хамгийн Дээдэд Хосанна! (Мт 21:9)

Гэхдээ энэ үед эш үзүүлэлэг бүрэн утгаараа биелээгүйг бид мэднэ. Яагаад гэвэл, сүүлд нь Эзэн Есүс, Иерусалимын төлөө гашуудахдаа ингэж хэлсэн байдаг:

Учир нь Би та нарт хэлье. “Эзэний нэрээр Ирэгч нь ерөөлтэй еэ!” гэж хэлтлээ та нар Намайг харахгүй. (Мт 23:39)

Аврагч маань Өөрийг нь Мессиа ба Хаанаар угтан авах хүмүүс дээр хүч чадал, сүр жавхлантайгаар уулзахаар дэлхийд эргэн ирэхэд энэ эш үзүүллэг бүрэн дүүрнээрээ, эцсийн байдлаар биелэх болно.

Иерусалимын сүйрэл

Хоёр биелэлтэй эш үзүүллэгийн бас нэгэн жишээ бол Иерусалимын сүйрэлтэй холбоотой зөгнөл. Лук 21:20-24 дээр Эзэн Есүс, Иерусалимын сүйрлийг зөгнөсөн. Энэ үг МЭ70 онд, Ромын жанжин Тит, армитайгаа ирж Иерусалимыг бүслэн сүйтгэж, сүмийг газартай тэгшилснийг хэлсэн нь тодорхой байдаг. Гэхдээ Иерусалимын дайснууд бүрэн алга болоогүй бөгөөд Илчлэл 11:2-ыг харвал харь үндэстнүүд их зовлонгийн үед энэ хотыг 42 сар ахин талхлахыг хэлжээ.

Христийн эсрэг тэрслэлт

Дуулал 2:1-2-ыг Үйлс 4:25-26 дээр эш татсан:

25 Юунд харийнхан уурсаж, ард түмнүүд дэмий зүйл сэднэ вэ? 26 Эзэн ба Түүний Христийн эсрэг газар дэлхийн хаад сууцгааж, захирагчид цугларцгаав.

Үйлс 4:27 энэ хэсгийг Христийн цовдлолтой холбон ярьсан байна:

Таны тосолсон, ариун зарц Есүсийн тань эсрэг Херод, Понти Пилат нар харийнхан болон израильчуудтай үнэхээр энэ хотод цугласан билээ.

Энэ бол Дуулал бичээчийн үгсийн урьдчилсан бөгөөд хэсэгчилсэн биелэл байлаа. Харин бүрэн биелэл нь их гамшгийн төгсгөлд болно. Тэр цагт дэлхийн удирдагчид нэгдэж, дэлхийг ноёрхох Христийн хаанчлалыг зогсоох гэж дэмий төлөвлөгөө сэднэ.

Израилийг дахин цуглуулах нь

Давхар биелэлийн сүүлийн жишээгээр Израилийг дахин цуглуулах тухай эш үзүүлэгийг дурдаж болно (Иса 43:5-7; Иер 16:14-15; Езк 36:8-11; 37:21). Езра, Нехемиа номуудад тэмдэглэсэнчлэн, иудейчүүдийн үлдэгсэд Вавилоны цөллөгөөс нутагтаа буцан ирэхэд энэ эш үзүүлэгүүд хэсэгчлэн биелсэн. Гэхдээ үндсэн биелэл нь ирээдүйд хүлээгдсээр л байгаа. Иаковын зовлон шаналангийн өдөр Бурхан сонгосон ард түмнээ дэлхийн өнцөг булан бүрээс цуглуулна (Мт 24:31; Дх 30:3-4; Езк 36:24-32; 37:11-14). Тэр цагт л, зөвхөн тэр үед л энэ эш үзүүлэгүүд бүрэн утгаараа, эцсийн байдлаар биелэх болно.

ТАВДУГААР ХЭСЭГ

ЯЛГАА V: БУСАД

ХОРИН ГУРАВ ДОЛООН ШҮҮЛТ

Библи судлахдаа түүн дотор олон янзын шүүлтийн тухай өгүүлснийг мэдэх нь чухал. Энэ шүүлтүүд ямар хүмүүс дээр, хэзээ, хаана, ямар үндэслэлээр, ямар үр дагавартай гэдгээсээ хамаараад өөр өөр. Жишээлбэл үндэстнүүдийн шүүлтийг их цагаан сэнтийн шүүлттэй адилгаж боддог олон хүн бий. Анхааралтай харвал хоёр шүүлт хоорондоо ялгаатайг мэднэ.

Итгэгч ба үл итгэгч бүгдээрээ Бурханы өмнө зогсоод, шүүхийн шийдвэр сонсохоор нэг доор шүүгдэнэ гэсэн ойлголт Библид үгүй. Библийг няхуур үздэг хэн ч үүнийг харж чадна.

Одоо бүгдээрээ Бурханы үгэнд илчлэгдсэн долоон шүүлтийн ялгаа салгааг авч үзье.

Хүний нүглийн шүүлт

Эзэн Есүс нүглийн шийтгэлийг модон загалмай дээр үүрч байхад Бурхан нүглийг шүүсэн юм. Аврагч ертөнцийн нүгэлтнүүдийн төлөө нас баржээ:

14 *Христийн хайр биднийг албаддаг. Учир нь Нэг нь бүгдийн төлөө үхсэн тул бүгд үхсэн гэж бид ятгагдсан.* 15 *Тэрээр бүгдийн төлөө үхсэн учраас амьд байгсад цаашид өөрсдийн төлөө бус, харин өөрсдийнх нь төлөө үхээд, амилуулагдсан Түүний төлөө амьдрах ёстой.* (2Кор 5:14-15, онцлох хэсгийг тодруулсан)

Тэр Өөрөө бидний нүглийн төлөөх эвлэрүүлэл бөгөөд зөвхөн бидний нүглийн учир төдийгүй,

хамаг ертөнцийн нүглийн учир билээ. (1Ио 2:2, онцлох хэсгийг тодруулсан)

Христ үхэхдээ нүглийн шийтгэлийг төлсөн. Урсгасан цус нь нүглийн эсрэг Бурханы шударга ёсны бүх нэхэмжлэлийг биелүүлсэн. Гэм нүгэлтнийг яллахгүйгээр, түүнд ариун байдлаа тооцон аврах боломжийг Христийн үхэл Бурханд бий болгож өгсөн. Христийн авралын ажил нүглийг зайлуулах хязгааргүй хүчин чадалтай.

Хүн Христийг өөрийн Эзэн ба Аврагчаар хүлээн авахад нүглийн ял зэм, шийтгэлээс үүрд чөлөөлөгдөнө. Тэр хойшид хэзээ ч нүглийн мөнхийн шүүлтэд орохгүй. Учир нь Есүс тэр шүүлтийг үүрчихсэн юм. Бурхан хоёр удаа ял асуухгүй. Итгэгч хүн итгэлээр дамжуулан шүүхийн уучлалыг нэг удаа, бүрмөсөн хүлээн авчээ.

Итгэгч хүн өөрийгөө шүүх шүүлт

Хүн аврагдсанахаа дараа амьдралдаа байгаа бурууг шүүх шаардлага гарна. Мөс чанар нь ямар нэг нүглийг олж харсан даруйд түүнийгээ улайж, таягдан хаях ёстой. 1Коринт 11:27-32 дээр Паулын хэлсэн шүүлт энэ юм:

27 Иймд хэн нэгэн нь зохисгүйгээр Эзэний талхыг идэж, аяганаас уух аваас Эзэний бие ба цусны буруутан болно. 28 Аливаа хүн өөрийгөө шалгаж байгаад талхыг идэж, аяганаас ууг. 29 Учир нь идэж ууж буй хүн биеийг зөв нягтлалгүй идэж, уувал өөртөө шийтгэл авчирна. 30 Үүнээс

болж та нарын дунд сул дорой, өвчтэй нь олон байгаа бөгөөд нэлээд нь нойрсож байна. 31 Бид өөрсдийгөө нягталсан бол шүүгдэхгүй байхсан. 32 Харин бид шүүгдэхдээ ертөнцтэй хамт яллагдахгүйн тулд Эзэнээр сахилгаждаг. 33 Тиймд ах дүүс минь, та нар идэхээр цуглахдаа нэг нэгнийгээ хүлээ. 34 Та нар цуглахдаа шийтгэлд унахгүйн тулд өлссөн хүн байвал тэр нь гэртээ идэг. Үлдсэнийг нь би очоод зохицуулъя.

Итгэгч хүн өөрийн амьдрал дахь нүглийг шүүнэ гэдэг нь түүнийгээ хүлээн зөвшөөрөх, дараа нь улайх, тэгээд түүнээсээ гэдрэг эргэхийг хэлнэ. Ийм шүүлт амьдралд маань байнга хийгдэх ёстой. Эс бөгөөс Еврей 12:3-15 дээр хэлсэнчлэн Эцэг Өөрөө биднийг сахилгажуулна.

Элч Паул өөрийнхөө амьдрал дахь нүглийг шүүхгүй бол христэч үйлчлэлд тэнцэхгүй болно гэдгээ мэддэг байжээ:

Харин ч бусдад тунхагласан атлаа өөрөө тэнцээгүй байх вий гэсэндээ биеэ залхааж, боолчилдог. (1Ко 9:27)

Христийн шүүх суудлын шүүлт

Христийн шүүх суудал гэхээр гэмт хэрэгтний шүүлт шиг зүйл бүү бодоорой. Үүнийг спортын тэмцээний шагнал гардуулах ёслолтой зүйрлэвэл тохирно. Эзэн тэнд буруутныг яллаж шүүхгүй. Харин шагнал гардуулна. Шүүх танхимд болдог хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа бус, ажлын тайланг хянан үзээд, гавьяатны гавьяаг алдаршуулах өдөр.

Бүх итгэгч энэхүү шүүх суудал (грекээр *бэма*)-ын өмнө зогсоно.

Бид бүгдээрээ Бурханы шүүх суудлын өмнө зогсох болно шүү дээ. (Ром 14:10)

Эл аугаа үйл явдал ариун хүмүүсийн амиллын дараа тэнгэрт болно. Итгэгчид бүгд цог жавхлант биеэ авсан байна.

Бурханы хүмүүсийн үйлчлэлд дүн тавигдана:

Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой. (2Ко 5:10)

Зарим нь шагнуулж, зарим нь хохирол амсана:

13...ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Юу гэвээс энэ нь галаар илчлэгдэх ба гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно. 14 Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэрээр шагналаа хүлээн авна. 15 Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр хохирол амсана. (1Ко 3:13-15а)

Арван тавдугаар эшлэлийн сүүлийн өгүүлбэрээс харвал, хохирол амсаж буй хүний аврал энэ шүүлт дээр хөндөгдөхгүй юм:

Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана.

Израилийн шүүлт

Үзэн ядалт, увайгүй хандлага, хавчлага, дарамт, хөнөөл, хядлагыг иудейчүүд шиг олон үзсэн ард түмэн үгүй гэвэл хилсдэхгүй биз. Фашистууд еврейчүүдийг үй олноор нь

хөнөөсөн явдал бол тэр их зовлон, шаналал, үхэл хагацалт түүхийн нэг л хэсэг юм.

Гэхдээ энэ бүхэн дуусах болоогүй. Чуулган дээш авагдсаны дараа Израиль болон бусад үндэстэн долоон жилийн зовлон дундуур гарна. Энэ үед дэлхий дээр хэзээ ч тохиолдож байгаагүй их гамшиг, сүүлийн их зовлон нүүрлэнэ. Энэ үеийг Иеремиа “Иаковын зовлон шаналангийн үе (Иер 30:7) гэж, Эзэн Есүс “гамшиг” гэж нэрлэсэн:

Учир нь ертөнцийн эхнээс өнөөг хүртэл болоогүй мөн хэзээ ч болохгүй гамшиг болно. (Мт 24:21)

Энэ үе дуусахад Мессиа ирнэ. Израиль үндэстэн цугларч, “ард түмнүүдийн цөл” гэж Эзэний нэрлэсэн газарт Эзэнтэй нүүр нүүрээ уулзан шүүхэд орно (Езк 20:33-44).

Тэднийг шүүх гол гэмт хэрэг нь гамшгийн үеэр антихристэд мөргөсөн явдал байх бөгөөд израильчуудын ихэнх нь энэ нүгэлд унана гэж Есүс зөгнөсөн байдаг:

Би Эцэгийнхээ нэрээр ирсэн юм. Гэтэл та нар Намайг хүлээж авдаггүй. Хэрэв өөр нэгэн өөрийнхөө нэрээр ирвэл та нар түүнийг хүлээн авна. (Иох 5:43)

Хааны шүүлтээр авч үзэх нүглүүдийн жагсаалтыг Малахи арай өргөн хүрээнд гарган тавьжээ (Мал 2:1-3:5).

Мессиа-Хааныг эсэргүүцэн тэрсэлсэн бүхэн хаанчлал байгуулагдахаас өмнө устгагдаж, харин Түүний захиргааг хүлээн авснууд цог

жавхлант хаанчлалд нь орж, мянган жилийн турш амар амгалан, хөгжил дэвшлийн хаант улсад амьдрах болно:

26 Ийнхүү бүх [итгэгч] Израиль аврагдах болно. Энэ нь ийн бичигдсэн юм. “Сионоос Чөлөөлөгч гарч ирнэ. Тэр итгэл сүсэггүйдлийг Иаковаас зайлуулна. 27 Би тэдний нүглүүдийг зайлуулах үед энэ нь тэдэнтэй байгуулах Миний гэрээ мөн.” (Ром 11:26-27)

Үндэстнүүдийн шүүлт

Үндэстнүүдийн шүүлтийг бичсэн гол эшлэл бол Матай 25:31-46. Энэ шүүх хурал Христийн хоёр дахь ирэлтээр болно. Шүүгч нь Хүний Хүү, Эзэн Есүс Өөрөө байна:

Хүний Хүү алдраа дуурсган бүх тэнгэрэлчийнхээ хамт ирж, сүр жавхлант сэнтийдээ залрах болно. (31-р эшлэл).

Үндэстнүүдийн шүүлтээр үндэстнүүд Израильд хэрхэн хандсаныг голчлон авч үзнэ гэж эш үзүүлэгч Иоел тодорхой болгож өгчээ (Иое 3:2). Гамшгийн үед Христийн иудей ах дүүсийг хамгаалж, тэдэнд тусалсан үндэстнүүдийг Матай дээр хонь гэж нэрлэсэн. Нөгөө талд, өвчтэй байхад нь эргэж очоогүй, шоронд байхад нь туслаагүй, хоол, унд, хувцсаа харамлаж, зочлоогүй үндэстнүүдийг ямаа гэж нэрлэсэн.

Хонь үндэстнүүд “ертөнцийн сууриас бэлтгэсэн хаанчлалыг” өвлөн авна (34-р эшлэл). Ямаа үндэстнүүд “Хараагдагсад аа, Надаас зайл.

Диавол болоод түүний тэнгэрэлч нарт бэлтгэсэн мөнх галд ор” (41-р эшлэл) гэсэн үгийг сонсоно.

Тэд мөнх шийтгэлд, харин зөвт нь мөнх аминд орох юм. (46-р эшлэл)

Үндэстнүүд аврагдах эсвэл мөхөх гэсэн санааг зарим хүн гайхдаг. Аврал зөвхөн хувь хүний асуудал гэж тэд боддог. Үүнд гайхах зүйлгүй. Түүхийн бүх цаг хугацаанд Бурхан үндэстнүүдтэй ч, хувь хүмүүстэй ч тулж харьцаар ирсэн. Аливаа нэг улсын дийлэнх хүн ам Бурханд тэрслэхэд Бурхан эхлээд дундаас нь хүмүүсээ гаргаж аваад, үлдсэн бүгд дээр нь шийтгэлээ асгадаг. Үүний тод жишээ бол Содом. Илүү өргөн хүрээнд гэвэл усан галавыг дурдаж болно.

Тэнгэрэлч нарын шүүлт

Библи бидний сониуч занг бүрэн хангаж дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй ч гэлээ, унасан зарим тэнгэрэлч нар хоригдоод эцсийн шүүлтийг хүлээж байна гэж дурдсан байдаг:

Учир нь хэрэв нүгэл үйлдсэн тэнгэрэлч нарыг Бурхан хэлтрүүлэлгүй, харин тэднийг тамд хаяад, харанхуйн гинжинд тушааж, шийтгэл хүртэл хадгалсан бол... (2Пт 2:4)

Эрх мэдэл бүхий байр сууриа сахилгүй, харин ч орон байраа орхисон тэнгэрэлч нарыг Тэрээр агуу их өдрийн шүүлтэд мөнхөд хүлээстэй нь харанхуйд хорьжээ. (Иуд 6)

Хоригдоогүй чөлөөтэй яваа унасан тэнгэрэлч нар байгааг ч бид сайн мэднэ. Тэднийг ерөнхийд нь чөтгөрүүд гэж нэрлэдэг. Унасан тэнгэрэлчийн шүүлт хэзээ болох вэ?

Мессиа-Хаан дэлхий дээр хаанчлахдаа “бүх удирдлага, эрх мэдэл, хүчийг хүчингүй болгоод”, “бүх дайснаа хөл дороо оруулна” (1Ко 15:24-25). Тэнгэрлэг газар дахь захирагчид, хүчнүүд, сүнслэг бузар мууг ч энэ үед дарна.

Итгэгчид Христтэй хамт хаанчлах учир тэнгэрэлч нарын шүүлтэд оролцоно. Ийм учраас Паул: “Бид тэнгэрэлч нарыг шүүнэ гэдгийг та нар мэдэхгүй гэж үү?” хэмээн 1Коринт 6:3 дээр асуусан буй заа.

Сатаны эцсийн шүүлт мянган жилийн хаанчлалын дараа, агуу их цагаан сэнтийн өмнө болно:

Тэднийг мэхэлсэн диавол хүхэр бүхий галт нуурт хаягдлаа. Тэнд мөн араатан болоод хуурамч эш үзүүлэгч байх агаад тэд үеийн үед өдөр шөнөгүй тарчилна.

(Илч 20:10)

Унасан тэнгэр элч нар Сатаныг өөрсдийн удирдагч гэж үздэг учир, Бурханд тэрсэлсэн ялыг нь хамт үүрэлцэж, галт нуурт хамт хаягдах нь дамжиггүй (Иса 14:12-17; Езк 28:12-19).

Агуу их цагаан сэнтийн шүүлт

“Цагаан өнгөтэй агуу сэнтий болон дээр нь Залрагчийг би харав. Түүний дүр төрхөөс газар, тэнгэр зугтсан бөгөөд тэдэнд байх газар эс олдов”

(Илч 20:11). Энэ бол Иоханы харсан ирээдүй. Дээр нь залрагч болоод тэнд болох үйл явдлын улмаас тэр сэнтий агуу юм. Шүүлт нь цэвэр ариун учир тэр сэнтий цагаан юм. Эл шүүлт мөнх эринд болно. Бидний мэдэх дэлхий ертөнц халуун галд утсаны дараа гэсэн үг (2Пт 3:10).

“Их, бага үхэгсдийг сэнтийн өмнө зогсохыг би харлаа” (Илч 20:12а). Тэд болбоос бүх цаг үеийн эс уучлагдсан нүгэлтнүүд билээ. Эзэнд итгэлээ тавиагүй учраас тэнд зогсож байгаа нь тэр. Үл итгэл бол мөхөлд хүргэх аймшигт нүгэл мөн.

Харин итгэдэггүй нь хэдийнээ яллуулсан нь Бурханы цор ганц Хүүгийн нэрд итгээгүйн учир юм (Иох 3:18б).

Хүүд дуулгаваргүй нь мөнх амийг эс үзэх бөгөөд Бурханы уур хилэн түүн дээр оршино (Иох3:36б).

Эцсийн тэр шүүлт дээр хоёр ном дэлгээтэй байх ба үүнд бичигдсэнээр шийтгэлийнх нь хэр хэмжээ тодорхойлогдоно:

Үхэгсэд үйлсийнхээ дагуу энэхүү номд бичигдсэнээр шүүгдэв (Илч 20:12б).

Тэдний нэрс амийн номд бичигдээгүй байгаа нь тэд хэзээ ч гэмшээгүй, Христийг Аврагчаа болгон хүлээн аваагүйг илтгэнэ. Тиймд тэд шийтгүүлэх нь тодорхой. Гол нь тамд эдлэх шийтгэл нь хэр хүнд байхыг шүүлтээр тодорхойлно. Мөнхийн улсад шагналын зэрэглэл байдаг шиг, мөнхийн зовлонд шийтгэлийн зэрэглэл байх болно. Жишээлбэл, цуврал алуурчин мөрөөрөө амьдарч байсан

боловч харамсалтай нь аврагдаагүй хөршөөсөө илүү хатуу шитгэл амсана.

Энд Үхэл хүний биеийг, Үхэгсдийн орон сүнс ба сэтгэлийг төлөөлнө. Нэг ёсондоо, тухайн хүн бүхлээрээ галт нуурт хаягдана гэсэн үг:

Тэгээд үхэл ба Үхэгсдийн орон галт нуурт хаягдлаа. Энэ бол хоёр дахь үхэл буюу галт нуур болой. (Илч 20:14)

Цагаан өнгөтэй агуу сэнтийн өмнө итгэгчид зогсохгүй. Гагцхүү, Бурханы өршөөл энэрлийн саналаас татгалзсан, Хурганы амийн номд нэрсээ бичүүлээгүй хүмүүс зогсох болно.

ХОРИН ДӨРӨВ

ҮХЭГСДИЙН ОРОН БА ТАМ

Үхэгсдийн орон ба там хоорондоо ялгаатай. Шинэ гэрээний эх хэл дээрх үгс нь өөр, утгууд нь ч өөр. Нэгийг нь нөгөөгөөр нь орлуулж хэрэглэхүйц ижил утгатай үгс биш¹⁰. Үхэгсдийн орон түр зуурынх, там мөнхийнх. Үхэгсдийн орон нь Хуучин гэрээний *шоэл*-тэй ижил утгатай бол, там нь *гэхэнна* болон галт нууртай ижил утгатай. Үхэгсдийн орныг хэрэг нь эцэслэн шийдэгдээгүй хүмүүсийг түр саатуулах газартай зүйрлэж болно. Харин тамыг ял авсан хүмүүсийг хорьж ялыг нь эдлүүлдэг шоронтой зүйрлэж болно.

Үхэгсдийн орон

Юуны түрүүнд үхэгсдийн орны тухай тайлбарлая. Үүнийг заримдаа тарчлалын газар, заримдаа булш, заримдаа биегүй сүнсээр байгаа байдал гэж ойлгогдохоор дүрсэлжээ. Хаана байдаг тухайд нь тодорхой мэдээлэл Библид үгүй. Үхэгсдийг орныг хамгийн тодорхой

¹⁰Библийн зарим орчуулга үхэгсдийн орон ба тамын ялгааг гаргаж буулгаагүй байдаг. Жэймс хааны орчуулга (KJV)-д гэхэд үхэгсдийн орныг ганцхан 1Коринт 15:55 дээр л булш гэж буулгаад, бусад бүх тохиолдол там гэж орчуулжээ. Үхэгсдийн орон нь “үл үзэгдэх” [ертөнц] гэсэн утгатай грек үг. Там бол гэхэнна гэх еврей үгэнд дүйцсэн англи-саксон буюу эртний англи хэлнээс гаралтай үг. Эзэн Есүс тамын мөнх шийтгэлийн аймгийг ойлгуулахын тулд тасралтгүй гал асаж байдаг газрын нэрээр тамыг нэрлэсэн байна.

дүрсэлсэн нь Лук 16:19-31. Тэнд бичсэнээр, нэгэн үл итгэгч баян эр үхсэн хойноо үхэгсдийн орноос дээш нүдээ өргөөд диваажинд буй Абрахамыг харсан тухай өгүүлдэг. Тэр хүний бие нь булшинд үлдсэн нь тодорхой тул, сүнс сэтгэл нь Үхэгсдийн оронд байсан байж таарна. Гэсэн ч бүхнийг мэдэрч байлаа. Оюун ухаан нь хэвийн байлаа. Урд хойдохоо санах, дээш өнгийх, диваажинг харах тэнхэлтэй байсан. Халуунаас болж тарчилж, цангасан. Дүү нараа энэ тарчлалын газар ирүүлэхгүй байхсан гээд, хэн нэгэн дүү нар руу минь очоосой гэх хүсэл сэтгэлтэй байсан. Үхэгсдийн орныг энд тарчлалын газар гэдгээр дүрсэлжээ. Түүнээс зугтах арга байхгүй.

Гэтэл Үйлс 2:27 дээр үхэгсдийн орныг газар гэхээсээ байр байдлыг илэрхийлсэн байна:

Учир нь Та сэтгэлийг минь Үхэгсдийн оронд орхихгүй, Ариун Нэгэндээ ялзралыг үзүүлэхгүй.

Энд Үхэгсдийн орныг ямар нэг газар гэж ойлгох боломжгүй. Яагаад гэвэл, Эзэн Есүс үхэхэд сүнс сэтгэл нь диваажин¹¹ руу буюу гурав дахь тэнгэр¹² рүү, Бурханы оршдог газар руу явсан билээ. Энэ хэсэгт өгүүлснийг сүнс сэтгэлийн биегүй байдал гэж ойлгохоор байна. Эзэн Есүсийн сүнс сэтгэлийг Бурхан тийм байдалд орхиогүй. Өөрийн Ариун Нэгэнд буюу Аврагчийн биед ялзрахыг зөвшөөрөөгүй.

¹¹Лук 23:43

¹²Коринт 12:2, мөн 4-р эшлэлийг харьцуулан үз.

“Ариун Нэгэн” гэснийг бие гэж ойлгох нь зөв. Учир нь хүнээс зөвхөн бие л ялзардаг. Эзэний сүнс сэтгэл Үхэгсдийн оронд орхигдоогүй гэж Петр зоригтой мэдэгдсэн (Үйл 2:31). Түүний сүнс сэтгэл гурав дахь өдөртөө цог жавхлантай болж өөрчлөгдсөн биетэйгээ эргэн нэгдсэн.

Үхэгсдийн орныг сүнс сэтгэлийн биегүй байдал гэж дүрсэлсэн өөр нэгэн хэсэг бол Илчлэл 20:13-14:

Дотроо байсан үхэгсдийг тэнгис гаргаж өгөв. Үхэл ба Үхэгсдийн орон өөрсдийн доторх үхэгсдийг гаргаж өгөв. Тэдний нэг бүр нь үйлсийнхээ дагуу шүүгдэв. 14 Тэгээд үхэл ба Үхэгсдийн орон галт нуурт хаягдлаа. Энэ бол хоёр дахь үхэл буюу галт нуур болой.

Энд уучлагдаагүй нүгэлтнүүдийн эцсийн шүүлтийг өгүүлсэн. Шүүгч нь үхэл ба үхэгсдийн орны түлхүүрийг атгадаг (Илч 1:18) Эзэн Есүс Өөрөө. Үхэл тэдний биеийг, үхэгсдийн орон тэдний сүнс ба сэтгэлийг төлөөлж байна. Тэдний сүнс ба сэтгэл агуу их цагаан сэнтийн шүүлт дээр биетэйгээр эргэн нийлнэ. Хүн бүхлээрээ галт нуурт хаягдана.

Үхэгсдийн орныг сүнс сэтгэлийн биегүй байдал гэж дүрсэлсэн бас нэгэн хэсэг бол 1Коринт 15:55:

Үхэл ээ, ялалт чинь хаана байна вэ? Үхэгсдийн орон оо, хатгуур чинь хаана байна вэ?

Энэ бол Христийг ахин ирэхэд итгэгчдийн дуулах дуу. Тэдний бие булшнаас гарахад үхлийг бодоод, “Тийм ээ, чи бидний биеийг түр

л барилаа. Үүрд барьж чадсангүй” гэнэ. Үхэгсдийн орныг бодоод “Чи бидний сүнс сэтгэлийг биеэс маань үүрд салгаж чадсангүй. Ялалт чинь богино настай байжээ” гэнэ.

Илчлэл 6:8 дээр “Үхэл” нэртэй зэгэл ногоон морьтныг үхэгсдийн орон дагалдаж явсан тухай бичсэн байна. Дэлхийн хүн амын дөрөвний нэгийг устгах эрх тэдэнд өгөгдсөн гэж цааш нь тайлбарласан. Энд ч мөн үхэл ба үхэгсдийн орныг бие ба сүнс сэтгэлийн салах явдал гэж дүрслэлийн аргаар бичсэн байгаа юм. Үхэл гэдэг бол үнэндээ сүнс, сэтгэл биеэс салах явдал ажээ.

Заримдаа үхэгсдийн орон нь машинд дорд орохын илэрхийлэл болдог. Жишээ нь, Капернаум хот. Капернаум хот хүртсэн боломжоороо тэнгэрт тултал өргөмжлөгдсөн боловч Бурханы Хүүг үл тоосон учир үхэгсдийн оронд ортол ичгүүр гутамшиг, сүйрлийг амссан (Мт 11:23; Лк 10:15).

Дээрх бүгдээс өөр утгаар орсон ганц хэсэг бол Матай 16:18. Өөрийнх нь байгуулах гэж буй чуулганыг үхэгсдийн орны хаалга дийлэхгүй гэж Есүс тэнд амласан. Ямар ч дайралт довтолгоо чуулганыг нурааж чадахгүй, харин ч эсрэгээрээ, чуулган үхэгсдийн орныг гарцаагүй дийлэх болно.

Там

Там гэж үг Шинэ гэрээнд арван хоёр удаа дурдагдсанаас арван нэг нь хүмүүсийг хамгийн ихээр энэрэн хайрладаг Эзэн Есүсийн амнаас

гарсан байна. Арван хоёр дахийг нь Эзэний дүү Иаков хэлжээ.

Энэ аймшигт газрын тухай бид юу мэдэх вэ? Тамыг хүнд бус, диавол болон түүний тэнгэрэлч нарт зориулсан (Мт 25:41). Бурхан хэн нэгнийг сонгож тамд унагадаггүй. Харин хүмүүс Бурханы нигүүлслээс татгалзаж өөрсдөө тамыг сонгодог. Там бол уйлаан, орилоон, шүд хавиралт байдаг газар (Мт 8:12; 22:13; 24:51; 25:30; Лк 13:28). Тамд өт (тарчлал) нь үхэхгүй (дуусахгүй), гал нь унтрахгүй (Мк 9:46). Тэдний зовлон тарчлалын утаа үеийн үед суунаглана (Илч 14:11).

Бүтэн биетэйгээ тамд унаснаас тахир дутуу ч болов аминд орсон нь дээр гэж Есүс хэд хэдэн удаа сануулсан (Мт 5:29-30; 18:9; Мк 9:43, 45, 47). Гэхдээ энэ нь диваажинд тахир дутуу хүн байна гэсэн үг биш юм шүү. Харин, энэ амьдралдаа хүсэл тачаалаа өөгшүүлж яваад мөнхийн шийтгэл хүртсэнээс биеийнхээ дур хүсэлд хатуу хандаж, сахилга баттай бай гэсэн үг.

Итгэгчид бие хөнөөж чадах хүмүүсээс бус, бие ба сэтгэлийг хоёуланг нь тамд хөнөөж¹³ чадах Бурханаас л эмээвэл зохилтой (Мт 10:28; Лк 12:5).

¹³ Хөнөөх гэж үг “ор мөргүй алга болгох” гэсэн санааг агуулаагүй юм шүү. Харин мэнд сайн байдлыг нь үгүй хийх гэсэн санаа. Хүн юм уу, юмсыг анх бүтээгдсэн зорилгынхоо дагуу ажиллах нөхцөлгүй болгох гэсэн утгаар хэрэглэгддэг. Жишээ нь Матай 9:1 дээр дарсны тулам алга болоогүй. Харин хийгдсэн зорилгодоо ашиглагдах аргагүй сүйдсэн.

Ах дүүдээ хорссондоо түүнийг “мунхаг” гэж хараах нь тамд хаягдах хангалттай шалтгаан (Мт 5:22). Бузар үг ярианд тамын шинж чанар оршдог (Иак 3:6). Фарисайчуудын нүгэл тэднийг тамд унах хүмүүс гэдгийг нь харуулсан (Мт 23:15, 33)

Тартарос

2Петр 2:4 дээр “там” гэж орчуулагдсан үг нь грекээрээ *тартарос*¹⁴. Энэ нь нүгэл үйлдсэн, унасан тэнгэрэлч нарт зориулагдсан тусгай газрыг хэлж байна уу гэж харагддаг. Тэд шүүлтээ хүлээн тартарост харанхуйн гинжинд хүлээтэй байдаг.

Ариусгалын газар

Ромын католик сүмийн сургаалд “ариусгалын газар” гэсэн ухагдахуун байдаг. Хүн нас барахад Бурханы нигүүлсэл түүнийг цагаатгахын тулд “түр зуурын” шийтгэлийн газар аваачин шийтгэж, дараа нь суллаад диваажинд оруулна. Үүнийг ариусгалын газар гэж нэрлэдэг. Ариусгалын газрын гал хүний сүнс сэтгэлийг ариусгах нөлөөтэй гэж католикийн сургаалд заадаг. Амьд үлдсэн хүмүүс эсвэл сүм цуглаан тухайн нас барсан хүний нэр дээр залбирал өргөвөл ариусгалын газарт өнгөрөөх хугацаа богиносно гэж номлодог. Библид ийм газрын тухай нэг үг, нэг санаа ч байхгүй бөгөөд энэ нь

¹⁴Латин маягаар бас “тартарус” гэж бичих нь бий.

Эзэн Есүс Христэд итгэснээр дамжуулан
нигүүлслээр аврагдах үнэнтэй бүрэн харш үзэл
мөн.

ХОРИН ТАВ

БИЧВЭРИЙН НУУЦУУД

Шинэ гэрээ бидэнд хэд хэдэн нууцыг толилуулдаг. Хүмүүс Шинэ гэрээнд ярьж буй нууцуудыг хольж хутгах гэхээсээ, анхнаасаа сайн ойлгодоггүйд гол асуудал оршдог. Тиймээс бид тусгайлан нэг бүлгийг энэ сэдэв дээр зориулж байна. Шинэ гэрээнд ямар нууцуудыг өгүүлсэн тухай тус бүрт нь товч тайлбарлана.

Тодорхойлолт

Нууц – Өмнө нь хэнд ч илчлэгдэж байгаагүй, бас хүн өөрийн оюун ухаанаар ойлгох аргагүй байсан боловч Бурхан эдүгээ илчилчихсэн байгаа үнэн. Англи хэлний *mystery* гэж үг нь грек дээрх *μυστήριον* гэдгийн англи маягтай болгосон хэлбэр юм.

Тэнгэрийн хаанчлалын нууцууд Матай 13:3-50

Матай 13:11 дээр “тэнгэрийн хаанчлалын нууцууд” гэх үг гарна. Тэгээд тэр бүлэг эл нууцыг долоон сургаалт зүйрлэлээр тайлбарладаг.

Матай номын эхний бүлгүүдэд Эзэн Есүс Өөрийгөө Мессиа-Хаан гэж Израильд танилцуулж буйг бид уншдаг. Гэтэл 12-р бүлэгт шашны удирдагчид Түүнээс татгалзаж, Беелзебүл (диавол)-ын хүчээр гайхамшиг үйлддэг хэмээн Түүнийг буруутгасан. Хаанаас татгалзсан тул хаанчлал өөр хэлбэрт шилжихээр

болов. Энэ тухай Матай 13-р бүлэгт ярьсан. Хааныг үгүйсгэсэн цагаас эхлээд Хаан буцан ирж хаанчлалаа байгуулах хүртэлх хугацаанд хаанчлалын *түр* хэлбэрт байх ба энэ тухай эл долоон сургаалт зүйрлэл өгүүлдэг. Хааныг эзгүй байхад Түүний ноёрхлыг амаараа хүлээн зөвшөөрсөн хүн бүр хаанчлалд багтдаг. Тэр хаанчлалд аман мэдэгдэл ба үнэн байдал хоёул байх ажээ. Одоо бид тэр цаг үед амьдарч байна.

Энэ түр хугацаа дуусахад буудайг хивэг хогноос цэвэрлэнэ. Үнэнийг худлаас салгана. Хоосон амыг чин сэтгэлээс ялгана. Хааны үнэн албатууд мянган жилийн хаанчлалын ерөөлийг хүртэж, худлууд устгагдана.

Израилийн сохролын нууц Ром 11:25

Израиль Хаанаасаа татгалзсан учраас Бурхан тэднийг шийтгэж сохруулсан. Өнөөдөр иудейчүүд яагаад Есүсийг Мессиа гэж хүлээн авахгүй, тэднээс маш цөөн хүн аврагдаж байгаагийн нэг тайлбар энэ юм. Гэхдээ энэ сохрол бүх еврейчүүдэд буулгасан шийтгэл биш. Эсвэл үүрд ийм байхгүй. Есүс бол эш үзүүлэгчдийн ярьсан Нэгэн мөн юм байна гэдгийг ойлгож эхэлсэн еврейчүүд бий болсоор байна (Ялангуяа тэдэнд сайнаар ханддаг улс орнуудад). Мөн энэ сохрол “харь үндэстнүүдийн дүүрэх” хүртэл л үргэлжилнэ. Өөрөөр хэлбэл, голчлон харь үндэстнүүдээс бүрдэх чуулганаа Эзэн дээш шүүрэн авч, Эцэгийн гэр рүү авч явах

хүртэл гэсэн үг. Тэгээд Израилийн итгэгч үлдэгсэд Христ рүү эргэх болно.

Шүүрэлтийн нууц 1Коринт 15:51-52

Эдүгээг хүртэл хүн төрөлхтний бүх түүхэнд хүн бүр эрт орой хэзээ нэгэн цагт үхнэ гэж итгэж ирсэн. Гэтэл зарим итгэгч үхэхгүй гэж элч Паул мэдэгдсэн байдаг. Шүүрэлт болоход амьд байх итгэгчид үхэлгүйгээр тэнгэр рүү явна. Тэд өөрчлөгдөнө. Цог жавхлант биеэ авна. Тэгээд үхлийг хэзээ ч үзэхгүй. Христ дотор нас барсан хүмүүс үхлээс амилж, амьд байх ариун хүмүүстэй хамт тэнгэр рүү дээш өргөгдөн авагдана. Нэмэлт мэдээллийг 1Тесалоник 4:13-18 дээрээс үзэж болно.

Чуулганы нууц Ром 16:25; Ефес 3:4-5

Чуулган бол ертөнцийн эхнээс аваад огт илчлэгдэж байгаагүй, далд, нууц байсан зүйл (Ром 16:25). Харин Шинэ гэрээний үед элч нар болон эш үзүүлэгчдээр дамжуулан илчлэгджээ (Еф 3:5). Энэ нууц дараах чухал зүйлсийг агуулдаг. Үүнд:

1. Тэргүүн нь Христ (Кол 1:18).
2. Эрхтнүүд нь бүх итгэгч (1Ко 12:13).
3. Итгэгч харь үндэстэн, итгэгч иудейчүүдтэй адил тэнцүү байх ба Христ тэдний бүгдийнх нь алдрын найдвар юм. Иудейчүүд болон харь үндэстнүүдийн хооронд байсан эртний дайсагнал

Христийн дотор үгүй болсон (Еф 3:6; Кол 1:26-27; Еф 2:14-15).

4. Чуулган бол Христийн бие (1Ко 12:12-13).
5. Чуулган бол Христийн сүйт бүсгүй (Еф 5:25-27; 31-32).
6. Чуулган бол тэнгэрлэг оршихуй дахь захирагчид болон эрх мэдэлтнүүдэд мэдүүлсэн Бурханы мэргэн ухаан (Еф 3:10).
7. Бурхан Христийг аврагдсан ертөнцийн Тэргүүн болгоод чуулганыг Түүний сүйт бүсгүйн хувиар эл ертөнцийг Христтэй хамт захируулж, Христийн алдрыг үүрд хуваалцуулах зорилготой.

Колоссай 1:27 дээр “Харийнхан дунд энэхүү нууц” гэснийг “та нарт буй алдрын найдвар болох Христ” гэж тодорхойлсон. Энэ нь “чуулганы нууц” гэдэгтэй ижил бөгөөд эдүгээ Христ нь итгэгч харь үндэстнүүд ба итгэгч иудейчүүдийн хувьд алдрын найдвар гэдгийг цохон тэмдэглэж байгаа юм. Аль аль нь одоо Христийн дотор Бурханы өмнө нэг л зогсох байр суурьтай гэдгийг хэлж байгаа юм.

Колоссай 2:2 дээр Бурханы энэ нууцыг “Христ” гэж хэлсэн. Энэ нь Христийн биеийг, тэргүүн нь болох Өөрийг нь, эрхтнүүд нь болох бүх итгэгчдийг хамруулаад хэлсэн ажээ.

Чуулганы нууцын тухай дурдсан өөр хэсгүүд гэвэл: Ефес 6:19, Колоссай 4:3. Чуулганы нууцыг Бичвэрийн илчлэлийн тулгийн чулуу гэж эл хэсгүүдэд илэрхийлсэн байна. Элч Паул энэхүү

үнэнийг дамжуулж өгөөд Бурханы үгийг биелүүлсэн (Кол 1:25). Энэ нь он цагийн дарааллаар бичигдсэн Библийн сүүлчийн хэсэг биш байсан ч маш чухал шинэ үнэн буюу оргил цэг нь байжээ.

Ёс бусын нууц 2Тесалоник 2:7-8

“Ёс бусын нууц”-ыг дурдсан цорын ганц хэсэг бол 2Тесалоник 2:7-8: “Ёс бусын нууц нь хэдийнээ ажиллаж байна. Гагцхүү эдүгээ хязгаарлан баригч дундаас нь зайлуулагдах хүртэл ажээ. Дараа нь хуульгүй нэгэн илчлэгдэнэ” гэж Паул хэлсэн байна. Чуулганы эхэн үеэс л ёс бусын сүнс ажиллаад эхэлчихсэн байлаа. Олон антихристүүд гарч ирсэн. Гэвч уг ёс бус байдал бүрэн оргилдоо хүрэхэд хязгаарлан баригч тээг болж байв. Тэр нь Ариун Сүнс. Ариун Сүнс зайлуулагдах үед буюу шүүрэлтээр итгэгчид дээш авагдаж, тэдний дотор оршигч Ариун Сүнс хамт одоход хуульгүй нэгэн болох антихрист түүхийн тавцанд гарч ирнэ. Тэрээр нүгэл хилэнц, ёс бусын амилсан дүр байх болно. Хүмүүний дотор ёс бус байдал нэг дор цугласан байхыг ертөнц өмнө харж байгаагүйгээрээ түүнээс харна.

Итгэлийн нууц 1Тимот 3:9

“Итгэлийн нууц” гэдэг нь христэч сургаалын нийлбэр, христитгэл юм. Энэ итгэлийн ихэнх нь Хуучин гэрээнд байхгүй, урьд өмнө нь илчлэгдээгүй учир нууц гэж нэрлэгддэг.

Итгэл сүсгийн (бурханлаг байдлын) нууц 1Тимот 3:16

Итгэл сүсгийн нууц агуу нь эргэлзээгүй. Махбодоор илчлэгдсэн Тэр Сүнс дотор зөвтгөгдсөн. Тэнгэрэлч нарт үзэгдсэн Тэр харийнханд ч тунхаглагдсан. Ертөнцөд итгэгдсэн Тэр сүр алдраар дээш авагдсан. (1Тм 3:16)

Бурханы Гурвалын нэг Бодгалийг энд тодорхойлсон байна. Энэ тодорхойлолт гагцхүү бидний Эзэн Есүс Христэд тохирдог. Христийг дэлхий дээр ирэх хүртэл төгс бурханлаг байдлыг хүний амьдралаас хэн ч хараагүй юм. Эзэн Есүс ирж байж л жинхэнэ бурханлаг хүн ямар байдгийг амьдрал дээр харуулжээ.

Паул: Бурханлаг байдлын нууц “агуу” (грекээр *мэга*) гэж хэлэхдээ тайлагдашгүй гүн гүнзгий гэсэн санаагаар бус, харин Христ гэж хэн болох тухай үнэн үнэхээр гайхамшигтай, биширмээр гэсэн утгаар хэлсэн юм.

Бурханлаг байдлын нууц нь ёс бусын нууцын эсрэг талд байдаг. Эхнийх нь бурханлаг хүн ямар байдгийн бодит жишээ. Хоёр дахь нь нүглийн амьд жишээ. Эхнийх нь Христ ба хоёр дахь нь антихрист.

Долоон одны нууц Илчлэл 1:20

Энэ нууцыг Библи өөрөө тодорхой хэлж өгсөн. Иоханы үзсэн үзэгдэл дэх долоон од бол Азийн долоон чуулганы тэнгэрэлчүүд (эсвэл зүгээр элч: ингэж орчуулах ч боломжтой). Долоон дэн нь

долоон чуулган. Дараагийн хоёр бүлэгт Эзэн уг долоон чуулганы тэнгэрэлч нарт захидал илгээсэн. Энэ захидлуудыг гурван янзаар ойлгох боломжтой. Үүнд:

1. Иоханы цаг үед байсан бодит долоон чуулганд бичсэн долоон захидал: Бараг бүгд энэ үзлийг хүлээн зөвшөөрдөг.
2. Долоон захидал нь аль ч цаг үед дэлхий дээр орших чуулгануудын янз бүрийн нөхцөл байдлыг дүрсэлсэн: Энэ үзэл ихэнх итгэгчдэд их тусалдаг.
3. Элч нарын өдрүүдээс эхлээд чуулганы үе дуусах хүртэлх чуулганы түүхийн долоон нөхцөл байдлыг цаг хугацааны дарааллаар бичсэн: Ихэнх хүн энэ үзлийг хүлээж авдаггүй. Гэхдээ түүх үзвэл чуулганы нөхцөл байдал яг л энэ долоон захидлын нөхцөл байдлын өгүүлсэн дарааллаар явсан нь анхаарууштай.

Бурханы нууц Илчлэл 10:7

Илчлэл 10-р бүлгийн долоо дахь бүрээг үлээхэд Бурханы нууц биелнэ. Долоо дахь бүрээний араас “Ертөнцийн хаанчлал нь бидний Эзэний болон Түүний Христийнх болсон. Тэр үеийн үед хаанчилна” (Илч 11:15) гэх чанга дуу тэнгэрт гарна. Эндээс харахад их гамшгийн төгсгөлд, Христ дэлхий дээр хаанчлахаар ирэхэд долоо дахь бүрээ дуугарах нь (Илч 11:17). Тэр цагт их гамшгийн үеийн Эзэний итгэмжит ариун

хүмүүс шагнуулж, Эзэний дайснууд устгагдана (18-р эшлэл).

Тэгээд Бурханы нууц биелнэ. Үргэлж ялж байсан муу бүхэн тэр цагт дарагдана. Хүний бузар мууг хүлцсэн Бурханы хүлцэл дуусна. У. А. Крисвэлл: “Хаанчлалыг гартаа авахыг, дэлхий дээр шударга ёс тогтоохыг Бурхан удаан хойшлуулсан нь тэгэхэд дуусна.” Ф. У. Грант: “Бурханы нууц үүрд төгсөнө. Бурханы алдар нар мэт цацарна. Итгэл бүрэн зөвтгөгдөж, эргэлзэгчдийн бувтнал үүрд амаа хамхиулна.”

Вавилоны нууц Илчлэл 17:5-7

Их Вавилоны тухай Илчлэл 17-р бүлэгт долоон толгойтой, арван эвэртэй араатан дээр суусан янхан эм гэж дүрсэлсэн байдаг. Түүнийг “*Дэлхийн янхнуудын ба жигшүүрт юмсын эх их Вавилон*” гэж нэрлэдэг аж. Энэ нууцыг 8-18 дугаар эшлэлд тайлбарласан. Янхан эм бол дэлхийг захирдаг их хот (18-р эшлэл). Араатан бол нэгэн цагт оршин байгаад, алга болж, ахин сэргэсэн, хожим нь устгагдах эзэнт гүрэн (8-р эшлэл). Долоон толгой бол тэр эзэнт гүрний долоон хаан (9-р эшлэл). Арван эвэр бол энэ эзэнт гүрэнтэй холбоотой болох арван хаан (12-р эшлэл). Янхан эм араатны нуруун дээр суух боловч араатнаар устгуулна (16-р эшлэл). Араатан буюу эзэнт гүрэн өөрөө Эзэнээр устгуулна (14-р эшлэл).

Энэ нууцыг бид ингэж тайлж байна: Эмэгтэй нь Ромд төвтэй шашин ба эдийн засгийн

тогтолцоо. Өөрөөр хэлбэл, асар их санхүүгийн эх үүсвэртэй дэлхийн сүм чуулган байна. Араатан нь ахин сэргэх Ромын эзэнт гүрэн. Энэ эзэнт гүрэн одоогийн Европын улс орнуудын газарзүйн хил хязгаартай адил газар нутаг бүхий арван хаанчлалын хэлбэртэй байна.

Сэргэсэн Ромын эзэнт гүрний удирдагч, түүнтэй холбоотой арван хаан дэлхийн сүмийг хэсэг хугацаанд дэмжиж байгаад дараа нь эл тогтолцооны эсрэг болж, түүнийг устгана. (Вавилон болон түүний мөхлийн тухай нэмэлт мэдээллийг 18-р бүлгээс уншаарай.)

Дүгнэлт

Шинэ гэрээнд нууцуудын тухай өөр дөрвөн эшлэл бий:

- 1Коринт 2:7 – Паул болон бусад элч нар “нууц дотор нуусан Бурханы мэргэн ухааныг” ярьдаг гэж энд бичжээ. Тэгээд араас нь, өмнөх үеийнхнээс нууцлагдсан боловч эдүгээ Ариун Сүнсээр дамжуулан илчлэгдсэн үнэнийг хэлж буйг тайлбарласан.
- 1Коринт 4:1 – Паул болон бусад элч нар “Бурханы нууцын нярвууд” байлаа. Энд ч мөн адил нууц гэдгийг христитгэлийн эрин үед илчлэгдсэн бүх шинэ үнэнүүдийг дэлгэн тавих гэсэнтэй холбожээ.

- 1Коринт 13:2 – Бүх нууцууд, бүх мэдлэгийг мэдлээ ч хангалтгүй. Хайр байхгүй бол бид юу ч биш.
- 1Коринт 14:2 – Хэн нэгэн хүн орчуулагчгүйгээр гадаад хэлээр яривал, хамгийн гүн нууцуудыг ярьж байлаа ч сонсож буй хүмүүстээ ямар ч ашиг өгөхгүй гэж Паул учирласан.

ХОРИН ЗУРГАА **ХРИСТИЙН АЛДАР (ЦОГ** **ЖАВХЛАН)**

Бид Христийн алдар гэж ярихдаа Христийн хэн болох, ямар байр суурьтай, эсвэл ямар ажил гүйцэтгэсэнтэй нь холбож, хэнтэй ч зүйрлэмгүй агуу байдлыг нь хэлдэг. Христийн алдар гэхээр, Бурханы үгнээс итгэлээр дамжуулан сүнслэгээр олж хардаг Христийн төгс төгөлдөр байдал байж болно. Мөн одоо тэнгэрт байхдаа эсвэл газар дэлхий дээр хаадын Хаан, эздийн Эзэн болж ирэхдээ биетээр бодитоор харагдах алдрыг нь хэлж байж болно.

Эзэн Есүсийн алдруудыг тоолох боломжгүй. Бүгдийг нь хүний хэлээр илэрхийлэхэд үгийн сан нь дутна. Гэсэн ч, энэ бүлэгтээ бид ариун Бичвэрээс олдож байгаа Христийн долоон алдрын ялгаа салгааг гаргаж тавихыг зорилоо.

Бурханы Хүүгийн хувьд Өөрийнх нь анхны алдар

Христ бол Бурхан. Тиймээс Бурханд байдаг бүх агуу байдал, төгс төгөлдөр чанар, алдар Түүнд оршдог. Энэ алдар нь мөнхийнх бөгөөд анхных нь. Энэ алдар бол Бурханы цог жавхлангийн гэгээ мөнөөс мөн (Евр 1:3). Эзэн Есүс Өөрөөсөө энэ алдрыг хоосолж чадахгүй эсвэл энэ алдраасаа түр салах боломжгүй. Мөн чанарынх нь салшгүй хэсэг учраас тэр. Үүнд нь Түүний бүх гайхамшигт чанарууд, эрхэмсэг

байдал, сайн сайхан нь багтдаг. Эзэн Есүс дэлхийд ирэхдээ *махан биед энэ алдраа далдалсан*. Тэрнээс биш, алдар нь Түүнээс авагдсан юм биш. Нэгэн удаа уулан дээр энэ алдар нь Түүнээс цацарсан байдаг (Мт 17:1-8; Мк 9:1-8; Лк 9:28-36)

Христийн тэнгэр дэх байр суурийн алдар

Бүхий л мөнхөөс Эзэн Есүс аугаа их хүндлэл ба дээд байр сууринд байсан билээ. Тэрээр Эцэгийнхээ өдөр бүрийн баяр баясал байж, тэнгэрэлч нарын мөргөл хүндлэлийг авч байсан. Гэхдээ хүн төрөлхтний авралын асуудал яригдахад байр сууриа ямар ч үнээр хамаагүй хадгалах ёстой гэж үзээгүй. Харин байр суурийнхаа алдрыг Өөрөөсөө *хоосолж* (Флп 2:7а, шууд үгчилсэн орчуулга нь), боолын дүрийг авч, хүнтэй адил болсон. Чарльз Уэсли нэгэнтээ: “Хүнийг ахиж бүү үхлийг үзээсэй гэсэндээ Аврагч минь алдраа хойш тавьжээ” гэсэн нь энэхүү байр суурийн алдрыг ярьсан юм.

Аврагч Өөрийгөө хоосолсон гэж ярьж байвал, *Бурхан болохын* хувьд байдаг алдрыг нь бус, *байр суурийн* алдрыг нь ярьж байдгийг мартаж болохгүй. Хаан хүн ордноо орхиод ширэнгэ рүү явж болох ч, хэн гэдгээ орхих боломжгүй юм.

Аврагч маань Иохан 17:5 дээр: “Аав аа, ертөнцөөс өмнө Тантай хамт Надад байсан сүр жавхлангаар одоо Та Намайг Өөрийнхөө хамт алдаршуулаач” гэж залбирсан. Тэрээр, Эцэгтэй хамт байхдаа эзэмшиж байсан, дэлхийд ирэхдээ

түр хойш тавьсан байр суурийнх нь алдрыг сэргээж өгөхийн төлөө залбирсан гэсэн үг.

Хүний Хүүгийн хувьд дэлхий дээрх амьдралынх нь алдар

Эзэн Есүс дэлхий дээр хүн болж амьдрахдаа үйлдсэн гайхамшгуудаараа цог жавхлантай байлаа. Тийм болохоор “Есүс тэмдгүүдийнхээ эхлэлийг Галилын Канаад үйлдэж алдраа илчилсэн” (Иох 2:11) гэж бичигджээ. Мөн зан чанарын төгс байдлаараа цог жавхлантай байлаа. Тэрээр нүглийг үл мэдэгч бөгөөд нэг ч нүгэл үйлдээгүй. Түүний дотор нүгэл байгаагүй юм (2Ко 5:21; 1Пт 2:22; 1Ио 3:5). Мөн Тэрээр ёс суртахууны хувьд төгс байсан. Хувийн хүсэл гэж Түүнд байгаагүй. Зөвхөн Эцэгийнхээ хийлгэхээр өгснийг л хийж (Иох 5:19)¹⁵, Эцэгийнхээ ярь гэснийг л ярьж байлаа (Иох 13:50; 17:8). Пилат Түүнээс ямар ч буруу олоогүйгээ хүлээн зөвшөөрсөн (Лк 23:14, 22; Иох 18:38; 19:4, 6). Херод Түүнийг үхэх ял авах юу ч хийгээгүй юм байна гэж үзсэн (Лк 23:15). Нас барж байсан гэмт хэрэгтэн Түүнийг ямар ч буруугүй гэж гэрчилсэн (Лк 23:41). Иудас хүртэл “Би гэмгүй цуснаас урвалаа” гэж улайсан байдаг (Мт 27:4).

¹⁵Энэ нь “Есүс нүгэл үйлдсэн байж болох уу?” гэсэн асуултад хариулдаг. Тэр зөвхөн Эцэгээсээ харсан зүйлээ л хийж байсан бөгөөд үргэлж Эцэгт таалагдах зүйлсийг хийдэг байсан (Иохан 8:29), энэ нь гэм нүгэл огт үйлдээгүйг харуулдаг.

Аврагч маань нүгэлгүй байдлаараа цог жавхлантай байгаад зогсохгүй, үг яриагаараа ч цог жавхлантай байв. Назарчууд Түүний амнаас гарах нигүүлслийн үгст гайхаж байв (Лк 4:22). Эзэнийг барих гэж очсон харуулууд “Хүн хэзээ ч үүн шиг ярьж байсангүй” (Иох 7:46) гэж хүлээн зөвшөөрцгөөсөн. Эзэн маань төгс байснаараа цог жавхлантай байсан юм. Энэ бол Эзэн Есүс Христийн маань хүн ахуйн алдар юм.

Христийн олж авсан алдар

Эзэн маань тэнгэртээ үлдсэн бол хэзээ ч бидний Аврагч болохгүй байлаа. Загалмайг сонгож, үхлээс амилснаараа Тэр *бидний төгс Аврагч* болжээ. Энэ тухайд ингэж бичигджээ:

Олон хөвгүүдийг цог жавхланд авчрахдаа тэдний авралын Эхлүүлэгчийг зовлонгоор төгс болгох нь Түүнд зохистой байжээ. Бүх юмс Түүний төлөө бөгөөд Түүгээр бүх юмс байдаг. (Евр 2:10)

Тэр төгс болгогдсоноороо Өөрт нь дуулгавартай байдаг бүхэнд мөнх авралын эх үндэс нь болсон. (Евр 5:9)

Эзэн, *Бурхан болохынхоо хувьд* төгс болно гэж байхгүй. Энэ талаас яривал Тэр угаасаа төгс. Харин бидний төгс *Аврагч* болно гэж яривал боломжтой бөгөөд үнэхээр ч тэгсэн билээ.

Эзэн маань Голгота дээрх үхлийнхээ тухай урьдчилан ярихдаа, олж авах алдрынхаа талаар дурджээ:

Хүний Хуугийн алдарших цаг ирлээ. (Иох 12:23б)

Эзэн Есүс бидний төгс Аврагч болж алдрыг олж авснаас гадна, хүн болж төрөхдөө, бас тахил болохдоо алдар хүндлэлийг олж авсан. Есүс хүн болоогүй бол хэзээ ч Мессиа болж чадахгүй. Учир нь Мессиа Давидын удам байх ёстой. Есүс загалмайд тахил болоогүй бол хэзээ ч бидний Өмгөөлөгч, Зууч, Зуучлан залбирагч, Золигч, сайн Хоньчин, бүгдийн Өвлөгч, Шүүгч, чуулганы Тэргүүн болохгүй байлаа. Хэзээ ч бүх нэрээс дээгүүр нэрийг, үхэгсдээс анх төрсөн нь болохгүй байлаа. Энэ бүх цолууд Түүний хүн болж мэндэлсэн, үхээд, оршуулагдсан, үхэгсдээс амилснаас үүдэлтэй, олж авсан алдрууд юм.

Тэрээр нэгэн удаа олж авсан алдрынхаа тухайд Иохан 17:10 дээр ингэж хэлжээ:

Миний бүх юм Таных, Таных бас Минийх. Би тэднээр алдаршуулагдлаа.

Ариун хүмүүсээрээ алдаршсан нь Голгота дээрх ажлаар л зөвхөн боломжтой болсон гэдгийг дээрх үг харуулж байна.

Элч Паул, 2Тесалоник 1:10 дээр үүнийг Эзэний хоёр дахь ирэлттэй холбон ярьсан:

Энэ нь тэрхүү өдөр ариун хүмүүсийнхээ дунд алдаршихаар мөн бүх итгэгчдэдээ гайхагдахаар Түүнийг ирэхэд болно.

Христийн амилал ба тэнгэр өөд одолтын алдар

Иохан 17:1 дээр Эцэгт залбирахдаа Эзэн Голготын үйл явдал болчихсон байгаагаар, цаг нь ирчихлээ гэж ярьсан. Ингэхдээ “Хүү нь Таныг алдаршуулахын тулд Хүүгээ алдаршуулаач” гэж залбирсан. Өөрөөр хэлбэл, Та Намайг үхлээс амилуулбал, Би Таныг алдаршуулж чадна гэсэн утгаар.

Үүнтэй ижил утгатай хэсэг Иохан 13:31-32:

31 Иудасыг гарсны дараа Есүс “Одоо Хүний Хүү алдаршлаа. Бурхан Түүгээр алдаршлаа. 32 [Хэрэв Бурхан Түүгээр алдаршсан бол] Бурхан Өөрийнхөө дотор Түүнийг бас алдаршуулна. Даруй Түүнийг алдаршуулна...” гэлээ.

Эзэн Өөрийнхөө үхлийг Өөрийгөө алдаршуулах, эргээд Эцэгт алдрыг авчрах зам гэж ярьж байна. Гучин хоёрдугаар эшлэлийг арай өөр үгээр хэлбэл: “Бурхан загалмай дээр Христийн ажлаар алдаршсан болохоор Бурхан Түүнийг алдаршуулна. Өөрөөр хэлбэл үхлээс амилуулна. Түүнийг даруй хийнэ.” Үнэхээр энэ ёсоор болсон. Бурхан Түүнийг гурав дахь өдөрт нь амилуулсан.

Түүний амилал ба тэнгэр өөд одолтын алдрын талаар өгүүлсэн эшлэлүүд:

Христ энэ бүх зовлонг эдлэн, тэгээд Өөрийн сүр жавхланд орох ёстой байсан биш үү? (Лк 24:26)

*Есүст итгэгсдийн хүлээн авах Сүнсний тухай
Тэр үүнийг хэлжээ. Есүс хараахан
алдаршуулагдаагүй тул Сүнс тэнд өгөгдөөгүй
байлаа. (Иох 7:39)*

*Шавь нар нь үүнийг анхандаа ойлгоогүй
ажээ. Харин Есүсийг алдарших үед энэ нь
Түүний тухай бичигдсэн байсныг мөн хүмүүс
Түүнд эдгээрийг үйлдсэнийг санажээ. (Иох
12:16)*

*Абрахамын [Бурхан], Исаакийн [Бурхан],
Иаковын Бурхан, бидний эцэг өвгөдийн Бурхан
Өөрийн үйлчлэгч Есүсийг алдаршуулжээ.
Түүнийг та нар барьж өгсөн. Харин Пилат
Түүнийг чөлөөлөхөөр шийдсэн байхад та нар
түүний өмнө үгүйсгэсэн шүү дээ. (Үйл 3:13)*

*Ертөнцөд итгэгдсэн Тэр сүр алдраар дээш
авагдсан. (1Тм 3:16)*

*Та нар Түүгээр дамжин Бурханд итгэсэн юм.
Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулж, Түүнд
алдрыг өгчээ. Ингэснээр итгэл хийгээд найдвар
чинь Бурханд байх юм. (1Пт 1:21)*

Түүний амилал ба тэнгэр өөд одолтын алдар
нь тэнгэртэй мөнхийн алдартай нь нийлсэн.
Тэдгээр нь салшгүй.

Христийн хоёр дахь ирэлт, хаанчлалын алдар

Шинэ гэрээнд Христийн хоёр дахь ирэлт ба хаанчлалын алдрыг хамгийн олон өгүүлсэн байдаг. Хүний Хүүгийн тэмдэг тэнгэрт илэрхийлэгдэхэд газрын бүх овог гашуудан уйлж, Хүний Хүүг тэнгэрийн үүлэн дунд аугаа сүр хүч, цог жавхлантайгаар залрахыг харна (Мт 24:30). Тэрхүү өдөр Тэрээр ариун хүмүүсийнхээ дунд алдаршиж, мөн бүх итгэгчдэдээ гайхагдах болно (2Тс 1:10). Тэрээр цог жавхлант сэнтийдээ заларч, элч нараа болон Өөрийнхөө дагалдагч нарыг шагнаж (Мт 19:28), үндэстнүүдийг шүүнэ (Мт 25:31-33). Тийнхүү цог жавхлангаа мандуулах үедээ, Өөрөөс нь болон Үгээс нь ичсэн хүмүүсээс ичих болно (Лк 9:26) Иаков, Иохан хоёр Христийг хаанчлалын алдраа мандуулан ирэхэд баруун зүүн талд нь сууя гэж болчимгүй юм гуйсан нь бий (Мк 10:37). Одоо Христийн зовлонгуудаас хуваалцагчид хожим мянган жилийн хаанчлалд Христ алдраа илчлэх цагт асар их баяр хөөрийг амсана (1Пт 4:13).

Уулан дээр Есүсийн дүр хувирсан нь тэр алдарт эрин үеийн урьдчилсан үзэгдэл байлаа. Мессиа хаадын Хаан, эздийн Эзэн болж ирэхдээ ямар байхыг, агуу цог жавхланг нь Петр, Иаков, Иохан нар уулан дээр харсан:

Бид Түүний алдар сууг үзсэн. Энэ нь Эцэгээс цор ганц Төрөгчийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн юм. (Иох 1:14)

Нойрондоо дийлдээд байсан Петр болон нөхөд нь бүрэн сэргэхдээ Түүний цог жавхланг, Түүнтэй хамт зогсох хоёр хүнийг ч бас харав. (Лк 9:32)

Петр уулан дээр үзсэнээ хожим дурсахдаа, Эзэн Есүс Христийнхээ хүч чадал ба Түүний ирэх тухай хэмээн тайлбарласан байдаг (2Пт 1:16).

Христ хаанчлалын цог жавхлангийнхаа талаар дурдсан бас нэгэн хэсэг бол Иохан 17:22. Бидний агуу Тэргүүн Тахилч тэнд ингэж хэлжээ:

Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд Надад өгсөн сүүр жавхланг тань Би тэдэнд өгсөн билээ.

Нэг талаас яривал, бид одоо ч Түүний цог жавхлан, алдрыг хуваалцдаг. Бурханы хөвгүүд, Түүний ахан дүүс, биеийнх нь эрхтнүүд, хамтран өв залгамжлагч гэх мэтээр алдраас нь хуваалцаж байна.

Гэхдээ дээр дурдсан цог жавхлан бол эд бүгдээс өөр. Мянган жил дэлхий дээр хаанчлахад нь бидэнтэй хуваалцах алдрынхаа тухай Эзэн ярьсан нь энэ (Илч 20:4). Түүнийг алдар, цог жавхлантай үзэгдэхэд бид бас Түүн шиг цог жавхлантай үзэгдэнэ.

Одоо энэ ертөнц Бурханы хүмүүсийг таньдаг ч үгүй, тоодог ч үгүй.

Биднийг ертөнц таньдаггүй нь Түүнийг таниагүйн учир юм. (1Ио 3:1)

Харин Христ алдраа мандуулж, цог жавхлантайгаар үзэгдэхэд итгэгчид ч цог жавхлантай үзэгдэнэ:

Бидний амь болох Христ илчлэгдэх үед та нар ч бас яруу алдар дотор Түүнтэй илчлэгдэх болно. (Кол 3:4)

Хайртууд минь, бид одоо Бурханы хүүхдүүд. Бидний ямар болох нь хараахан илчлэгдээгүй. Түүнийг илчлэгдэхэд бид Түүнтэй адил болно гэдгийг мэднэ. Учир нь бид Түүнийг байгаагаар нь харах болно. (1Ио 3:2)

Тэр цагт Эзэн Есүс ба Түүний дагалдагчдын нэгдмэл байдлыг энэ ертөнц харна. Эцэг Хүүг илгээснийг, Бурхан ариун хүмүүсийг Хүүгээ хайрладаг шиг хайрладгийг мэдэж авна.

Христийн одоогийн алдар – тэнгэрт

Иохан 17:24 дээр хэлсэнчлэн, Эзэн Есүс Өөрийг нь хайрладаг хүмүүстэй хамт тэнгэрт байж, тэд нь Түүний алдрыг хараасай гэж хүсдэг. Эзэн Есүс тэнгэрт алдар ба хүндэтгэлийн титэм зүүсэн байгааг бид итгэлээр хардаг:

Харин Бурханы нигүүлслээр хүн бүрийн төлөө үхлийг амсахын тулд тэнгэрэлч нараас арай дорд болгогдсон бөгөөд үхлийн зовлонгийн учир цог жавхлан хийгээд хүндэтгэлийн титэм өмссөн Есүсийг бид хардаг. (Евр 2:9)

Түүний мөнх алдар гэж Петр хэлсэн нь тэнгэр дэх Түүний одоогийн алдар мөн:

Христ дотор та нарыг Өөрийн мөнх алдарт дуудсан, бүх нигүүлслийн Бурхан Өөрөө, түр зуур зовсны чинь дараа та нарыг төгс болгож, бататгаж, бэхжүүлэн байгуулах болно (1Пт 5:10).

Гэхдээ энэ алдар нь дэлхийд ирэхийн өмнөх алдраас нь нэг зүйлээр өөр болсон. Өмнө нь тэр цог жавхлант Бурхан байсан бол, одоо Тэр түүн дээрээ нэмээд *цог жавхлант Хүн* хэмээх алдрыг нэмсэн байгаа.

Тэнгэр дэх одоогийн алдар нь анхных ба олж авсан бүгдийг нь нийлүүлсэн алдар. Бурхан болох алдар, Хүн болох алдар, агуу байдлын алдар, байр суурийн алдар, зан чанарын алдар бүгд одоо Түүнд бий. Бид тэдгээрийг нь хуваалцахгүй боловч, тэдгээрт нь баярлаж, үүрдийн аугаа алдар суу, цог жавхлангуудынх нь төлөө Түүнийг магтаж чадна.

ХОРИН ДОЛОО САЙНМЭДЭЭНИЙ НОМУУДЫН ЯЛГАА

Сайнмэдээний номуудыг судалсан хэн бүхэн адил төстэй байдлыг нь амархан анзаардаг. Ялангуяа Матай, Марк, Лук хоорондоо тун төстэй. Ижил гайхамшгууд, ижил сургаалт зүйрлэлүүд, ижил номлолууд. Гэвч шаардлагагүй зүйлсийг давтаж бичнэ гэж үгүй. Ариун Сүнс ямар ч шалтгаангүйгээр Өөрийгөө давтдаггүй.

Хэрэв нарийн анзаарвал, төстэй зүйлс нь биш, ялгаанууд нь гол чухал гэдгийг мэдэж болно. Ижил төстэй гэсэн хэсгүүд маань ялимгүй зөрүүнүүдтэй байдаг.

Библи судлалын олон ном сайнмэдээнүүдийн ижил зүйлсийг жагсааж бичдэг. Тэгээд голыг нь хардаггүй. Ижлүүд нь биш зөрүүнүүд нь, адилууд нь биш ялгаанууд нь бидэнд хэрэгтэй чухал сургамжийг агуулж байдаг ажгуу. Тэгэхээр энэ бүлгээр бид төстэй хэсгүүдийг харьцуулан үзэх болно.

Эзэн хүмүүст баптисм хүртээнэ гэж Баптисч Иохан зарласныг дөрвөн сайнмэдээ дөрвүүлээ тэмдэглэн үлдээсэн. Тэрээр дан итгэгчдэд ярихдаа “Тэр (Есүс) та нарт Ариун Сүнсээр баптисм хүртээнэ” (Мк 1:8; Иох 1:33) гэсэн бол, сонсогчдынх нь дунд үл итгэгч байх үед “Тэр та нарт Ариун Сүнс хийгээд галаар баптисм хүртээнэ” (Мт 3:11; Лк 3:16) гэж айлджээ.

Баптисч Иохан хоёр өөр баптисмын тухай ярьсан байна. Нэг нь ерөөлийн баптисм, нөгөө нь шүүлт шийтгэлийн баптисм.

Нэг биш, хоёр өөр номлол

Матай 5-7 дээрх сургаалыг уулан дээрх номлол гэдэг. Үүний зарим хэсэг Лук 6:17-49 дээр давтагдаж байх шиг харагддаг. Гэтэл энэ хоёр нь хоёр өөр газар, өөр өөр тохиолдолд номлосон номлолууд ажээ. Матай дээр номлолыг уулан дээр заасан бол, Лук дээр номлолыг тал газарт заажээ. Есүс шавь нартайгаа хамт уруудан бэлд буусан гэж Лук 6:17-д бичсэн байна. Матай дээр тэнгэрийн хаанчлалын иргэд ямар байдаг тухай стандарт маягийн зүйл ярьсан бол, Лук дээр сайнмэдээг тунхаглахаар яваа дагалдагч хүний амьдралын хэв маягийг өгүүлдэг. Матай дээр сүнс дотроо ядуу хүнийг ерөөлтэй гэж (5:3) мэдэгдсэн. Лук дээр харин Эзэн ядуусыг ерөөсөн (6:20). Матайн тэмдэглэлд “золгүй еэ” гэх хэсэг байхгүй. Лук дээр харин дөрөв бий. (Лк 6:4-26). Энэ ялгаануудыг юу ч бодолгүй хурдан өнгөрүүлж болохгүй, няхуур судлах хэрэгтэй.

Матай, Лук хоёр хоёулаа “Нүд бол биеийн дэнлүү” гэж Эзэний хэлснийг тэмдэглэжээ. Харин хам сэдвийг нь харгал, Матайнх мөнгөний хайр сүнслэг харааг бүрэлгэх тухай ярьж байна (6:22). Лукийнхт болохоор мөнгөний тухай юу ч алга (11:33-36). Лукийн тэмдэглэсэн хэсэгт Эзэний сургаалыг хүлээн авах сэтгэлтэй байж,

хүлээн авснаа бусдад хуваалцвал ерөөлтэй гэсэн санаа агуулагддаг. Гурван сайнмэдээнд “Өөрсдийнхөө хэмжсэн хэмжээсээр та нар хариуд нь хэмжигдэх болно” гэсэн үг гардаг. Матай 7:2 бусдыг шүүх хандлагыг зэмлэж, Марк Бурханы үгийг өөрсдөдөө шингээж авахыг уриалж (4:24), Лук дээр Бурханы хүмүүст өгөөмөр хандлагыг урамшуулж (6:38) хэлжээ.

Матай 10:24-т Эзэн Есүс “Шавь нь багшийнхаа, боол нь эзнийхээ дээр байдаггүй” гэж хэлсэн. Лук 6:40 дээр “Шавь нь багшийнхаа дээр байдаггүй” гэж айлдсан. Харахад хоорондоо төстэй, нэг л юмны тухай ярьсан юм шиг. Гэвч огт өөр утгатай. Матай дээрх нь: Шавь нь багшаасаа бага хавчлага амсана гэж бодох хэрэггүй гэсэн утгатай бол, Лукийнх нь: Итгэгч хүн өөрийнхөө сүнслэг түвшнээс илүү гарсан шавь бэлдэж чадахгүй гэсэн утгатай ажээ.

Ерэн ес

Ерэн есөн хонины сургаалт зүйрлэл ч мөн төстэй харагддаг. Матай 18:12-13 энэ сургаалт зүйрлэл хүүхдүүдийг гэсэн Эзэний хайрыг харуулдаг (14-р эшлэл). Лук 15:4-7 дээр болохоор, гэмших хэрэгцээгээ хүлээн зөвшөөрдөггүй фарисайчууд болон хуулийн багш нарт хандаж энэ сургаалт зүйрлэлийг ярьсан (2 ба 7-р эшлэл).

Талантын тухай сургаалт зүйрлэлийг (Мт 25:14-30) маанэгийн тухай сургаалт зүйрлэлтэй (Лк 19:12-27) бүү андуураарай. Талантын

зүйрлэлд гурван хүн ур чадварынхаа хэмжээгээр мөнгө авсан. Эхний хоёр нь мөнгөөрөө өөр өөр үр дүн гаргасан ч, итгэмжтэй байлаа гэж адил сайшаал хүртсэн. Гурав дахь хүн авсан талантаараа юу ч хийгээгүй хэмээн яллуулсан.

Маанэгийн зүйрлэлд гурван хүн ижил мөнгө хүлээн авсан. Бүгдэд нь ижил боломж олгосон. Авсан мөнгөө эхнийх нь арав дахин, хоёр дахь нь тав дахин нугалж ашиг гаргасан. Гурав дахь нь ямар ч ашиг гаргаагүй. Эхний хоёрт өгсөн шагнал хэр их ашиг хийснийх нь дагуу өгөгдсөн. Гурав дахь нь анх авсан мөнгөө алдсан.

Хэдэн удаа үгүйсгэв?

Петр Эзэнийг зургаан удаа үгүйсгэсэн байх боломжтой юу? Сайнмэдээний номуудыг няхуур судлаад үзэхээр (1) нэгэн шивэгчин (Мт 26:69-70; Мк 14:66-68); (2) өөр нэг шивэгчин (Мт 26:71-72; Мк 14:69-70); (3) хамт зогсож байсан хүмүүс (Мт 26:73-74; Мк 14:70-71); (4) нэг эрэгтэй хүн (Лк 22:58); (5) өөр нэг эрэгтэй хүн (Лк 22:59-60); (6) тэргүүн тахилчийн зарц (Иох 18:26-27) гээд зургаан өөр хүний өмнө Петр Эзэнийг үгүйсгэсэн гэж харагддаг. Зургаа дахь хүн бусдаасаа ялгаатай. Яагаад гэвэл хэлсэн үг нь өөр: “Чамайг Түүнтэй хамт цэцэрлэгт байхыг чинь би хараагүй бил үү?”

Сайнмэдээ болгоны төгсгөлд Эзэн шавь нартаа захирамж өгсөн байдаг ч хоорондоо бас л ялгаатай:

Матай – дагалдагч болго, номло, заа (28:19)

Марк – сайнмэдээг тунхагла (16:15)

Лук – гэрчил (24:48)

Иохан – Намайг дага (21:19-22)¹⁶

Тэгэхээр, сайнмэдээний номуудад давтагдсан гэж харагдаж байгаа хэсгүүд үнэндээ тийм биш байдаг аж. Юу нь адил байна гэхийн оронд, ялгаануудыг нь нягтлан судалбал гүн сүнслэг үнэнийг олох болно. Тэгээд зогсохгүй, хоорондоо зөрчилтэй мэт хэсгүүдийн учрыг ойлгож аваад, Бурханы амьсгалаар бичигдсэн ариун номын гайхамшгийг цоо шинээр мэдэж авна.

¹⁶*Петрт хэлсэн үг боловч бүх итгэгчдэд хамаатай.*

